

Оюу Толгой компанийн Бараа бүтээгдэхүүн (болон Холбогдох Үйлчилгээ)-ний

Ерөнхий Нөхцөл

ГАРЧИГ

1. **Нэр томъёоны тодорхойлолт, тайлбар**
  - 1.1 Нэр томъёоны тодорхойлолт
  - 1.2 Тайлбар
2. **Гэрээний нотлох баримт, баримт бичгийг давууд үзэх дараалал**
  - 2.1 Гэрээ
  - 2.2 Гэрээний баримт бичгийг давууд үзэх дараалал
  - 2.3 Гэрээний бүрэн бүтэн байдал
  - 2.4 Бичгээр нэмэлт өөрчлөлт оруулах
3. **Нийлүүлэгчийн мэдэгдэл**
4. **Нийлүүлэгчийн хяналт шалгалт**
  - 4.1 Гэрээтэй холбоотой хяналт шалгалт
  - 4.2 Компаниас баталгаа гаргахгүй байх
  - 4.3 Нийлүүлэгч нь үнэн зөв байдалд ханамжтай байх
  - 4.4 Үүргээс чөлөөлөхгүй байх
  - 4.5 Компани хариуцлага хүлээхгүй байх
5. **Нийлүүлэгчийн гэрээний гүйцэтгэл**
  - 5.1 Үйлчилгээ үзүүлэх
  - 5.2 Захиалах
  - 5.3 Үйлчилгээ
6. **Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах**
  - 6.1 Нэмэлт өөрчлөлт
  - 6.2 Нэмэлт өөрчлөлтийн улмаас гарах зардал
  - 6.3 Нэмэлт өөрчлөлт оруулах журам
7. **Нийлүүлэгчийн баталгаа**
  - 7.1 Нийлүүлэгчийн баталгаа
  - 7.2 Худалдааны баталгааны хуулбар хувь
  - 7.3 Аюултай бодисууд ба бусад хориглосон бодисууд
  - 7.4 Нийлүүлэгчийн нөхөн төлбөр
8. **Доголдол, зөрчил дутагдлыг арилгах**
  - 8.1 Баталгаа
  - 8.2 Баталгаат хугацаа эхлэх
  - 8.3 Доголдол, зөрчил дутагдлыг арилгах
  - 8.4 Доголдолтой үйлчилгээг засах
  - 8.5 Доголдол, зөрчил, дутагдлыг арилгахгүй байх
9. **Нийлүүлэлтийн хугацааны хуваарь**
  - 9.1 Нийлүүлэлтийн хугацааны хуваарийг мөрдөх
  - 9.2 Нийлүүлэлтийн хугацааны хуваарьт нэмэлт өөрчлөлт оруулах
10. **Гэрээний хугацаа**
11. **Төлөөлөгч**
  - 11.1 Гэрээний гүйцэтгэл
  - 11.2 Компанийн төлөөлөгч
  - 11.3 Нийлүүлэгчийн төлөөлөгч
12. **Хүргэлт, Өмчлөх эрх, Эрсдэл**
  - 12.1 Хүргэлт
  - 12.2 Өмчлөх эрх
  - 12.3 Эрсдэл
13. **Гэрээний үнэ**
  - 13.1 Гэрээний үнэ
  - 13.2 Гэрээний үнэд багтах зардал
  - 13.3 Хүлэмжийн хийн ялгаруулалт
14. **Татвар**
  - 14.1 Татвар, Шууд бус гүйлгээний татвар, Орлогын албан татвар
  - 14.2 Компанийн гаалийн татвар
15. **Нийлүүлэгчид төлөх төлбөр**
  - 15.1 Төлбөрийн хэлбэр
  - 15.2 Татварын нэхэмжлэх
  - 15.3 Татварын нэхэмжлэхийн төлөлт
  - 15.4 Маргаан бүхий татварын нэхэмжлэх
  - 15.5 Нэхэмжлэхийн алдаа ба онцгой нөхцөл
16. **Цахим худалдаа**
  - 16.1 Нийлүүлэгчийн цахим худалдааны талаар хүлээх үүрэг
  - 16.2 Цахим худалдааны зардал
17. **Төлбөрийн суутгал**
  - 17.1 Суутгал тооцох
  - 17.2 Хуулийн дагуу суутгал, хасалт тооцох
  - 17.3 Суутгал, хасалт тооцох тухай мэдэгдэх
18. **Хувилбарт нийлүүлэлт**
  - 18.1 Хувилбарт нийлүүлэлт
  - 18.2 Нийлүүлэгч нэмэгдэл зардлыг хариуцах
19. **Нийлүүлэгчийн мэдээлэл, данс ба бүртгэл тооцоо**
  - 19.1 Мэдээллээр хангах
  - 19.2 Нийлүүлэгч данс, бүртгэл тооцоог хөтлөх
  - 19.3 Нийлүүлэгч мэдээлэл авах боломжоор хангах
20. **Компанийн аудит хийх эрх**
  - 20.1 Нийлүүлэгчийн гүйцэтгэлд аудит хийх эрх
  - 20.2 Нийлүүлэгчийн авах арга хэмжээ
21. **Гүйцэтгэлийн баталгаа**
  - 21.1 Баталгаа
  - 21.2 Нэмэлт баталгаа
  - 21.3 Тэмдэгтийн хураамж, бусад татвар
  - 21.4 Баталгаа гаргахаас өмнө төлбөр хийхгүй байх
  - 21.5 Баталгаа чөлөөлөх өдөр
  - 21.6 Баталгааг үргэлжлүүлэх
  - 21.7 Баталгааг буцаах
22. **Гуравдагч талын одоогийн нийлүүлэлтийг үргэлжлүүлэх**
23. **Худалдан авалтын доод хэмжээ байхгүй ба онцгой эрх олгохгүй байх**
  - 23.1 Худалдан авалтын доод хэмжээ байхгүй байх
  - 23.2 Онцгой эрх олгохгүй байх

- 24. Нийлүүлэгчийн ажиллах хүч, эд хөрөнгө, тоног төхөөрөмж**
- 24.1 Нийлүүлэгчийн ажиллах хүч
- 24.2 Ажиллах хүчний тохиролцоо
- 24.3 Нийлүүлэгчийн ажиллах хүчний талаархи мэдээлэл
- 24.4 Компани ажиллах хүчийг ажиллуулахаас татгалзах
- 24.5 Нийлүүлэгчийн хариуцлага
- 24.6 Компанийн барилга байгууламж
- 24.7 Зөрчил, дутагдалтай зүйлс
- 25. Сав баглаа боодол, ачилт, тээвэрлэлт**
- 25.1 Нийлүүлэгчийн хариуцлага
- 25.2 Тээвэрлэлтийг Компани хариуцах
- 25.3 Тээвэрлэлтийн бэлтгэл ажил
- 25.4 Тээвэрлэлт эхлэх өдрийг мэдэгдэх
- 26. Хяналт шалгалт**
- 26.1 Хяналт шалгалт
- 26.2 Мэдээллээр хангах үүрэг
- 26.3 Хяналт шалгалтын зардал
- 27. Туршилт хийх, ашиглалтад оруулах**
- 27.1 Туршилт
- 27.2 Туршилтын зардал
- 27.3 Туршилт хийх тухай мэдэгдэл
- 27.4 Хугацаа хоцорсон туршилт
- 27.5 Шалгалт, туршилтыг давтан хийх
- 27.6 Туршилт хийгээгүйн улмаас үүсэх үр дагавар
- 27.7 Туршилтын үр дүн
- 27.8 Ашиглалтад хүлээлгэн өгөх үе дэх Нийлүүлэгчийн хариуцлага
- 27.9 Ашиглалтад хүлээлгэн өгөх Нийлүүлэгчийн ажилтан
- 27.10 Тайлан
- 27.11 Ажиллуулж эхлэхийн өмнө мэдэгдэх
- 28. Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин**
- 28.1 Заалтын хэрэглээ
- 28.2 Нийлүүлэгч баталгаа гаргах
- 28.3 Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба байгаль орчны тухай хууль тогтоомж, бодлого шийдвэр, холбогдох стандартыг дагаж мөрдөх
- 28.4 Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны удирдлагын төлөвлөгөө
- 28.5 Удиртгал сургалт
- 28.6 Нийлүүлэгчийн хариуцлага
- 28.7 Заалт зөрчсөнөөс үүсэх үр дагавар
- 29. Сайтад нэвтрэн орох**
- 29.1 Нэвтрэх эрх
- 29.2 Нийлүүлэгчийн үүрэг
- 29.3 Нэвтрэх эрхийг хугацаа хоцорч олгох эсхүл хойшлуулах
- 29.4 Нэвтрэх эрх олгохоос татгалзах эрх
- 29.5 Эзэмших онцгой эрх байхгүй байх
- 30. Компанийн бодлогыг мөрдөх**
- 30.1 Компанийн ерөнхий бодлого
- 30.2 Бидний ажлын арга барил
- 31. Хууль**
- 31.1 Хууль тогтоомжид нийцүүлэх
- 31.2 Эрүүл мэндийн үзлэг
- 31.3 Хууль зөрчсөнөөс үүсэх үр дагавар
- 32. Гуравдагч талтай хамтран ажиллах**
- 32.1 Хөндлөнгөөс үл оролцох
- 32.2 Нөхөн төлбөр олгохгүй байх
- 32.3 Нийлүүлэлтийн хугацааны хуваарьт өөрчлөлт оруулах
- 33. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал**
- 33.1 Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэнийг мэдэгдэх
- 33.2 Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдэл
- 33.3 Хохирлыг арилгах, засварлах үүрэг
- 33.4 Нөхөн төлбөр олгохгүй байх
- 34. Даатгал**
- 34.1 Нийлүүлэгчийн даатгалууд
- 34.2 Ерөнхий болон бүтээгдэхүүний хариуцлагын даатгал
- 34.3 Ажилчдын нөхөн олговор болон ажил олгогчийн хариуцлагын даатгал
- 34.4 Тээврийн хэрэгслийн хариуцлагын даатгал
- 34.5 Мэргэжлийн хариуцлага (алдаа, дутагдал)-ын болон мэргэжлийн баталгаа гаргах даатгал
- 34.6 Нийлүүлэгчийн үйлдвэрийн газар, тоног төхөөрөмж
- 34.7 Тээвэрлэлтэнд яваа бараа
- 34.8 Аюултай бодис (аюултай бодис тээвэрлэлт)-ын даатгал
- 34.9 Нислэгийн даатгал
- 34.10 Нэмэлт хариуцлагын (Шүхрэн) даатгал
- 34.11 Даатгалд хамрагдах нөхцөл
- 34.12 Нийлүүлэгчийн мэдэгдэл
- 34.13 Туслан гүйцэтгэгчийн даатгал
- 34.14 Нийлүүлэгч даатгуулаагүйбайх
- 34.15 Даатгалын нэхэмжлэх, даатгалаас хэтэрсэн төлбөр
- 34.16 Нөхөн төлбөрт үл нөлөөлөх Нийлүүлэгчийн даатгал
- 35. Нөхөн төлбөр**
- 35.1 Хүлээн зөвшөөрөх
- 35.2 Нөхөн төлбөр
- 35.3 Нөхөн төлбөр үл тооцогдох нөхцөл
- 36. Үр дагавар бүхий хохиролд үл тооцох**
- 37. Хохирол барагдуулах, алданги**
- 37.1 Хохирол барагдуулах, алданги
- 37.2 Компани буруутай үед алданги төлөхгүй байх
- 37.3 Хүлээн зөвшөөрөх
- 37.4 Шаардсаны дагуу төлөх алданги
- 38. Гэрээг цуцлах үед зөрчил үл гаргах**
- 38.1 Гэрээ цуцлах мэдэгдэл
- 38.2 Гэрээ цуцлах мэдэгдэлийг хүлээн авмагц хүлээх үүрэг
- 38.3 Гэрээг цуцлах үед хүлээх үүрэг
- 38.4 Нийлүүлэгчид нөхөн олговор олгох
- 39. Нийлүүлэгч гэрээний үүргээ зөрчих, төлбөрийн чадваргүй байх**
- 39.1 Нийлүүлэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай мэдэгдэл
- 39.2 Нийлүүлэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай мэдэгдэлд тавигдах шаардлага

- 39.3 Гэрээг цуцлах үед хүлээх үүрэг
- 39.4 Хохиролгүй болгох
- 39.5 Нийлүүлэгчийн төлбөрийн чадваргүй байдал ба дампуурал
- 40. Компани гэрээний үүргээ зөрчих**
  - 40.1 Компани гэрээний үүргээ зөрчих
  - 40.2 Компани гэрээний үүргээ зөрчсөн тухай мэдэгдэл
  - 40.3 Компани гэрээний үүргээ зөрчсөн тухай мэдэгдэлд тавигдах шаардлага
  - 40.4 Нийлүүлэгчид нөхөн төлж болох зардлууд
  - 40.5 Нийлүүлэгчийн бүртгэл тооцооны талаар мэдээлэл авах компанийн эрх
- 41. Маргаан шийдвэрлэх**
  - 41.1 Маргаан
  - 41.2 Талуудын маргаан шийдвэрлэх төлөөлөгчид
  - 41.3 Маргаан үүссэн үе дэх гэрээний үүргийн гүйцэтгэл
  - 41.4 Яаралтай үед түр зуурын арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- 42. Нууцлал**
  - 42.1 Нууцлалыг хангах үүрэг
  - 42.2 Онцгой тохиолдол
  - 42.3 Нийлүүлэгч хүлээн зөвшөөрөх
  - 42.4 Нөхөн төлбөр
  - 42.5 Нэмэлт үүрэг
  - 42.6 Нууц мэдээллийг буцаах
- 43. Нийтэд зарлан мэдээлэх**
- 44. Нийлүүлэлт хийхтэй холбоотой оюуны өмчийн эрх**
  - 44.1 Нийлүүлэгчийн оюуны өмч
  - 44.2 Гэрээний дагуу оюуны өмч шилжих
  - 44.3 Нийлүүлэгчийн оюуны өмчийг ашиглах эрхийг зарим этгээдэд зөвшөөрөх
  - 44.4 Рио Тинтогийн оюуны өмч
  - 44.5 Нийлүүлэгчийн баталгаа
  - 44.6 Нийлүүлэгчийн хүлээх ерөнхий үүрэг
- 45. Гуравдагч талын оюуны өмчийн эрх**
  - 45.1 Гуравдагч талын оюуны өмчийн эрх
  - 45.2 Нөхөн төлбөр
  - 45.3 Оюуны өмчийн эрхийг худалдан авах
  - 45.4 Оюуны өмчийн эрхийг худалдан авах боломжгүй үед мөрдөжжурал
  - 45.5 Ёс суртахууны эрх
- 46. Мэдэгдэл**
  - 46.1 Мэдэгдлийн хэлбэр
  - 46.2 Мэдэгдлийг хүлээн авсан гэж үзэх
- 47. Сонирхлын зөрчил**
  - 47.1 Нийлүүлэгчийн баталгаа
  - 47.2 Сонирхлын зөрчил
  - 47.3 Нөхөн олговор
- 48. Бизнесийн стандарт**
  - 48.1 Авлигын эсрэг
  - 48.2 Албан тушаалтанд шударга бусаар давуу байдал, ашиг орлого бий болох
  - 48.3 Ашиг сонирхлын өөрчлөлтийн талаар мэдэгдэх
  - 48.4 Туслан гүйцэтгэгчид хамаарах
  - 48.5 Заасан журмыг биелүүлээгүй талаарх мэдэгдэл
- 49. Хууль бус мэдээллийн зуучлал**
  - 49.1 Хууль бус мэдээллийн зуучлал
  - 49.2 Мэдэгдэх
- 50. Монгол Улсын хөгжилд оруулах хувь нэмэр, олон нийтийн харилцаа**
- 51. Зардал**
  - 51.1 Талууд өөрсдийн зардлыг хариуцах
  - 51.2 Тэмдэгтийн хураамж
- 52. Нийлүүлэгчийн статус**
  - 52.1 Хараат бус гүйцэтгэгч
  - 52.2 Түншлэл, хамтарсан нийлүүлэгч
- 53. Туслан гүйцэтгүүлэх**
  - 53.1 Компани зөвшөөрөл олгох
  - 53.2 Туслан гүйцэтгүүлэх хариуцлага
  - 53.3 Туслан гүйцэтгэгчийн статус
- 54. Хувийн мэдээллийг хамгаалах**
  - 54.1 Хувь хүний мэдээлэл
  - 54.2 Баталгаа
  - 54.3 Мэдээллийн хамгаалалт
  - 54.4 Хувь хүний гаргасан гомдол
  - 54.5 Нийлүүлэгч нөхөн төлбөр төлөх
  - 54.6 Гэрээг цуцлах
- 55. Татгалзах**
- 56. Нэмэлт баталгаа**
- 57. Гэрээний тусгаар байдал**
  - 57.1 Гэрээний тусгаар байдал
  - 57.2 Сайн санаагаар хэлэлцээ хийх
- 58. Удирдлага болгох хууль**
  - 58.1 Удирдлага болгох хууль
  - 58.2 НҮБ-ийн конвенц - Олон улсын бараа худалдаа
  - 58.3 Гуравдагч талын эрх
- 59. Гэрээний нөхцөлийн хүчинтэй байдал**
- 60. Гэрээний хувь**
- 61. Гэрээний хэл**

## 1. Нэр томьёоны тодорхойлолт, тайлбар

### 1.1 Нэр томьёоны тодорхойлолт

Энэхүү гэрээ болон ерөнхий нөхцөлд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

**Салбар компани** гэж гэрээний нэг тал нь хяналтыг хэрэгжүүлж буй эсхүл түүний хяналт дор буй эсхүл нэгдсэн хяналт дор буй аливаа корпораци, компани, нөхөрлөл, хязгаарлагдмал нөхөрлөл, хязгаарлагдмал хариуцлагатай компани, хамтарсан хөрөнгө оруулалттай компани ба аж ахуйн нэгжийн бусад хэлбэрийг ойлгоно. “Хянах” гэсэн үгийг үйл үгээр хэрэглэх бол тухайн хуулийн этгээдийн удирдлагыг хэрэгжүүлэх, эсхүл удирдлагын бодлого чиглэлд нөлөө үзүүлэх, чиглүүлэхдээ (i) саналын эрхтэй хувьцааны эсвэл гишүүнчлэлийн ашиг сонирхлын хууль ёсны өмчлөгч болон; (ii) менежер, захирал болон корпорацийн удирдлагыг томилох эрх; (iii) гэрээ; (iv) үйл ажиллагааны гэрээ, хэлцэл; (v) санал өгөх итгэмжлэлээр эсвэл өөр аргаар нэг буюу түүнээс дээш тооны зуучлагчаар шууд, шууд бусаар хэрэгжүүлэх эрх мэдэл; эсвэл хэрэв аливаа этгээдэд хамаарч хэрэглэгдэж байвал тухайн этгээдийн үйл ажиллагааг хянах бодит, хууль ёсны эрх мэдлийг; хэрэв нэр үгээр хэрэглэх бол дээр дурдсан эрх мэдлийн алийг ч хэрэгжүүлэх эрхийг холбогдох этгээдэд олгож буй ашиг сонирхлыг хэлнэ.

**Хувилбарт нийлүүлэлт** гэдгийг 18.1-д тодорхойлов.

**Хэрэглэгдэх хууль** гэж энэхүү гэрээний дагуу аль нэг талын эрх, үүрэгтэй холбоотой эсвэл тухайн нийлүүлэлт хийгдэх, түүнийг ашиглах газрын эрх зүйн тогтолцооноос хамаарах орон нутаг, улс, муж, нутаг дэвсгэр, үндэсний болон холбооны аливаа хууль, тогтоомж, дүрэм, журам, гэрээ хэлэлцээр, Засгийн газрын агентлагийн тушаал шийдвэрийг хэлнэ.

**Холбогдох үйлчилгээ** гэж (хэрэв шаардлагатай бол) Хавсралт В (холбогдох үйлчилгээ)-д тусгасан Нийлүүлэгчийн гүйцэтгэх үйлчилгээг хэлнэ.

**Ажлын өдөр** гэж гэрээний үүргийг биелүүлэх газар эсхүл 44-т заасан мэдэгдэл хүргэгдэх газарт орших банкны ажиллах өдрийг хэлнэ.

**Цуцлах өдөр** гэдгийг 39.2(б)(iii)-д тодорхойлов.

**Нэхэмжлэл** гэж аливаа хэлбэрийн нэхэмжлэл, зарга, хэрэг эсвэл хүсэлт шаардлагыг хэлнэ. (Компани, түүний ажилтан, Нийлүүлэгчийн ажилтан, аливаа гуравдагч талаас гаргасан, эсхүл эсрэгээр хэнд нь ч хандсан байж болно)

**Эхлэх өдөр** гэдгийг Гэрээний Гол Нөхцөлд заасан.

**Ашиглалтад оруулах** гэдэгт эд зүйлс бүрийн үйл ажиллагааны бэлэн байдлыг шалгах, механик болон автомат бүх холбоос болон хаалтыг шалгах, ачаалалгүйгээр ажиллуулж шалгах, бүрэн ачаалалтайгаар ажиллуулж шалгах, техникийн тодорхойлолтод заасан үзүүлэлтүүдийн дагуу гүйцэтгэлийг хангаж буй эсэхийг нотолж турших, эсхүл талуудын ашиглалтанд хүлээн авахад шалгахаар тохиролцсон бусад нөхцөлүүдийг хангаж буй эсэхийг шалгах зэрэг үйл ажиллагааг ойлгоно.

**Компани** гэдгийг Гэрээний Гол нөхцөлд тодорхойлов.

**Компаниас эрх хэмжээ** гэдгийг 28.5(б)-д тодорхойлов.

**Компани гэрээний үүргийг зөрчих** гэдгийг 40.1-д тодорхойлов.

**Компани гэрээний үүргийг зөрчсөн тухай мэдэгдэл** гэдгийг 40.2-д тодорхойлов.

**Компанийн удиртгал сургалт** гэдгийг 28.5.(а)-д тодорхойлов.

**Компанийн төлөөлөгч** гэдгийг Гэрээний Гол нөхцөлд тодорхойлсны дагуу болон дор дурдсанаар ойлгоно. Үүнд:

- (а) Төлөөлөгчийг орлох тухай Компанийн бичгээр баталгаажуулсан бусад этгээд; эсхүл
- (б) Төлөөлөгчийн аливаа эрх, үүрэг хариуцлага, үйл ажиллагааны эрх чөлөө, эрх мэдлийг хэрэгжүүлэхээр тухайн төлөөлөгчийн албан ёсоор зөвшөөрөл олгосон этгээд зэрэг болно.

**Компанийн хувийн мэдээлэл** гэж Компаниас Гэрээтэй холбоотойгоор тухай бүрт Нийлүүлэгчид өгсөн хувийн чанартай мэдээллийг ойлгоно.

**Нууц мэдээлэл** гэдэгт энэхүү Гэрээ, гэрээний бусад тал болон Рио Тинто Группийн (тухайн нийлүүлэлттэй холбоотой) гишүүдийн бизнес, үйл ажиллагаатай холбоотой ,нууц шинж чанар бүхий (Гэрээний тал болон түүний ажилтан тухайн мэдээллийг нууц гэдгийг мэдэх боломжтой байх) аливаа хэлбэрийн мэдээлэл, баримт бичгийг ойлгох бөгөөд дор дурдсан мэдээлэл нууц байна. Үүнд:

- (а) аль нэг талын нэрийн өмнөөс эсхүл түүгээр нөгөө тал эсвэл түүний ажилтнуудад мэдээллийг задруулсан;
- (б) аль нэг тал эсхүл түүний ажилтан нь нийлүүлэлтийн явцад бий болгож бүтээсэн; эсхүл
- (в) аль нэг тал эсхүл түүний ажилтны мэдлэг байхаас бусад тохиолдол зэрэг болно.

**Гэрээ** гэдгийг 2.1-д тодорхойлов.

**Гэрээний оюуны өмч** гэдэгт Гэрээг хэрэгжүүлэх, нийлүүлэлт хийх зорилгын хүрээнд (нийлүүлэлт хийхэд Нийлүүлэгчийн бий болгож бүтээсэн зүйлсэд холбогдох оюуны өмчийн бүх эрх, Компаниас Нийлүүлэгчид өгсөн баримт бичиг дэх аливаа оюуны өмчийн эрхийг оролцуулан), эсхүл бараа бүтээгдэхүүн нийлүүлсний үр дүнд үүссэн, нээгдсэн буюу бий болсон (одоо ба ирээдүйд) оюуны өмчийн бүх эрхийг хамтад нь ойлгоно.

**Гэрээний үнэ** гэдгийг 13.1-д тодорхойлов.

**Үр дагавар бүхий хохирол** гэдэгт энэхүү Гэрээний улмаас үүссэн шууд бус ашгийн алдагдал, хүлээгдэж байсан хуримтлалын алдагдал, бизнесийн гарз хохирол болон мэдээлэл алдагдах зэргийг ойлгоно.

**Гаалийн татвар** гэж бараа материалыг импортлох, экспортлохтой холбоотойгоор аль нэг Засгийн газрын эрх бүхий байгууллагад төлбөл зохих буюу ногдуулсан, нэхэмжилсэн аливаа татварыг хэлнэ.

**Суутгасан дүн** гэдгийг 17.2(a)-д тодорхойлов.

**Доголдол арилгах хугацаа** гэдгийг Гэрээний Гол нөхцөлд тодорхойлов.

**Хүргэлтийн цэг** гэдгийг Гэрээний Гол нөхцөлд тодорхойлов.

**Маргаан** гэдгийг 41.1-д тодорхойлов.

**Маргааны тухай мэдэгдэл** гэдгийг 41.1-д тодорхойлов.

**Талуудын маргаан шийдвэрлэх төлөөлөгчид** гэдгийг 41.2(a)-д тодорхойлов.

**Баримт бичиг** гэж төлөвлөгөө, дизайн, зураг төсөл, тооцоо, инженер техникийн мэдээлэл, өгөгдөл, техникийн тодорхойлолт шаардлагууд, скез, тэмдэглэл, загвар жишээ, тайлан, газрын зураг, бүртгэл тооцоо, үйл ажиллагааны гарын авлага, сургалтын материал болон гэрээнд тодорхойлсон бусад (биет болон цахим хэлбэрээр хадгалсан) баримт бичгүүдийг хэлнэ.

**Онцгой албан татвар** гэж барааны үйлдвэрлэлтэй холбоотойгоор аль нэг Засгийн газрын эрх бүхий байгууллагад төлөх шаардлагатай буюу ногдуулсан, нэхэмжилсэн аливаа татварыг хэлнэ.

**Барилга байгууламж** гэж ажлын талбай дахь тээвэрлэлт болон эмнэлэг, бие засах газрыг хэлнэ.

**Давагдашгүй хүчин зүйлс** гэж энэ тухай нэхэмжлэл гаргаж буй талын хувьд удирдлага хяналтаас давсан, тухайн этгээд урьдчилан сэргийлж түүнээс зайлсхийх ямар нэгэн арга хэмжээ авч даван туулах боломжгүй буюу урьдчилан харах боломжгүй аливаа үйл явдал эсхүл шалтгааныг хэлэх бөгөөд үүнд (дээр дурдсан нөхцөлд нийцэхүйц) дараахь зүйлс орно. Үүнд:

- (а) байгалийн гамшиг (цаг агаарын онц аюулаас бусад);
- (б) хуй салхи, гал түймэр, үер, эсхүл
- (в) дайн тулаан, дайсны довтолгоо, террорист үйл ажиллагаа, бослого мөргөлдөөн болон олон нийтийн эмх замбараагүй байдал зэрэг болно.

**Бараа бүтээгдэхүүн** гэж Хавсралт А (Бараа бүтээгдэхүүн)-д тодорхойлсон бараа, бүтээгдэхүүн, материал, хэрэгсэл, тоног төхөөрөмж болон бусад зүйлсийг хэлнэ.

**Засгийн газрын эрх бүхий байгууллага** гэж аливаа Засгийн газар эсхүл түүний харьяаны зохицуулагч, захиргааны, хагас төрийн оролцоот, орон нутгийн/хотын захиргааны, санхүү татвар эсхүл шүүх эрх мэдэл бүхий байгууллага, яам тамгын газар, комиссын бүрэлдэхүүн, нэгж хэлтэс, шүүх, эрх бүхий байгууллагууд, товчоод, төрийн түшмэл, яамдын сайд, улсын мэдлийн корпораци, маргаан шийдвэрлэх комисс болон хууль, журам, дүрэм батлан гаргах бусад эрх бүхий байгууллыг хэлнэ.

**Аюултай бодис** гэж (а) хэрэглэгдэх хуулиудын дагуу бохирдуулагч, хордуулагч, аюултай бодис, хорт бодис, аюултай болон хортой химийн бодис, аюултай хог хаягдал гэж тодорхойлогдсон бөгөөд үүгээр үл хязгаарлагдсан асбест гэх мэт аюултай бодис, түүний агууламж бүхий материал, (б) хэрэглэгдэх хуулийн дагуу судлан шинжлэх, шалгах, цэвэрлэх, нүүлгэн шилжүүлэх, зайлуулах зэрэг арга хэмжээ авах шаардлагатай аливаа бодисыг хэлнэ.

**Эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, байгаль орчин (ЭАБ)-ны Удирдлагын Төлөвлөгөө** гэдгийг 28.4(a)-д тодорхойлов.

**ЭАБ-ны бодлого, стандарт** гэдгийг 28.3(a)-д тодорхойлов.

**Мэдээллийн хууль бус зуучлал** гэж өрсөлдөөнт тендер шалгаруулалтын үед гэрээ байгуулах эрхийг авлига, хээл хахуулийн замаар олж авах зорилго бүхий тодорхой этгээд нь гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч, үйлдвэрлэгч болон бусад нийлүүлэгчид нууц мэдээлэл өгөхийг санал болгох, эсхүл хууль бус нөлөөлөл үзүүлэх гэсэн аливаа оролдлого, үйлдлийг хэлнэ.

**Нөхөн олговор төлөгдөх тал** гэж Компани, түүний ажилтныг хэлнэ.

**Шууд бус гүйлгээний татвар** гэж аль нэг Засгийн газрын эрх бүхий байгууллагад төлөхөөр ногдуулсан, нэхэмжилсэн аливаа нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), бараа, үйлчилгээний татвар эсхүл түүнтэй төсөөтэй худалдаа, хэрэглээ, ашиглалтын татварыг хамааруулах ба торгууль, шийтгэл, хүүг энд оролцуулахгүй.

**Татварын хөнгөлөлт** гэж нь аливаа нийлүүлэлтийг худалдан авсан буюу хүлээн авсантай холбоотойгоор тавигдах Шууд бус гүйлгээний татварын хасалт, хөнгөлөлт, зөрүү, буцаан олголт зэрэг хөнгөлөлтийн эрхийг хэлнэ.

**Оюуны өмчийн эрх** гэж бүхий л зохиогчийн эрх болон түүнтэй төстэй эрхүүдийг багтаасан зохион бүтээх (бүх патентууд болон патентын хүсэлтийг хамааруулах), худалдааны нууцууд ба ноу-хау, дизайнтай холбоотой эрхүүд (бүртгэж болох эсэх нь хамаагүй), бүртгэсэн бүртгээгүй худалдааны тэмдэг, цахилгаан электроникийн хэлхээний зургийн дизайн болон түүнтэй холбоотой эрхүүд зэрэг нь хуулиар хамгаалагддаг бүх үйлдвэрлэлийн болон оюуны өмчийн эрхүүдийг ойлгоно. Гэхдээ шилжүүлэх боломжгүй ёс суртахууны эрхүүд, эсхүл түүнтэй төстэй шилжүүлэх боломжгүй зохиогч ба үйлдвэрлэгчийн хувийн эрхүүд зэргийг оюуны өмчийн эрхэд хамруулахгүй.

**Хамтрагчид** гэж хамтран ажиллах зорилгоор уг хамтарсан үйл ажиллагааны нэг тал болж оролцож буй этгээдийг хэлнэ.

**Гол нөхцөл** гэдэгт Гэрээний “Гол Нөхцөл” гэж нэрлэсэн хэсгийг ойлгох бөгөөд үүнд тухайн баримт бичигт хамаарах Хавсралтуудыг оролцуулахгүй.

**Нийлүүлэлт хийгдээгүйн улмаас хугацаа хэтрүүлсний төлбөр** гэдгийг 37.1(б)-д тодорхойлов.

**Хариуцлага** гэдэгт бүх төрлийн хохирол, нэхэмжлэл, алдагдал, зардал зэргийг ойлгоно.

**Хугацаа хэтрүүлсний төлбөр** гэдгийг 37.1(б)-д тодорхойлов.

**Материал** гэдгийг 45.5.(а)(i)- д тодорхойлов.

**Монголын ажлын байрны төлбөр** гэж Ажиллах хүч гадаад гаргах болон гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай Монгол Улсын хуулийн дагуу үүний дагуу (Нийлүүлэгч эсхүл туслан гүйцэтгэгчийн хөлслөн ажиллуулж буй) Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт (эсхүл аливаа Бараа бүтээгдэхүүний хүргэлт) үзүүлж буй Монгол улс дахь гадаад (Монгол хүн бус) ажилтнууд ажлын байранд ногдуулах төлбөрийг ойлгоно.

**Мэдээдэл** гэдгийг 46.1-д тодорхойлов.

**Албан тушаалтан** гэж:

- (а) Аль нэг Засгийн газрын эрх бүхий байгууллагын ажилтан, албан тушаалтан, эсхүл тухайн Засгийн газрын эрх бүхий байгууллагыг албан ёсоор төлөөлж буй аливаа этгээд;
- (б) Улс төрийн намын аливаа ажилтан, албан хаагч, албан тушаалтан;
- (в) Төрийн байгууллагад нэр дэвшигч аливаа этгээд; эсхүл
- (г) Олон улсын нэр бүхий байгууллага (жишээлбэл НҮБ, ОУ Валютын Сан, Дэлхийн Банк)-ын аливаа ажилтан, албан тушаалтан зэргийг хэлнэ.

**Тал** гэж энэхүү гэрээний аль нэг талыг хэлнэ.

**Хувийн мэдээлэл** гэж (а) тухайлсан хувь хүний оршин суугаа, (б) тухайн хувь хүнтэй холбоотой мэдээллийг боловсруулсан улсад мөрдөх хувь хүний нууцын тухай хууль болон мэдээлэл хамгаалах тухай хуулиар хамгаалагдсан тухайлсан хувь хүнтэй холбоотой бүх мэдээллийг хэлнэ.

**Ажиллах хүч** гэж:

- (а) Нийлүүлэгчтэй холбоотойгоор түүний аливаа ажилтан, туслан гүйцэтгэгч (түүний ажиллах хүчин), бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, гүйцэтгэхэд шууд болон шууд бусаар оролцогч агент ба төлөөлөгч нар;
- (б) Компани эсхүл Рио Тинто Группийн аль нэг гишүүнтэй холбоотойгоор түүний өмнөх болон одоогийн ажилтан, албан хаагчид, агентууд ба тэдний өмнөх болон одоогийн ажилтан, албан хаагчид болон төлөөлөгч нар;
- (в) Туслан гүйцэтгэгчтэй холбоотойгоор түүний аливаа ажилтан, бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, гүйцэтгэхэд шууд болон шууд бусаар оролцогч агент ба төлөөлөгч нарыг хэлнэ.

**Худалдан авах захиалга** гэж энэхүү гэрээний нөхцөлд заасан Нийлүүлэлт хийх болон холбогдох үйлчилгээний нийлүүлэлттэй холбоотойгоор Компанийн Нийлүүлэгчид гаргасан бараа бүтээгдэхүүн худалдан авах болон холбогдох үйлчилгээг гүйцэтгүүлэх тухай захиалгыг хэлнэ.

**Үүргээс чөлөөлөх өдөр** гэдгийг 21.5-д тодорхойлов.

**Рио Тинто Групп** гэж Рио Тинто плс ба Рио Тинто Лимитэдээс бүрдэж буй давхар бүртгэлтэй компанийн бүтцийг хэлэх бөгөөд үүнд:

- (а) Рио Тинто плс болон Рио Тинто Лимитэдийн аливаа Салбар компани,

- (б) Рио Тинто Плс болон Рио Тинто Лимитэд эсвэл Рио Тинто плс болон Рио Тинто Лимитэдийн аливаа Салбар Компани хувьцааны 50-аас доошгүй хувийг нь эзэмшдэг аливаа корпораци эсвэл хамтарсан компани,
- (в) Рио Тинто Плс болон Рио Тинто Лимитэд эсвэл Рио Тинто Плс болон Рио Тинто Лимитэдийн аливаа Салбар Компани менежментийг нь хэрэгжүүлдэг аливаа корпораци эсвэл хамтарсан компани, болон
- (г) Талуудын бичгээр хүлээн зөвшөөрсөн бусад этгээдийг оролцуулна.

**Рио Тинтогийн оюуны өмч** гэж Компанийн болон Рио Тинто Группийн (тухайн тохиолдолд шаардлагатай бол) аль нэг гишүүний эзэмших дор дурдсан оюуны өмчийн эрхийг хэлнэ. Үүнд:

- (а) Гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр байсан эрх; эсхүл
- (б) Гэрээ байгуулсан өдрөөс хойш гэрээтэй холбогдолгүйгээр бий болсон эрхийг оролцуулна.

**Рио Тинто Лимитэд** гэж Викториа, 3000, Мелбурн хот, Коллинс Гудамж 120, давхар 33-т хаягийн бүртгэлтэй, Рио Тинто ХХК (ABN 96 004 458 404)-ийг хэлнэ.

**Рио Тинто Плс** гэж Нэгдсэн Вант Улс, Лондон хот W2, 6LG, Истбурн террас 2 дахь Рио Тинто ХК (Компанийн дугаар: 719885)-ийг хэлнэ.

**Гүйцэтгэлийн баталгаа** гэдгийг 21.1-д тодорхойлсон ба энэ нь 21.2-т заасны дагуу аливаа нэмэлт, өөрчлөлтийг агуулна.

**Сайт** гэж Гэрээний Гол нөхцөлд дурдсан Компанийн газар, барилга байгууламжийг хэлнэ.

**Сайтын онцгой нөхцөл** гэж Хавсралт Е-д заасны дагуу болон Компаниас цаг тухай бүрт сайтын онцгой нөхцөлд тооцсон тухай өөрчлөлтийг бичгээр мэдэгдсэн Компанийн сайтын онцгой нөхцөлийг хэлнэ.

**Тусгай нөхцөл** гэж Хавсралт G (Тусгай нөхцөл) –д заасан тусгай нөхцөлийг хэлнэ.

**Үзүүлэлт** гэж үйлчилгээнд тавигдах техникийн тодорхойлолт, шаардлага болон тухайн шаардлагад оруулсан аливаа өөрчлөлтийг хэлнэ.

**Туслан гүйцэтгэгч** гэж 53-р зүйлд зааснаар Нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний дагуу Нийлүүлэлтийн аль нэг эсхүл бүх хэсгийг Нийлүүлэгчийн өмнөөс гүйцэтгэх этгээдийг хэлнэ.

**Нийлүүлэгч** гэдгийг Гэрээний Гол нөхцөлд тодорхойлов.

**Нийлүүлэгч гэрээний үүргийг зөрчсөн тухай мэдэгдэл** гэдгийг 39.1-д тодорхойлов.

**Нийлүүлэгчийн даатгал** гэдгийг 34.1-т тодорхойлов.

**Нийлүүлэгчийн оюуны өмч** гэж Нийлүүлэгчийн эзэмших дор дурдсан оюуны өмчийн эрхийг хэлнэ. Үүнд:

- (а) Гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр байсан эрх; эсхүл
- (б) Гэрээ байгуулсан өдрөөс хойш гэрээтэй холбогдолгүйгээр бий болсон эрхийг оролцуулна.

**Нийлүүлэгчийн төлөөлөгч** гэдгийг Гэрээний Гол нөхцөлд тодорхойлов.

**Нийлүүлэлт** гэж Гэрээний дагуу бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт, холбогдох үйлчилгээний гүйцэтгэлийг хэлнэ.

**Нийлүүлэлтийн гинжин хэлхээ** гэж компанид бараа бүтээгдэхүүн болон холбогдох үйлчилгээг (хэрэв байгаа бол) нөөцлөн гүйцэтгэхээс эхлэн Компани бараа бүтээгдэхүүн, холбогдох Үйлчилгээг ашиглаж дуусах хүртэлх нийлүүлэлт хийхтэй холбоотойгоор хамарч буй бүхий л үе шат, явцыг хэлнэ.

**Нийлүүлэлтийн хугацааны хуваарь** гэж бараа бүтээгдэхүүн нийлүүлэлтийн явцыг үр дүнтэй хянах зорилгоор Хавсралт D (Нийлүүлэлтийн хугацааны хуваарь)-д тусгасан хугацааны график хуваарийг хэлнэ. Үүнд:

- (а) (хэрэв талууд харилцан өөрөөр тохиролцоогүй бол) нийлүүлэлтийг гүйцэтгэхтэй холбоотой чухал нэр төрөл, үйл ажиллагааг тодорхой нарийвчлан тусгасан, хугацаанд суурилсан загвартай;
- (б) нийлүүлэлтийн үе шат, хэсэг бүрийн эхлэх болон дуусах өдөр, цаг хугацааг заасан байх бөгөөд энэхүү Нийлүүлэлтийн хугацааны хуваарьт 9.2-ийн дагуу түүнд хийх аливаа нэмэлт өөрчлөлтийг багтаана.

**Татвар буюу татварууд** гэдэгт эсрэг утга санаа илэрхийлээгүй бол, аль нэг Засгийн Газрын эрх бүхий байгууллагаас тогтоосон, ногдуулсан ба нэхэмжилсэн буюу төлбөл зохих бүх татварууд, мөн үүгээр үл хязгаарлагдах аливаа шууд бус гүйлгээний татвар, онцгой албан татвар, тэмдэгтийн хураамж, баримт бичиг бүрдүүлэлтийн хураамж, гаалийн татвар, импорт/экспортын татвар, цалингийн шимтгэл, хувь хүний татвар, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн татвар, ашгийн тэнцэтгэлийн татвар, бизнесийн татвар, мэргэжлийн татвар, эргэлтийн хөрөнгийн татвар, орлогын албан татвар, корпорацийн татвар, хөрөнгийн татвар, ашгийн татвар, нийт олсон орлогод ногдуулах татвар болон бусад татвар хураамж болон бусад төлбөр, хүн амын орлогын албан татвар, гаалийн хураамж, шимтгэл, суутгал зэрэг аль ч үед ногдуулах боломжтой аливаа хэлбэрийн татвар хураамжууд тэдгээрт тооцсон алданги, торгууль, хүү болон түүнтэй төстэй бүх нэмэгдэл төлбөрүүдийг хамтатган ойлгоно.

**Татварын нэхэмжлэх** гэж ногдуулсан, тогтоосон, нэхэмжлэх шууд бус гүйлгээний татварыг төлөх хариуцлага үүссэн газрын эрх зүйн тогтолцоонд мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомжийн дагуу хүчин төгөлдөр маягтын дагуу гаргасан авлагын болон өрийн бичгээс гадна мөн үүгээр үл хязгаарлагдах аливаа нэхэмжлэх буюу бусад баримт бичгийг хэлэх бөгөөд уг нэхэмжлэхийг гаргасан тухайн этгээд нь Орлогын татварын хөнгөлөлт эдлэх эрх бүхий байх ёстой.

**Тендер** гэж тухайн нийлүүлэлт хийх тухай “тендер” эсхүл “санал” гэж нэрлэсэн Нийлүүлэгчийн бичгээр өгч буй санал, эсхүл хариу саналыг хэлнэ.

**Хугацаа** гэдгийг Гэрээний Гол нөхцөлд тодорхойлов.

**Гэрээ цуцлах мэдэгдэл** гэдгийг 38.1-д тодорхойлов.

**Нэмэлт, өөрчлөлт** гэдгийг 6.1(a)-д тодорхойлов.

**Санаатай зөрчил** гэдэг нь аль нэг тал ба түүний аливаа ажилтан, албан хаагч, агентуудын (ажилтан, албан хаагч эсхүл агентын үүргээ биелүүлэх явцдаа) гаргасан дор дурдсан үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ. Үүнд:

- (b) бусдад аюул, хохирол, гэмтэл учруулах боломжтойг тухайн тал (холбогдох ажилтан, албан хаагч эсхүл агент) мэдсэн эсхүл мэдэх ёстой байсан ч санаатай, шалтгаангүй, эсхүл болгоомжгүйгээр;
- (c) залилан мэхлэж зэрэг болно.

Гэхдээ, үүнд сайн санаагаар үйлдэж (эсхүл үйлдэхээс татгалзаж) буй аль нэг тал, түүний ажилтан, албан хаагч эсхүл агентын аливаа гэм буруугүй үйлдэл, эс үйлдэхүй, алдаа болон тооцооллын алдаа зэргийг хамааруулахгүй.

## 1.2 Тайлбар

- (a) Гарчиг нь зөвхөн ойлгомжтой байлгах үүднээс өгсөн бөгөөд гэрээний тайлбарт нөлөөлөхгүй. Агуулгад тусгайлан өөрөөр заагаагүй тохиолдолд дор дурдсан дүрмийг мөрдөнө.
- (b) Ганц тоогоор илэрхийлсэн үг олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.
- (в) Хүйс гэдэг үг бүх хүйсийг илэрхийлнэ.
- (г) Хэрэв үг ба хэллэг нь тодорхойлогдсон бол тухайн үг/хэллэгийн бусад өгүүлбэрзүйн хэлбэрүүд нь тухайн утгаар хэрэглэгдэнэ.
- (д) Ерөнхий үг хэллэгийн утга нь түүнийг жишээнд оруулж тайлбарласан тодорхой жишээгээр үл хязгаарлагдана.
- (e) Этгээд гэж корпораци, итгэлцэл, хамтын ажиллагаа, түншлэл, хувь нийлүүлсэн бус байгууллага эсхүл бусад байгууллагын тухай бол тэдний аль нь ч байж болно.
- (ё) Хувь хүн эсхүл гэрээний аль нэг тал гэдэгт уг хүний эсхүл тухайн талын гүйцэтгэгч, албан тушаалтан, өв залгамжлагчид, орлогч (үүргийг нь албан ёсоор хүлээж авсан этгээдийг оролцуулан), эрх шилжүүлж авсан хүн (хувь хүн бол), эрх шилжүүлж авахыг нь зөвшөөрсөн тал (гэрээний аль нэг тал бол) зэргийг оруулна.
- (ж) Заалт болон хавсралт гэж энэ нь энэхүү “Ерөнхий нөхцөл”-ийн заалт, түүнд хавсаргасан хавсралт гэж ойлгоно.
- (з) Хавсралт гэж энэ нь энэхүү Гэрээний хавсралт гэж ойлгоно.
- (и) Хууль тогтоомж болон хууль тогтоомжийн нөхцөл нь заалтуудад тэдгээрийн өөрчлөлт болон дахин шинэчлэн найруулсан батлах хувилбар, үүнд нэмсэн хуулинд орсон хууль зүйн нөхцөл болоод болон түүний хүрээнд батлан гаргасан тогтоомж, хууль ёсны баримт бичгийг хамаарна.
- (к) Оюуны өмчийн эрхтэй холбоотой агуулгыг хэрэглэх бол түүнийг хэрэглэх, ашиг шимийг нь хүртэх, хуулбарлах, тохируулан өөрчлөх, түүнээс үүсмэл зүйлсийг бий болгох, хөгжүүлэх, өөрчлөх, задруулах болон дамжуулах зэргийг багтаан ойлгоно.
- (л) Зохион байгуулах гэдэгт эс үйлдэхүй, бичгийн эсхүл бичгийн бус мэдээлэл, үйл ажиллагаа зэргийг илэрхийлэх бөгөөд үүгээр үл хязгаарлагдана.
- (м) Хэрэв Нийлүүлэгч аливаа ажиллагаа явуулах эсхүл эд зүйлийг нийлүүлэхдээ түүнд харгалзах зардалд нь багтаан гүйцэтгэнэ гэж заасан бол энэ нь Нийлүүлэгч тухайн ажил эсхүл эд зүйлийн төлөө ямарваа нэгэн нэмэлт урамшуулал авах эрхгүй бөгөөд уг зардлыг Гэрээний үнэд багтсан гэж ойлгоно.
- (н) Компани нь Гэрээнд тусгасан бүхий л хөнгөлөлт, чөлөөлөлт, хязгаарлалт, хамгаалалт, урамшуулал, нөхөн төлбөрийн баталгаа болон бусад дэмжлэгийг өөрийн ажилтан, албан хаагч нар болон Рио Тинто Группийн гишүүн, түүний ажилтнуудад үзүүлэх бөгөөд Рио Тинто Группийн гишүүн, түүний ажилтнуудын хувьд батлан даагч болж сахин хамгаална.



- (о) Компани болон Рио Тинто Группийн гишүүн эсхүл тэдний холбогдох ажилтан нь Гэрээнд заасны дагуу нөхөн төлбөрийн эрхийг хэрэгжүүлэхийн өмнө ямар нэгэн зардал гаргах эсхүл төлбөр хийх шаардлагагүй.

## **2. Гэрээний нотлох баримт, баримт бичгийг давууд үзэх дараалал**

---

### **2.1 Гэрээ**

Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно. Үүнд:

- (а) Гэрээний Гол нөхцөл;
- (б) Хавсралт G (Тусгай нөхцөл)(хэрэв байгаа бол);
- (в) Хавсралт E (Сайтын онцгой нөхцөл) (хэрэв байгаа бол);
- (г) Энэхүү "Ерөнхий нөхцөл";
- (д) Хавсралт A (Бараа бүтээгдэхүүн);
- (е) Хавсралт B (Холбогдох үйлчилгээ) (хэрэв шаардлагатай бол);
- (ё) Хавсралт F (Орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр)(хэрэв тохирох бол);
- (ж) Хавсралт C (Үнэ);
- (з) Хавсралт D (Нийлүүлэлтийн хугацааны хуваарь); болон
- (и) бусад Хавсралтууд

Гэхдээ тендерийг (хэрэв байгаа бол) бүхэлд нь эсхүл түүний аль нэг хэсгийг Компани бичгээр зөвшөөрөөгүй бол Гэрээний бүрдэл хэсэг болохгүй.

### **2.2 Гэрээний баримт бичгийг давууд үзэх дараалал**

- (а) Хэрэв Гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл 2.1-д дурдсан дарааллын дагуу давууд үзэж шийдвэрлэнэ.
- (б) Хэрэв худалдан авах захиалга, Гэрээний бусад нөхцөл хоорондоо зөрчилдвөл тухайн зөрчилдсөн хэмжээнд Гэрээний нөхцөл давамгай үйлчилнэ.

### **2.3 Гэрээний бүрэн бүтэн байдал**

- (а) Энэ Гэрээ нь агуулгын хувьд Компани ба Нийлүүлэгчийн хоорондын эцсийн тохиролцоо болох бөгөөд эдгээр харилцаа нь Гэрээний нэг хэсгийг бүрдүүлж буйг илэрхийлснээс бусад тохиолдолд талуудын хооронд урьд өмнө үйлдсэн бүх харилцаа, хэлцлийг орлон шинээр тогтооно.
- (б) Нийлүүлэгч нь Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлттэй холбоотойгоор энэхүү Гэрээнд зааснаас (нэхэмжлэх хүргүүлэх хэсэг болгон) өөр нөхцөлийг хангах, хамаатуулах, дагаж мөрдөх, эсхүл хэрэглэх тохиолдолд, тэдгээр нөхцөл нь энэхүү Гэрээний хэсэг болохгүй бөгөөд үл хамаарна.  
  
Энэхүү гэрээний дагуу нийлүүлсэн бараа бүтээгдэхүүн эсхүл бусад зүйлсийн хамт Нийлүүлэгчийн баримт бичиг дагалдах хэдий ч тухайн нийлүүлсэн бараа бүтээгдэхүүн (эсхүл бусад зүйлс)-г хүлээн авсан эсхүл хүргэлт хийгдсэн тухай Компанийн хүлээн зөвшөөрсөн мэдэгдлийг үндэслэх бөгөөд Нийлүүлэгчийн баримт бичгийг харгалзан үзэхгүй.
- (в) Гэрээний хугацааны явцад Компанийн гаргасан худалдан авах захиалгад энэхүү Гэрээнд зааснаас өөр нөхцөлийг хавсаргасан бол тэдгээр нөхцөл нь энэхүү Гэрээ болон тухайн худалдан авах захиалгын хэсэг болохгүй бөгөөд үл хамаарна.

### **2.4 Бичгээр нэмэлт өөрчлөлт оруулах**

Нийлүүлэгч ба Компани бичгээр үйлдэж гарын үсэг зурснаас бусад тохиолдолд Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь хүчин төгөлдөр бус байна.

## **3. Нийлүүлэгчийн мэдэгдэл**

---

Нийлүүлэгч нь Компанид Гэрээ хүчин төгөлдөр болох өдрийн байдлаар дараахь зүйлсийг нотлон харуулна. Үүнд:

- (а) Гэрээнд заасан өөрийн бүх үүргийг хүлээн авч гүйцэтгэх хангалттай хүчин чадал, чадавхи бүхий;
- (б) Гэрээ хэрэгжүүлэх чадвартай буюу Нийлүүлэлт хийхэд зайлшгүй шаардагдах туршлага, арга барил, нөөц боломжтой;
- (в) Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ цаг хугацаанд нь шаардлага хангасан байдлаар гүйцэтгэх чадварт нь нөлөөлөх ямар нэг зэрэгцсэн гэрээ байхгүй бөгөөд энэхүү Гэрээнд заасан бүх үүргийг гүйцэтгэхтэй холбоотой зохих тусгай зөвшөөрөл, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, зохион байгуулалт, санхүүжилт бүхий;

- (г) Нийлүүлэгч нь Гэрээг шударгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд Нийлүүлэгчийн гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэхдээ түүнд заасан хүчин төгөлдөр нөхцөлийг мөрдөн ажиллаж буй гэдгийг;
- (д) Гэрээний биелэлт болон Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт нь дор дурдсан нөхцөлийн улмаас зөрчигдөх ёсгүй. Үүнд:
  - (i) Нийлүүлэгчид нөлөөлөх эсхүл үүрэг хүлээж болох ямар нэгэн тохиролцоо буюу үйл ажиллагаа (аман болон бичгийн хэлбэрийн), аливаа хэрэгсэл, төхөөрөмжийн улмаас гэрээний үүргийг зөрчих нөхцөл байдал;
  - (ii) Нийлүүлэгчид хамаарах, Нийлүүлэгч дагаж мөрдөх шаардлага үүсч болох аливаа Шүүх, Засгийн газрын эрх бүхий байгууллагын гаргасан тушаал, шийдвэр, заавар дүрэм, журам, хориг, тогтоол болон бусад хууль тогтоомж зэрэг болно.

#### **4. Нийлүүлэгчийн хяналт шалгалт**

---

##### **4.1 Гэрээтэй холбоотой хяналт шалгалт**

Нийлүүлэгч нь өөрийн тендерийг ирүүлэхээс өмнө, эсхүл нэг ч тендер ирүүлээгүй тохиолдолд Нийлүүлэлт хийхтэй холбоотой Компанийн саналыг хүлээн авахаас өмнө дор дурдсан нөхцөлийг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- (а) Компани нь Нийлүүлэгчийг Сайттай танилцаж шалгах, турших бүхий л боломжоор хангаж, Гэрээний гүйцэтгэл болон Нийлүүлэлт хийхэд нөлөөлж болох цаг уур, геологи, хөдөлмөр, орон байр, шатахуун түлш, эрчим хүч, ус, цахилгаан холбоо болон тээврийн нөхцлүүд зэрэг орон нутгийн шинжтэй болон бусад бүх нөхцөл байдлыг шинжилж судлахтай холбоотой туслалцааг бүрэн үзүүлсэн; бөгөөд
- (б) Нийлүүлэгчийг:
  - (i) Сайттай танилцан шалгаж, туршсан;
  - (ii) (4.2-т зааснаар үл хязгаарлагдан) Тендер шалгаруулалтын нэг хэсэг болох Компанийн гаргасан бүхий л баримт бичгийг бүрэн гүйцэд, анхааралтай судалсан;
  - (iii) Энэхүү 4.1-д заасан заалт бүрийн талаар холбогдох мэдээллийг бүрэн авсан гэж үзэхийг хүлээн зөвшөөрнө.

##### **4.2 Компаниас баталгаа өгөхгүй**

Компани нь, Нийлүүлэгч, түүний ажилтан сайттай танилцаж, тендерийн өмнөх уулзалт эсхүл өөр бусад байдлаар Нийлүүлэгч, түүний ажилтны Компаниас олж авсан эсхүл тэдэнд өгсөн аливаа мэдээллийн үнэн зөв байдлыг баталгаажуулахыг (үүнийг хийх үүргийг хүлээхгүй) хичээн ажилладаг бөгөөд цаашид ч хичээх болно. Гэвч Компани нь тухайн мэдээллийн үнэн зөв, хүрэлцээтэй байдлын талаар баталгаа эсхүл батлан даалт гаргахгүй бөгөөд тухайн мэдээллийн талаар ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

Ийнхүү өгсөн мэдээлэл нь зөвхөн Нийлүүлэгчид дөхөм байх үүднээс өгсөн гэдгийг Талууд хүлээн зөвшөөрөх бөгөөд энэ нь Талуудын бичгээр тусгайлан зөвшөөрснөөс бусад тохиолдолд Гэрээний нэг хэсэг болохгүй. Мөн Нийлүүлэгчийн ирүүлсэн аливаа Тендер, түүний улмаас хэрэгжиж буй Гэрээний гүйцэтгэл, хэрэгжилтийг Нийлүүлэгчийн өөрийнх нь хяналт шалгалт ба олж тогтоосон зүйлс дээр тулгуурласан гэж үзнэ.

##### **4.3 Нийлүүлэгч нь үнэн зөв байдалд ханамжтай байх**

Нийлүүлэгч нь Гэрээний гүйцэтгэлээс өмнөх хугацаанд түүнд өгсөн аливаа мэдээллийн үнэн зөв байдалд сэтгэл хангалуун байсан бөгөөд тухайн мэдээллийг аливаа хэлбэрээр ашигласны буюу тухайн мэдээллээс урган гарсан аливаа дүгнэлтийн хариуцлагыг оролцуулан ямар нэгэн хязгаарлалтгүй, бүрэн хариуцлагыг хүлээн гэдгийг зөвшөөрч байна.

##### **4.4 Үүргээс чөлөөлөхгүй байх**

Нийлүүлэгч нь бүх нөхцөл эсхүл аль нэгийг нь биелүүлж чадаагүй тохиолдолд Нийлүүлэгчийг энэхүү Гэрээнд заасан аливаа үүргээс 4-д заасны дагуу чөлөөлөгдсөн гэж үзэхгүй.

##### **4.5 Компани хариуцлага хүлээхгүй байх**

Компанийн Нийлүүлэгчид өгсөн аливаа мэдээллийг ашигласны улмаас Нийлүүлэгч ямар нэг хохирол амссан эсхүл хүндрэл учирсан тохиолдолд Компани хариуцлага хүлээхгүй.

#### **5. Нийлүүлэгчийн гэрээний гүйцэтгэл**

---

##### **5.1 Нийлүүлэлт хийх**

Нийлүүлэгч нь энэхүү Гэрээний нөхцөлийн дагуу Гэрээний үнэд багтаан Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг хийж гүйцэтгэх ёстой.

## 5.2 Захиалах

9-д зааснаас үл хязгаарлагдан, Компани нь Бараа бүтээгдэхүүний зарим болон бүх хэсгийг захиалахдаа Нийлүүлэгчид худалдан авах захиалгыг гарган хүргүүлж болно.

## 6. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

---

### 6.1 Нэмэлт, өөрчлөлт

- (a) Гэрээ хэрэгжих явцад Компанийн төлөөлөгч эсхүл Нийлүүлэгч нь Нийлүүлэлтийн аль нэг хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах (**Нэмэлт, өөрчлөлт**) хүсэлтийг гаргаж болно.
- (b) Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг бичгээр хийх ба Нийлүүлэгч болон Компанийн эрх бүхий этгээд тус тус гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

### 6.2 Нэмэлт, өөрчлөлтийн улмаас гарах зардал

- (a) Компанийн төлөөлөгчийн зааврын дагуу хийгдсэн нэмэлт өөрчлөлтийн улмаас нэгэнт бэлтгэсэн бараа бүтээгдэхүүн, гүйцэтгэсэн боловч шаардлагагүй болсон Бараа бүтээгдэхүүний хувьд үндэслэл бүхий нөхөн олговрыг багтаасан зардлын зөрүүнд (шууд бус гүйлгээний татварыг оролцуулахгүй) Гэрээний үнийн хасалт эсхүл нэмэлтийн аль тохирохыг хийнэ.
- (b) Нэмэлт, өөрчлөлт тооцоолох хэмжээг хавсралтад тодорхойлсон бол Нийлүүлэгч түүнийг нэмэлт өөрчлөлтийн улмаас гарах зардлыг тооцоход ашиглаж болох бөгөөд бусад тохиолдолд Нийлүүлэгч нь нэмэлт, өөрчлөлтийн зардлыг салбарын бодит практикт нийцүүлэн үндэслэл бүхий хамгийн бага зардлаар тооцно.

### 6.3 Нэмэлт, өөрчлөлт оруулах журам

Компани нь нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан тохиолдолд Нийлүүлэгч нь уг хүсэлтийг гаргаснаас хойш 10 хоногийн дотор тухайн өөрчлөлтийг оруулах бол Гэрээний үндэс ямар хэмжээний зөрүү гарах хийгээд, уг өөрчлөлтийн улмаас гарах зардлын зөрүүний барагцаалсан үнэ цэнийн талаар зөвлөмж бүхий мэдэгдлийг Компанийн төлөөлөгчид хүргүүлнэ.

## 7. Нийлүүлэгчийн баталгаа

---

### 7.1 Нийлүүлэгчийн баталгаа

Нийлүүлэгч нь 7.3, 44.5, 45.1, 47.1, 48.2.(б), 49.1, 54.2 ба 8.2-д заасан баталгаанаас гадна дор дурдсан баталгааг өгнө. Үүнд:

- (a) бүх Нийлүүлэлтийг холбогдох хууль тогтоомж, журам дүрмийн дагуу үр ашигтай байдлаар үзүүлнэ;
- (b) бүх Нийлүүлэлт нь Компанийн өгсөн тодорхойлолт, шаардлагад нийцсэн хамгийн өндөр стандартыг хангахуйц байх, хэрэв тийм шаардлага байхгүй бол Олон улсын стандартчлалын байгууллагаас гаргасан тохирох стандарт, хэрэв тийм стандарт байхгүй бол Олон улсад танигдсан холбогдох стандартын дагуу байна;
- (b) Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлттэй холбоотойгоор:
  - (i) Нийлүүлэгч, түүний ажилтнууд нь ижил төстэй, өрсөлдөхүйц чадвар бүхий этгээдийн ажил гүйцэтгэхдээ байнга баримталдаг хичээл зүтгэл, туршлага, чадвар ба анхаарал болгоомжийн стандарт буюу зарчмыг хангаж ажиллана гэдгийг;
  - (ii) Нийлүүлэгчийн сайтад хэрэглэж буй аливаа тоног төхөөрөмж нь Компанийн шаардлагын түвшинд хүртэл аюулгүй ажиллагааны нөхцөлд байж, тухайн тоног төхөөрөмжид холбогдох бүх хууль тогтоомжид нийцсэн, түүнийг ажиллуулах мэргэжилтнүүд нь чадварлаг ажиллах хүчин гэдгийг; мөн түүнчлэн
- (г) Нийлүүлэлтийн нэг хэсэг болох холбогдох бараа бүтээгдэхүүний нийлүүлэлттэй холбоотойгоор:
  - (i) бараа бүтээгдэхүүн нь худалдааны чанарын шаардлага хангасан;
  - (ii) бараа бүтээгдэхүүн нь загвар дизайн, материал ба хийц чанарын хувьд дутагдалгүй бөгөөд бараа бүтээгдэхүүний зорилгод тохирсон;
  - (iii) бараа бүтээгдэхүүн нь сайн, зах зээлийн нэр хүнд бүхий байх бөгөөд Компани нь бараа бүтээгдэхүүний өмчлөх эрхийг ямар нэг үнэ хөлс эсхүл хүндрэл чирэгдэлгүйгээр хүлээн авахыг;
  - (iv) Ердийн худалдааны бүх баталгаа ба Компанийн тусгайлан хүссэн аливаа баталгааг өөрийнх нь өртгөөр нь олж авах ба Нийлүүлэлт гүйцэтгэж дуусах үед хугацаа дуусаагүй аливаа баталгаанаас ашиг хүртэх эрхийг Нийлүүлэгчийн туслан гүйцэтгэгчээс гарган өгсөн баталгааг оролцуулан Компанид шилжүүлэн өгөхийг;

- (д) Тендерийн аливаа хэсгийг бүрдүүлж байгаа бүх төрлийн мэдээлэл, материал нь (хэрэв байгаа бол) бүгд үнэн зөв, алдаа мадаггүй, худал мэдүүлсэн зүйлгүй бөгөөд Компани нь Нийлүүлэгчийг сонгон шалгаруулах эсэхийг шийдэх материал болох тул Нийлүүлэгчийн туршлага болон мэргэшсэн байдлын талаархи мэдээлэл эсхүл тухайн Нийлүүлэлт хийхтэй холбоотойгоор Компанийн бэлдвэл зохих нөхцөл шаардлага, түүний үнэтэй холбоотой мэдээллийг Нийлүүлэгч нь Компаниас нуун далдлаагүй гэдэгт тус тус баталгаа өгнө.

## **7.2 Худалдааны баталгааны хуулбар хувь**

Нийлүүлэгч нь 7.1(г)(iv)-д заасан худалдааны баталгааны хуулбарыг төлбөрийн нэхэмжлэхийн хамт Компанид өгөх ёстой.

## **7.3 Аюултай бодисууд ба бусад хориглосон бодисууд**

Энэхүү Ерөнхий Нөхцөлийн 30 болон бусад заалтын хэрэгжилтээр үл хязгаарлагдан Нийлүүлэгч нь дараахь баталгааг өгнө. Үүнд:

- (а) Компанид нийлүүлсэн бүх бараа бүтээгдэхүүн болон түүнийг баглаж боох, савлах, тээвэрлэхэд хэрэглэсэн бүх материал (тээвэрлэхэд зориулсан жийрэг, сав баглаа, уяа боолт, хамгаалах материал зэрэг түр зуурын эсхүл орлуулгын төмөр материалыг оролцуулан, мөн үүгээр үл хязгаарлагдан) нь холбогдох хуулиар хориглосон аливаа бодисыг агуулаагүй;
- (б) Нийлүүлэгч нь дизайн, материалын үзүүлэлт, материалын сонголт ба үйлдвэрлэл, өөрийн нийлүүлэгчид болон туслан гүйцэтгэгчдийн хувьд Бараа бүтээгдэхүүн болон түүнийг савлах, тээвэрлэхэд хэрэглэсэн материалын бүрэлдэхүүнд аюултай бодис, холбогдох хуулиар хориглосон бодис ороогүй гэдгийг хянаж баталгаажуулахад тухайн цаг хугацаа бүрт түүнчлэн цаашид үргэлж хичээнгүйлэн хяналт тавьж ажиллана гэдэгт баталгаа өгнө.

## **7.4 Нийлүүлэгчийн нөхөн төлбөрийн баталгаа**

34-т заасныг үл хязгаарлан, хуулиар зөвшөөрөгдсөн хэм хэмжээнд Нийлүүлэгч нь 7.3-д заасан баталгаа болон холбогдох хууль тогтоомж болон Засгийн газрын эрх бүхий байгууллагаас гаргасан шаардлагыг зөрчсөнтэй холбоотойгоор Компанид учирсан хохирлыг барагдуулах эсхүл үүсэх бүх нөхөн төлбөрийг хариуцах тухай баталгааг гаргана.

## **8. Доголдол, зөрчил дутагдлыг арилгах**

### **8.1 Баталгаа**

Нийлүүлэгч нь бараа бүтээгдэхүүн бүрийн хувьд баталгаат хугацааны туршид гарсан аливаа доголдлыг арилгах тухайгаа батална.

### **8.2 Баталгаат хугацаа эхлэх**

Бараа бүтээгдэхүүн бүрийн хувьд Компанийн төлөөлөгч тухайн бараа бүтээгдэхүүнийг хүлээн авсныг бичгээр зөвшөөрөл олгосон өдрөөс баталгаат хугацаа эхэлнэ.

### **8.3 Доголдол, зөрчил дутагдлыг арилгах**

Нийлүүлэгч нь баталгаат хугацааны туршид бараа бүтээгдэхүүний алдаатай загвар дизайн, материал, хийц, худалдааны чанарыг үл хангасан эсхүл зориулалтын бус байдал зэргийн улмаас үүссэн аливаа зөрчил, дутагдлын талаар Компанийн төлөөлөгчийн мэдэгдлийг хүлээн авмагц уг зөрчил, дутагдлыг мэдэгдэлд заасан хугацаанаас өмнө, Компаниас ямар нэгэн зардал гаргуулахгүйгээр зохих ёсоор загвар дизайныг дахин боловсруулах, засах, солих ёстой.

### **8.4 Доголдолтой үйлчилгээг засах**

Нийлүүлэгч нь Гэрээ хэрэгжих хугацаанд холбогдох Үйлчилгээний аливаа доголдлын талаар Компанийн төлөөлөгчийн мэдэгдлийг хүлээн авмагц уг доголдлыг (тухайн доголдлыг засахад шаардлагатай арга зам бүхий нэмэлт үйлчилгээг оролцуулан) мэдэгдэлд заасан хугацаанаас өмнө, Компаниас ямар нэгэн зардал гаргуулахгүйгээр зохих ёсоор засах ёстой.

### **8.5 Доголдол, зөрчил дутагдлыг арилгахгүй байх**

Хэрэв Нийлүүлэгч нь (тухайн шаардлагатай тохиолдолд):

- (а) 8.3-д зааснаар Компанийн олж илрүүлсэн бараа, бүтээгдэхүүний доголдол, гологдлыг засч сайжруулаагүй (тухайн доголдол, гологдлыг заасан хугацаанд засах эсхүл шинээр солих болон зайлшгүй шаардлагатай загвар дизайныг дахин гаргах зэргийг оролцуулан) тохиолдолд,
- (б) 8.4-д зааснаар Компанийн олж илрүүлсэн холбогдох Үйлчилгээний аливаа доголдлыг засч арилгаагүй, эсхүл

Компани нь Нийлүүлэгчийн эрсдэл, зардлаар Нийлүүлэлтийн аливаа доголдлыг эсхүл Холбогдох үйлчилгээний зөрчил, дутагдлыг засч сайжруулж болох бөгөөд Компанид учирсан аливаа зардал нь Нийлүүлэгчийн Компанид төлөх ёстой өр болж үлдэнэ.

## 9. Нийлүүлэлтийн хугацааны хуваарь

---

### 9.1 Нийлүүлэлтийн хугацааны хуваарийг мөрдөх

- (a) Нийлүүлэгчийн Гэрээний үүргийн гүйцэтгэлд Цаг хугацаа хамгийн чухал зүйл юм.
- (б) Нийлүүлэгч нь ажлыг Нийлүүлэлтийн хугацааны хуваарийн дагуу гүйцэтгэх ёстой. Нийлүүлэгч нь Компанийн төлөөлөгчид Нийлүүлэлтийн хугацааны хуваарийг баримтлан Сайтад болон өөр хаа нэгтгээ хийгдэж буй бусад ажлыг хооронд нь уялдуулан зохицуулах боломжтой гэдгийг хүлээн зөвшөөрнө.

### 9.2 Нийлүүлэлтийн хугацааны хуваарьт нэмэлт өөрчлөлт оруулах

- (a) Хэрэв Нийлүүлэгч нь хэдийгээр бүхий л боломжит арга хэмжээг авсан боловч дор дурдсан шалтгааны улмаас Нийлүүлэлтийн хугацааны хуваарийн аль нэг хэсгийг эсхүл бүхэлд нь мөрдөх боломжгүй гэж үзвэл, холбогдох шалтгааныг нарийн тоочин, хойшилсон хугацааны үндэслэлийг тодорхой гаргаж Нийлүүлэлтийн хугацааны хуваарьт нэмэлт өөрчлөлт оруулах тухай мэдэгдэл бүхий өргөдлийг дор дурдсан үйл явдал болсноос хойш 14 өдрийн дотор Компанид өгөх ёстой. Үүнд:
  - (i) Компани Гэрээний аль нэг заалтыг зөрчсөн;
  - (ii) Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн;
  - (iii) 29.3-д зааснаар Сайтад нэвтрэх эрх саатсан эсхүл түр зогсоосон;
  - (iv) 32.3-д зааснаар Сайтад ажиллаж буй өөр бусад нийлүүлэгч, түүний ажилтнаас шалтгаалан саатсан;
  - (v) Компани Өөрчлөлт хийх болсон зэрэг болно.
- (б) Компани нь 9.2(a)-д зааснаар Нийлүүлэгчийн гаргасан өргөдлийг үндэслэлтэй гэж үзвэл Нийлүүлэлтийн хугацааны хуваарьт нэмэлт өөрчлөлт оруулах тухай мэдэгдэл гаргах ба энэ тохиолдолд тухайн нэмэлт өөрчлөлтийн улмаас Нийлүүлэгч нь гэрээний үнийг нэмэгдүүлэх эрхгүй бөгөөд аливаа хугацаа хоцрох асуудлыг бие даан хариуцаж хэрэв хугацаа сунгасантай холбоотойгоор тухайн нөхцөл байдалд Нийлүүлэгчид учирсан аливаа хохирол, зардлыг нөхөн төлөх нь шударга бөгөөд тэгш байдлын зарчмыг хангана гэж Компани (өөрийн үзэмжээр) анхаарч үзвэл уг нэмэлт зардлыг Нийлүүлэгчид төлж болно.
- (в) 9.2(a)-д зааснаар Нийлүүлэлтийн хугацааны хуваарьт нэмэлт өөрчлөлт оруулах тухай мэдэгдэл бүхий өргөдлийг Нийлүүлэгч гаргаснаас бусад тохиолдолд мөн тухайн нэмэлт өөрчлөлтийг Компани баталгаажуулаагүй нөхцөлд эсхүл түүнийг баталгаажуулах хүртэл Нийлүүлэгчийн хувьд Нийлүүлэлтийн хугацааны хуваарьт заасны дагуу Нийлүүлэлтийг гүйцэтгэж дуусгах үүргээ аливаа байдлаар эсхүл тодорхой хэмжээгээр сунгаж гэрээний хугацаанаас хоцрох аливаа шалтгаан, үндэслэл байхгүй. Нийлүүлэлтийн хугацааны хуваарьт нэмэлт өөрчлөлт оруулсан тохиолдолд Нийлүүлэгчийн хувьд Нийлүүлэлтийг гүйцэтгэж дуусгах үүргээ холбогдох хугацааны дотор (өөрчлөгдсөний дагуу) зохих хэмжээгээр биелүүлнэ.

## 10. Гэрээний хугацаа

---

Энэхүү гэрээ нь Эхлэх өдөр гэж тодорхойлсон хугацаанд эхлүүлэх бөгөөд гэрээнд заасны дагуу хугацаа дуусахаас өмнө цуцалсанаас бусад тохиолдолд түүний Үргэлжлэх хугацаанд хүчин төгөлдөр хэрэгжинэ.

## 11. Төлөөлөл

---

### 11.1 Гэрээний гүйцэтгэл

Нийлүүлэгч нь Гэрээний дагуу, гэрээнд заасан Компанийн төлөөлөгчийн удирдамж дор Нийлүүлэлт хийх ёстой.

### 11.2 Компанийн төлөөлөгч

- (a) Компанийн төлөөлөгч нь Компанийг төлөөлж түүний нэрийн өмнөөс Гэрээнд заасны дагуу удирдамж, чиглэл өгөх үүрэгтэй.
- (б) Компанийн төлөөлөгчөөс бусад хэн нэгэн этгээдийн Нийлүүлэгчид өгсөн удирдамж, чиглэлийг Компанийн төлөөлөгч баталгаажуулаагүй тохиолдолд Компанид холбогдолгүй байна.

### 11.3 Нийлүүлэгчийн төлөөлөгч

- (a) Нийлүүлэгчийн төлөөлөгч нь 11.2-д заасантай хамаарах аливаа асуудлаар Компанийн төлөөлөгчтэй харилцан уялдаатай ажиллах үүрэгтэй бөгөөд Гэрээнээс урган гарах бүхий л асуудлын хүрээнд Нийлүүлэгчийг хууль ёсоор төлөөлөх бүрэн хэмжээний эрх мэдэлтэй байна.
- (б) Компанийн төлөөлөгчөөс Нийлүүлэгчийн төлөөлөгчид өгсөн аливаа удирдамж, чиглэл нь Компанийн нэрийн өмнөөс Нийлүүлэгчид өгсөн гэж тооцогдох бөгөөд Нийлүүлэгч нь тухайн чиглэлийг мөрдөж ажиллах ёстой. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн хийсэн аливаа харилцаа холбоо, гарын үсэг зурсан баримт бичгүүдийг Нийлүүлэгч үйлдсэн гэж тооцогдох бөгөөд үүний хариуцлагыг Нийлүүлэгч хүлээнэ. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдэж буй асуудлын талаар Нийлүүлэгч мөн адил мэдэж байгаа гэж үзнэ.

- (в) Аль ч Тал нь гэрээний хугацааны туршид өөрийн төлөөлөгчийг буцаан татах буюу татгалзах эсхүл түүний оронд өөр хүнийг томилж болох бөгөөд уг Тал нь энэ тухай мэдэгдлийг нөгөө талдаа өгөх ёстой.

## 12. Хүргэлт, өмчлөх эрх, эрсдэл

---

### 12.1 Хүргэлт

Нийлүүлэгч нь бараа бүтээгдэхүүнийг Хүргэлтийн цэгт хүргэж өгөх ёстой.

### 12.2 Өмчлөх эрх

Дор дурдсан тохиолдлын аль түрүүлж биелэгдсэн цаг хугацаанд өмчлөх бүрэн эрх Компанид шилжин очно. Үүнд:

- (а) Компани нь тухайн бараа бүтээгдэхүүний үнийг Нийлүүлэгчид бүрэн төлсөн; эсхүл
- (б) Бараа бүтээгдэхүүн нь Хүргэлтийн цэгт (хэрэв байгаа бол) хүргэгдсэн бөгөөд 26 ба 27-д заасны дагуу зохих шалгалт, туршилтыг хийж, Компанийн төлөөлөгч хүлээн авсан зэрэг болно.

### 12.3 Эрсдэл

Бараа бүтээгдэхүүн бүрийн Хүргэлтийн цэгт хүргэгдэхээс өмнөх эрсдэлийг Нийлүүлэгч хүлээнэ.

## 13. Гэрээний үнэ

---

### 13.1 Гэрээний үнэ

**Гэрээний үнэ** гэдэг нь Нийлүүлэлт хийхтэй холбоотойгоор Компанийн Нийлүүлэгчид төлөх ёстой (14-д заасны дагуу төлөх ёстой аливаа Шууд бус гүйлгээний татварыг оролцуулахгүйгээр) нийт үнийн дүнг хэлнэ.

### 13.2 Гэрээний үнэд багтах зардал

- (а) Унааны ба томилолтын зардал, төлөх ёстой аливаа татвар хураамж зэргийг гэрээний үнэд багтаасан гэж үзэх бөгөөд мөн үүгээр үл хязгаарлагдан Нийлүүлэгчээс Нийлүүлэлт хийхтэй холбогдон гарах бүх зардал;
- (б) Нийлүүлэгч нь Гэрээний үнэд багтсан аливаа Гаалийн татварын дэлгэрэнгүй мэдээллийг Компанид тусад нь гаргаж өгөх ёстой.

### 13.3 Хүлэмжийн хийн ялгаруулалт

Энэхүү гэрээний аль нэг заалтыг үл харгалзан, дор дурдсан нөхцөл байдлын улмаас Нийлүүлэгч нь өөрийн эсхүл түүний хамтран ажиллагчийн хувьд хуулийн дагуу худалдааны зөвшөөрөл авах болон татвар хураамж төлөх, эсхүл төлөх үүрэг үүссэн тохиолдолд уг зардлыг Компаниас ямар нэгэн хэмжээгээр нөхөн олгохгүй. Үүнд:

- (а) Бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн болон нийлүүлэлтийн эсхүл Гэрээний дагуу үзүүлэх Холбогдох үйлчилгээг гүйцэтгэх явцад хүлэмжийн хий ялгаруулах; эсхүл
- (б) Нийлүүлэлт хийхэд зэрэг болно.

## 14. Татвар

---

### 14.1 Татвар, Шууд бус гүйлгээний татвар, Суутгах татвар

- (а) Нийлүүлэгч нь Татвартай холбогдох бүх хууль тогтоомж, зохицуулалт болон аль нэг Засгийн газрын эрх бүхий байгууллагын захиргааны шаардлагыг мөрдөх ба өөрийн зардлаар хариуцах үүргийг хүлээнэ.

- (б) Татвар төлөлт

- (i) Дор дурдсан 14.1(б)(ii)-д зааснаас бусад тохиолдолд Нийлүүлэгч нь энэхүү Гэрээнд заасан Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлттэй (эсхүл аливаа бараа бүтээгдэхүүний хүргэлт) холбоотойгоор дэлхийн аль ч орны Засгийн газрын аливаа захиргааны байгууллагын шаардлагын дагуу ногдуулсан бүх төрлийн татварыг төлөх (энэхүү 14 дүгээр заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор, суутгал болон хөнгөлөлтийн аль тохирохыг хэрэглэх нөхцөлөөр) үүргийг хүлээнэ. Үүнтэй холбоотойгоор Нийлүүлэгч нь Холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжих боломжтой Нэмэгдсэн Өртгийн албан татварын хөнгөлөлт болон буцаан олголтын өргөдлийг мэдүүлж, үүний бүхий л үр ашгийг хүртэхийн төлөө хүчин чармайлт гаргана.

Нийлүүлэгч нь бараа материал эсхүл түүний орцод (хэрэв байгаа бол) ногдуулсан импортын гаалийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлэхээр бол энэ талаар Компанитай зөвлөлдөн хамтран ажиллаж боломжийг эрэлхийлэх ба үүний төлөө өөрийн хүчин чармайлтыг гаргана. Нийлүүлэгчийн төлөх үүрэгтэй бүх татвар нь Гэрээний үнэд багтсан байх ба Гэрээний үнэ дээр нэмэгдэхгүй.

- (ii) Дор дурдсан 14.1(б)(iii)-т зааснаар Компани нь энэхүү Гэрээнд заасан Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлттэй (эсхүл аливаа барааны хүргэлт) холбоотойгоор Монгол Улсын Засгийн газрын эрх

бүхий байгууллагаас тогтоосон эсхүл ногдуулсан дараах төрлийн татваруудыг төлөх үүрэг хүлээнэ.  
Үүнд:

- (А) Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гүйцэтгэж буй холбогдох Үйлчилгээний (эсхүл хүргэж буй бараа бүтээгдэхүүн) хувьд Өмчлөгч нь дараахь төлбөрийг хариуцна.
    - (1) Монгол Улсын Нэмэгдсэн Өртгийн Албан Татварын тухай хуулийн (Монгол Улсын НӨАТ) 3-р бүлгийн дагуу тухайн үйлчилгээнд (бараа бүтээгдэхүүн) ногдуулсан аливаа нэмэгдсэн өртгийн албан татвар;
    - (2) Гэрээ хэрэгжиж Эхлэх өдрөөс хойш Монгол Улсын аль нэг онцгой албан татварын хэмжээ нэмэгдсэн эсхүл шинээр тогтоосны улмаас хүргэж буй барааны хувьд (хэрэв байгаа бол) тооцон ногдуулах онцгой албан татвар;
  - (Б) Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна гүйцэтгэж буй холбогдох Үйлчилгээний (эсхүл хүргэж буй бараа бүтээгдэхүүн) хувьд Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу тухайн үйлчилгээнд (эсхүл бараа бүтээгдэхүүн) ногдуулсан дүнг буюу Монгол Улсын НӨАТ, Монгол Улсын Гаалийн татвараар үл хязгаарлагдан аливаа татварын төлөлтийг хариуцна.
- (iii) Компани нь 14.1(б)-д дурдсан аливаа татварыг Монгол Улсын холбогдох эрх бүхий Татварын байгууллагад хэрэв шууд төлөхийг хуулиар зөвшөөрсөн бол шууд төлнө. Хэрэв шууд төлөхийг хуулиар зөвшөөрөөгүй бол Нийлүүлэгч нь уг татвар, хураамжийг төлөх ба тухайн төлбөрийг Компани Нийлүүлэгчид буцаан олгоно.
- (в) Нийлүүлэгч нь Компанид өгөх анхны нэхэмжлэхийг холбогдох бүх татварын байгууллагаас гаргасан хүчин төгөлдөр татвар төлөгчийн гэрчилгээний хамт ирүүлнэ. Хэрэв Нийлүүлэгч нь хүчин төгөлдөр татвар төлөгчийн гэрчилгээг Компанид өгөөгүй эсхүл тухайн гэрчилгээ нь Компанийн хувьд Монгол Улс ба Нийлүүлэгчийн оршин суугаа улс хоорондын давхар татварын гэрээний дагуу Нийлүүлэгчийг Монгол Улсын аливаа орлогын албан татвараас чөлөөлөгдөх болон хөнгөлөлт эдлэх эрхтэй гэж үзэх хангалттай үндэслэл болж чадахгүй тохиолдолд Нийлүүлэгч тухайн орлогын албан татварыг Монгол Улсын хуульд заасан хувиар төлөх үүрэг хүлээнэ.
- (г) Нийлүүлэгч нь Монгол Улсын нутаг дэвсгэрээс гаднаас болон Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээ бүрийн хувьд татварын нэхэмжлэхийг тусад нь гаргана.
- (д) Компанийн хүсэлтийг бичгээр хүлээж авмагц Нийлүүлэгч нь Компанид дор дурдсан мэдээллийг хүргүүлнэ.  
Үүнд:
- (i) Аль нэг Засгийн газрын агетлагаас Компанийн татвар төлөлтийн талаар мэдээлэл авах хүсэлтэд нийцүүлэн бүх мэдээлэл, шаардагдах маягуудыг байгууллагын бүртгэлийн гэрчилгээ ба НӨАТ-ийн бүртгэлийн гэрчилгээний хамт;
  - (ii) Худалдааны татварын нэхэмжлэхийг Компанийн тавьсан шаардлагыг хангасан хэлбэр, маягын дагуу;
  - (iii) Монгол Улсын НӨАТ-ын баримт бичгийг Монгол улсын НӨАТ-ын тухай хуульд заасан шаардлагад нийцүүлж, зохих маягын дагуу;
- (е) Хэрэв Нийлүүлэгч нь Монгол Улсад татвар төлөгч аж ахуйн нэгжээр бүртгэгдээгүй бол, Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шаардсан тохиолдолд Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс орлогын албан татварын дүнг суутгана. Нийлүүлэгчийн эхний татварын нэхэмжлэх ирсэн үеэс эхлэн Өмчлөгч нь өөрийн албан ёсны үүргийн дагуу орлогын албан татварыг Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс суутгаж, Засгийн газрын холбогдох эрх бүхий байгууллагад төлөх татвараас чөлөөлөгдөх ба тухайн татварын чөлөөлөлтийг нотлох төлбөрийн баримт эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг Нийлүүлэгчид хүргүүлнэ. Компанийн төлөх тухайн орлогын албан татварын дүн нь Гэрээний үнэд багтсан байх ба Гэрээний үнэ дээр нэмэгдэхгүй.
- (ё) Хэрэв Компанийн Нийлүүлэгчид төлсөн төлбөрт орлогын албан татварын суутгал багтаагүй боловч холбогдох хууль тогтоомжид тухайн суутгал хийхийг шаардсан тохиолдолд эсхүл Компанийн Нийлүүлэгчид төлөх төлбөрт орлогын албан татварын суутгал багтсан боловч холбогдох хууль тогтоомжид тухайн суутгалыг илүү өндөр хувиар хийхийг шаардсан тохиолдолд Нийлүүлэгч нь суутгагдах ёстой байсан эсхүл илүү өндөр хувиар суутгагдах ёстой байсан дүнгийн үндэслэл болж буй албан ёсны төлбөрийн баримт (эсхүл түүний баталгаажсан хуулбар)-ийг хүлээн авсанаас 14 хоногийн дотор суутгагдах эсхүл илүү өндөр хувиар суутгагдах ёстой байсан дүнг Компанид буцаан төлнө.
- (ж) Нийлүүлэгч эсхүл аливаа туслан гүйцэтгэгчийн Татварын тухай хуулинд холбогдох хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас үүссэн аливаа болон бүх хүлээх хариуцлага, нэхэмжлэл шаардлага, хохирол,

зардлаас (өмгөөлөгчийн төлбөр, торгууль, шийтгэл, алданги зэргийг багтаана) Компанийг чөлөөлөх ба түүнийг Компанид нөхөн төлөх, Компанийг эрх ашгийг хамгаалах үүрэгтэй.

- (з) Хэрэв Нийлүүлэгч нь Монголд Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж бөгөөд Гэрээнд Компани нь Нийлүүлэгчийг орон байр, хоол хүнсээр болон нислэгийн зардлыг хангана гэж тусгасныг хүлээн зөвшөөрч буй бол,
- (i) Компани тухайн орон байр, хоол хүнс, нислэгийн НӨАТ-ийг багтаасан зардлын дүнд ногдох Татварын нэхэмжлэх гарган Нийлүүлэгчид хүргүүлнэ;
  - (ii) Компаниас ирүүлсэн нэхэмжлэхийн дүнтэй тэнцүү дүнгээр Нийлүүлэгч Компанид нэхэмжлэх гаргаж болно.

#### **14.2 Компанийн гаалийн татвар**

- (а) Компани бараа бүтээгдэхүүнийг Тээврийн зардлыг багтаасан дүнгээр худалдан авахаар сонгосон тохиолдолд Нийлүүлэгч нь:
- (i) аль нэг Засгийн газрын эрх бүхий байгууллагаас ногдуулсан эсхүл түүнд төлөх шаардлагатай бүх гаалийн татвар мөн бусад аливаа гадаад тээвэрлэлтийн зардлын төлбөрийг хариуцна.
  - (ii) шаардлагатай нөхцөлд, Хоёр талт чөлөөт худалдааны гэрээг (эсхүл түүнтэй дүйх) хэрэглэх замаар гаалийн татваргүйгээр Бараа бүтээгдэхүүнийг импортлох боломжтой эсэхийг тодорхойлно.
- (б) Ашиглаж буй тээвэрлэлтийн нөхцөлөөс үл хамааран Нийлүүлэгч нь Компанийн хүсэлтээр гаалийн татварын хөнгөлөлтийн тохиролцоо эсхүл Хоёр талт чөлөөт худалдааны гэрээний (эсхүл түүнтэй дүйх) дагуу өргөдөл гаргах болон гэрчилгээ авахтай холбоотойгоор холбогдох хууль тогтоомжийг мөрдөхөд шаардлагатай бүх мэдээлэл, баримт бичгээр Компанийг хангана. Компанийн гаргасан тухайн өргөдөл амжилттай шийдвэрлэгдсэн тохиолдолд Нийлүүлэгч нь Гаалийн татварын буцаан олголтыг авах ба гаалийн татварын аливаа хэмнэлтийг Компанид шилжүүлнэ.
- (в) Ашиглаж буй тээвэрлэлтийн нөхцөлөөс үл хамааран Нийлүүлэгч нь холбогдох тээвэр зуучийн компанийг Бараа бүтээгдэхүүнийг хүргэхээс өмнө Гэрээнд тодорхойлсон бүх баримт бичгээр хангах үүрэгтэй. Компани тээврийн зардлыг хариуцаж буй тохиолдолд Нийлүүлэгч нь баримт бичгийн бүрдэл дутуу эсхүл алдаатай байгаа тохиолдолд Компанийн тээвэр зуучийн компани Бараа бүтээгдэхүүнийг хүлээн авахаас татгалзаж болохыг, мөн түүнчлэн баримт бичиг бүрэн гүйцэд бөгөөд алдаагүй зөв болох хүртэл Бараа бүтээгдэхүүнийг хүргэгдсэнд тооцохгүй болохыг хүлээн зөвшөөрнө.

### **15. Нийлүүлэгчид төлөх төлбөр**

#### **15.1 Төлбөрийн хэлбэр**

Гэрээнд өөрөөр заагаагүй бол, Компаниас Нийлүүлэгчид Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлттэй холбоотойгоор Гэрээний дагуу хийх бүх төлбөр нь Нийлүүлэгчийн өгсөн банкны данс уруу цахим шилжүүлгийн аргаар буюу бэлэн бус хэлбэрээр, Хавсралт С (Үнэ)-д заасан валютаар хийгдэнэ.

#### **15.2 Татварын нэхэмжлэх**

- (а) Компанитай тусгайлан зөвшилцсөнөөс бусад тохиолдолд Нийлүүлэгч нь Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт хийхтэй холбогдон гарах Татварын нэхэмжлэхийг Нийлүүлэлт хийгдсэн хугацааны сар бүрийн эцэст Хавсралт С (Үнэ)-д заасан жишгээр үнэ, төлбөр болон бусад мөнгөн дүнг тооцоолж Компанид хүргүүлэх ёстой.
- (б) Татварын нэхэмжлэл нь Компанийн хүлээн зөвшөөрсөн маягтын дагуу байх бөгөөд дор дурдсан мэдээллийг агуулсан байх ёстой. Үүнд:
- (i) Татварын нэхэмжлэхийн холбогдож буй Худалдан авах захиалгын дугаар;
  - (ii) Татварын нэхэмжлэхийн хамарч буй хугацаанд гүйцэтгэсэн Нийлүүлэлтийн товч тодорхойлолт;
  - (iii) Татварын нэхэмжлэлтэй холбоотой Компанийн шаардсан үндэслэл бүхий аливаа хяналт, нэмэлт баталгаа болон баримт бичиг зэрэг болно.

#### **15.3 Татварын нэхэмжлэхийн төлбөр**

Компани нь 15.4, 17, 21.4, 37.4, 39.2(б)-д заасны дагуу Татварын нэхэмжлэхийг хүлээн авсанаас хойш 30 хоногийн дотор Татварын нэхэмжлэхийг үндэслэн түүнд заасан мөнгөн дүнг Нийлүүлэгчид төлөх ёстой.

#### **15.4 Маргаан бүхий татварын нэхэмжлэх**

Хэрэв Компани нь Татварын нэхэмжлэхэд дурдсан аль нэг мөнгөн дүнг маргаантай гэж үзвэл энэ тухайгаа Нийлүүлэгчид Татварын нэхэмжлэх хүлээн авснаас хойш 21 өдрийн дотор мэдэгдэх ёстой ба 15.3-д заасны дагуу хүлээн зөвшөөрч буй аливаа мөнгөн дүнг төлөх шаардлагатай бөгөөд хэрэв маргаан бүхий татварын нэхэмжлэхийн



дагуу Компани төлбөр төлсөн тохиолдолд Компанийг уг төлбөрийн дүнг эсхүл түүнийг төлөх хариуцлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцохгүй.

#### 15.5 Нэхэмжлэхийн алдаа ба онцгой тохиолдол

15.3-д зааснаар үл хязгаарлагдан, хэрэв Нийлүүлэгч нь Нийлүүлэлтийн нэхэмжлэхтэй холбоотойгоор ямар нэг алдаа болон онцгой тохиолдлыг олж илрүүлэх эсхүл энэ тухай сануулга авсан тохиолдолд түүнийг Нийлүүлэгч ба Компани хамтран хэлэлцэж, шаардлагатай бол Нийлүүлэгч нь яаралтай засах арга хэмжээ авч тухайн нэхэмжлэхэд өөрчлөлт оруулах эсхүл илүүдэл төлбөрийг буцаан олгох арга хэмжээ авна.

#### 16. Цахим худалдаа

---

##### 16.1 Нийлүүлэгчийн цахим худалдааны талаар хүлээх үүрэг

Нийлүүлэгч цахим худалдааны боломжийг тодорхойлохын тулд өөрийн бизнесийн явцад тогтмол хяналт тавьж ажиллах бөгөөд Компанитай харилцахдаа эдгээр боломжийг түлхүү хөгжүүлж хэрэглэхийн төлөө хүчин чармайлт гаргах ёстой.

##### 16.2 Цахим худалдааны зардал

Гэрээний талууд нь цахим худалдааны системийг хэрэглэхтэй холбоотойгоор гарах зардал, үүний тулд өөрсдийн ажиллагааны системд өөрчлөлт оруулахад шаардагдах төлбөр, хураамжийг өөрсдөө хариуцна.

#### 17. Төлбөрийн суутгал

---

##### 17.1 Суутгал тооцох

Компани нь:

- (a) 15.3-д заасны дагуу Нийлүүлэгчид төлөх ёстой эсхүл төлөхөөр болсон аливаа төлбөрөөс дараахь дүнгээр (Мөн 14 зүйлийн дагуу төлөх ёстой хасалттай холбоотойгоор Шууд бус гүйлгээний татварыг оролцуулан) хасалт хийж болно. Үүнд:
  - (i) Нийлүүлэгч, түүний ажилтнаас Компанид төлөх ёстой бүх өр төлбөр ба мөнгөн дүн;
  - (ii) Нийлүүлэгч, түүний ажилтны хариуцах, Компанид төлөх эсхүл буцаан олгох ёстой хариуцлага болон төлбөрийг Компани хүлээсэн, төлсөнтэй холбоотой бүх төлбөрийн дүн (Гэрээнд заасны дагуу аливаа нөхөн төлбөрийг оролцуулан);
  - (iii) Компанийн хүлээн зөвшөөрөх стандартаас доогуур Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт эсхүл Бараа бүтээгдэхүүний эвдрэл гэмтлийг нөхөх зардлын дүн; түүнчлэн
- (б) Энэхүү Гэрээнд заасан Компанийн эрхийг хөндөхгүйгээр, хэрэв Нийлүүлэгч нь Гэрээгээр хүлээсэн аль нэг үүргээ гүйцэтгээгүй бол тухайн асуудлыг бүрэн засч залруулах хүртэл Гэрээний дагуу Нийлүүлэгчид төлбөл зохих төлбөрөөс хэсэгчилэн эсхүл бүхэлд нь мэдэгдэл хүргүүлэхгүйгээр суутгаж болно.

##### 17.2 Хуулийн дагуух суутгал, хасалт

- (a) Хэрэв Компани нь хуульд заасан шаардлагын дагуу Гэрээний дагуу төлөх ёстой үнийн дүнгээс ямар нэг хэмжээг (**Суутгасан дүн**) суутгах, хасах тохиолдолд тухайн суутгах эсхүл хасалт хийсэн хэмжээний төлбөрийг Нийлүүлэгчид төлсөн гэж тооцогдох бөгөөд Компани нь Суутгасан дүнгийн тооцооноос Нийлүүлэгчид ямар нэгэн төлбөр төлөх хариуцлагыг хүлээхгүй.
- (б) Хэрэв Компани нь Суутгасан дүнг төлөхөөс зохих ёсоор суутгаагүй эсхүл хасалт хийгээгүй бол дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлж болно. Үүнд:
  - (i) Хасалт хийсэн дүнтэй тэнцүү хэмжээний төлбөрийг шаардсан мэдэгдлийг Нийлүүлэгчид өгөх бөгөөд Нийлүүлэгч нь мэдэгдэл хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор уг төлбөрийг Компанид төлнө;
  - (ii) Компаниас Нийлүүлэгчид төлөх ёстой аливаа мөнгөн дүнгээс хасалт хийсэн дүнтэй тэнцүү хэмжээг хасч болох бөгөөд ийнхүү хассан хэмжээний төлбөрийг Нийлүүлэгчид төлөгдсөн гэж тооцох бөгөөд хасалт хийсэн дүнгийн тооцооноос ямар нэг хэмжээг Нийлүүлэгчид төлөх хариуцлагыг Компани хүлээхгүй; эсхүл
  - (iii) 17.2.(б)(i)-д заасан шаардлага болон 17.2.(б)(ii)-д заасан хэмжээгээр хийх суутгал, хасалтыг хамтад нь Суутгасан дүнд тусгаж болох бөгөөд,

дээрх тохиолдол бүрийн хувьд Нийлүүлэгчийн аливаа үйлдэл, эс үйлдэхүй болон санамсаргүй байдлын улмаас Суутгасан дүнг төлөхөөс зохих ёсоор татгалзаагүй эсхүл хасалт хийгээгүй бөгөөд Суутгасан дүнтэй холбоотойгоор Компанийн төлбөл зохих аливаа торгууль, шийтгэл эсхүл хүүг Суутгасан дүнд оруулж тооцно.

### 17.3 Суутгал, хасалт тооцох тухай мэдэгдэх

Компани нь суутгал эсхүл хасалт хийсэн аливаа дүн хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Нийлүүлэгчид 17.1 ба 17.2-д заасны дагуу мэдэгдэх ёстой.

### 18. Хувилбарт нийлүүлэлт

#### 18.1 Хувилбарт нийлүүлэлт

Нийлүүлэгч нь ямар нэгэн шалтгааны (Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал, хүчин зүйлийг оролцуулан) улмаас Гэрээний дагуу Нийлүүлэлтийн аль нэг эсхүл бүх хэсгийг гүйцэтгэх боломжгүй болсон бол Компани нь Нийлүүлэлтийн тухайн хэсгийг аль нэг гуравдагч талаас (**Хувилбарт нийлүүлэлт**) авах шийдвэрийг дангаараа гаргаж болно.

#### 18.2 Нийлүүлэгч нэмэгдэл зардлыг хариуцах

(а) Компани нь 18.1-д заасан өөрийн эрхийн хүрээнд Хувилбарт нийлүүлэлт авахаар болсон бөгөөд хэрэв Үйлчилгээний нэг хэсэг эсхүл түүний бүх хэсгийг гүйцэтгэх чадваргүй байдал нь дор дурдсанаас бусад шалтгааны улмаас үүссэн бол Нийлүүлэгч нь уг Хувилбарт нийлүүлэлтийг авахтай холбоотойгоор Компаниас гарсан бүх нэмэлт зардлыг (нийлүүлэлтийн гинжин хэлхээний үнийн зөрүүг оролцуулан) хариуцна. Эдгээр нь:

- (i) Нийлүүлэгч нь Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас;
- (ii) Компанийн үйлдэл эсхүл эс үйлдэхүйн шууд үр дүнд чадваргүй болсон.

(б) Компани нь 18.1-д заасан өөрийн эрхийн хүрээнд Хувилбарт нийлүүлэлтийг аль болох бага зардлаар олж авахын төлөө боломжит хүчин чармайлтыг гаргах ёстой.

### 19. Нийлүүлэгчийн мэдээлэл, данс ба бүртгэл тооцоо

#### 19.1 Мэдээллээр хангах

Нийлүүлэгч нь Компанийг Нийлүүлэлт хийхтэй холбоотой түүний шаардсан аливаа мэдээллээр хангах ёстой.

#### 19.2 Нийлүүлэгч данс, бүртгэл тооцоог хөтлөх

Нийлүүлэгч нь:

- (а) Данс, бүртгэл тооцоог хянуур, бүрэн гүйцэт байдлаар хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн зарчмын дагуу хөтлөх ёстой; бөгөөд
- (б) Гэрээний үргэлжлэх хугацаа дууссан эсхүл Гэрээг түүнээс өмнө цуцалсанаас хойш доод тал нь 2 жилийн туршид 19.2 (а)-д заасны дагуу мэдээллийг Нийлүүлэгч, түүний бүх ажилтнууд хадгалж байгаа гэдэгт баталгаа гаргах ёстой.

#### 19.3 Нийлүүлэгч мэдээлэл авах боломжоор хангах

(а) 19.1-д зааснаас гадна Нийлүүлэгч, түүний ажилтан нь дараах зүйлсийг нотлох зорилгоор өөрсдийн данс, санхүүгийн бүртгэл, тооцоо, баланс, албан бичиг, санхүүгийн баримт, эрхийн бичиг болон бусад холбогдох баримт бичгийн (цахим хэлбэрээр хадгалагдаж буй баримт бичгийг оролцуулна) талаар мэдээлэл авах эрхийг Компанид зөвшөөрөх ёстой. Үүнд:

- (i) Гэрээний үнэ, түүнд оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг оролцуулан;
- (ii) Төлбөл зохих (эсхүл эсрэгээр) аливаа Шууд бус гүйлгээний татвар; болон
- (iii) Гэрээний дагуу Нийлүүлэгчид төлөх ёстой буюу Нийлүүлэгчийн нэхэмжилсэн аливаа бусад мөнгөн дүн зэрэг болно.

(б) Компани нь 19.3(а)-д дурдсан аливаа зүйлсийн хуулбар хийх болон хадгалж болно.

### 20. Компанийн аудит хийх эрх

#### 20.1 Нийлүүлэгчийн гүйцэтгэлд аудит хийх эрх

19-д заасан эрхээс гадна Нийлүүлэгч, түүний ажилтан нь дараах зүйлсийг хэрхэн мөрдөж байгаа эсэхийг баталгаажуулах, хянах болон аудит хийх шаардлагаар Нийлүүлэгчийн үл хөдлөх хөрөнгө, түүний аливаа баримт бичиг, мэдээллийн (цахим хэлбэрээр хадгалагдаж буй баримт бичгийг оролцуулна) талаар мэдээлэл авах эрхийг болон Нийлүүлэгчийн ажилтнаас Нийлүүлэлттэй холбоотойгоор ярилцлага авахыг Компанид зөвшөөрөх ёстой. Үүнд:

- (а) **(ЭАБ)-ны Удирдлагын Төлөөлөгөө** болон 27-д заасан эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, байгаль орчны нөхцөл;
- (б) 29-д тодорхойлсон Компанийн бодлого.

## 20.2 Нийлүүлэгчийн авах арга хэмжээ

20.1-д заасан аливаа нөхцөл, бодлого, стандартыг Нийлүүлэгч мөрдөж ажиллаагүй тохиолдолд Компанийн хэрэгжүүлэх аливаа бусад болон эрхийг хамгаалсан хэрэгслүүдээр үл хязгаарлагдан, 20.1-ийн дагуу аудит явуулахад хэрэв зөрчил, дутагдал илэрсэн бол Нийлүүлэгч нь түүнийг яаралтай засч залруулах арга хэмжээг авах ёстой бөгөөд энэ тухайгаа Компанид мэдэгдэнэ.

## 21. Гүйцэтгэлийн баталгаа

### 21.1 Баталгаа

Нийлүүлэгч Компанийн бичгээр гаргасан хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, нөхцөлт бус, үл буцах хэлбэрээр төлөгдөх банкны баталгааг Компанид өгөх ёстой. Гүйцэтгэлийн баталгаа нь:

- (a) Компанийн өөрийн хүлээн зөвшөөрсөн банкнаас;
- (b) Хавсралт А-д заасан маягтын дагуу эсхүл Компанийн хүлээн зөвшөөрөх бусад хэлбэрээр;
- (в) Гэрээний үнийн эсхүл энэхүү 21.1-д зааснаар Компанийн хүсэлт гаргасан өдрийн байдлаар Гэрээний үнийг тодорхойлох боломжгүй тохиолдолд Нийлүүлэлт хийхтэй холбоотойгоор Нийлүүлэгчид Компаниас төлөх боломжтой гэж тооцоолсон нийт үнийн 10 хувьтай тэнцэх дүнтэй байна.

(Баталгаа).

### 21.2 Нэмэлт баталгаа

Хэрэв 6.1(б)-д зааснаар, гэрээнд оруулсан өөрчлөлтийн улмаас Гэрээний үнэ нэмэгдсэн бол (баримт бичгээр нотлогдсон байх) Нийлүүлэгч Компанийн бичгээр гаргасан хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор уг баталгааны нийт дүн нь шинэчилсэн гэрээний үнийн 10 хувьтай тэнцүү эсэхийг баталгаажуулсаны үндсэн дээр нэмэгдүүлж эсхүл өөрчлөн Компанид өгөх ёстой.

### 21.3 Тэмдэгтийн хураамж ба бусад татвар

Нийлүүлэгч баталгаа болон аливаа нэмэлт баталгаа гаргахтай холбоотойгоор төлөгдөх бүх тэмдэгтийн хураамж, татварыг уг баталгааг Компанид гаргаж өгөхөөс өмнө төлсөн байх ёстой.

### 21.4 Баталгаа гаргахаас өмнө төлбөр хийхгүй байх

Энэхүү гэрээний аль нэг заалтыг үл харгалзан, Нийлүүлэгч гүйцэтгэлийн баталгаа, аливаа нэмэлт баталгааг Компанид гаргаж өгөх хүртэл Компани ямар нэгэн төлбөр төлөх үүрэггүй бөгөөд 21.1, 21.2-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд Компанийн хүсэлтэд нийцүүлэн төлж болно.

### 21.5 Баталгаа чөлөөлөх өдөр

Компани нь гэрээний үүргийн биелэлтийг хангуулах зорилгоор Гүйцэтгэлийн баталгааг гаргуулах бөгөөд баталгааг:

- (a) Нийлүүлэгч Гэрээнийн дагуу хүлээсэн үүрэг, үүсч болох бусад бүх үүргээ биелүүлж дууссан өдөр (Баталгааг хугацааг оролцуулан);
- (b) Нийлүүлэгчээс Гэрээний дагуу Компанид төлөх ёстой бүх мөнгөн төлбөр төлөгдөж дууссан өдөр чөлөөлнө.

(Баталгаа чөлөөлөх өдөр).

### 21.6 Баталгааг үргэлжлүүлэх

- (a) Хэрэв Компани нь Нийлүүлэгчийг Гэрээнд заасны дагуу үүргээ биелүүлээгүй (үндэслэлтэй байх) гэж үзсэн эсхүл Нийлүүлэгчийн эсрэг (Гэрээнд хамаарах эсхүл үл хамаарах асуудлаар болон өөрийн эрхийн хүрээнд буюу итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх хэмжээгээр) нэхэмжлэх, шаардлага гаргасан тохиолдолд баталгааг хэвээр үлдээж болно.
- (b) Энэхүү гэрээний аль нэг заалтыг үл харгалзан, баталгааг гүйцэтгүүлэхтэй холбоотойгоор Нийлүүлэгчийн буруугаас үүссэн эсхүл учирсан аливаа өр төлбөрийг Компани хариуцахгүй.
- (в) Нийлүүлэгч нь дараахь тохиолдлын алинд ч аливаа эрхийг хэрэгжүүлэхийг огтхон ч хөндөхгүй байж, хориглосон эсхүл хязгаарласан ямар нэгэн арга хэмжээ авахгүй гэдгээ хүлээн зөвшөөрнө. Үүнд:
  - (i) Баталгааг гүйцэтгүүлсэний орлогоос Компанийн авч ашиглаж буй аливаа мөнгөн дүн;
  - (ii) Компани Баталгаанд заасан аливаа эрхээ хэрэгжүүлэх;
  - (iii) Баталгаа гаргагч Баталгаанд заасан өөрийн эрх, үүргийг хэрэгжүүлэх зэрэгт саад болохгүй.

### 21.7 Баталгааг буцаах

- (a) Компани нь 21.7-д зааснаар баталгаа чөлөөлөх өдрөөс хойш 30 хоногийн дотор баталгааг Нийлүүлэгчид буцаах ёстой.

- (б) Аливаа Баталгааг Нийлүүлэгчид буцаахаас өмнө Нийлүүлэгч Хавсралт В-д заасны дагуу чөлөөлөх хүсэлтийг гаргаж урьдчилан хүргүүлсэн байх ёстой.

## **22. Гуравдагч талын одоогийн нийлүүлэлтийг үргэлжлүүлэх**

---

Нийлүүлэгч нь:

- (а) Гэрээ хэрэгжиж Эхлэх өдрийн байдлаар Компани болон гуравдагч талын нийлүүлэгч хооронд нийлүүлэлт хийх тодорхой ажиллагаа явагдаж байгаа;
- (б) 22(а) зүйлд хамрагдсан аливаа нийлүүлэлтийн ажиллагааг солих, өөрчлөх болон цуцлах үүргийг Компани нь Нийлүүлэгчийн өмнө хүлээгээгүй гэдгийг хүлээн зөвшөөрнө.

## **23. Худалдан авалтын доод хэмжээ байхгүй ба онцгой эрх олгохгүй байх**

---

### **23.1 Худалдан авалтын доод хэмжээ байхгүй байх**

Нийлүүлэгчээс авах Нийлүүлэлтийн доод түвшинг шаардах буюу худалдан авах үүргийг Компанид хүлээлгэсэн тухай Гэрээний аль ч хэсэгт заагаагүй болно.

### **23.2 Онцгой эрх олгохгүй байх**

Гэрээ нь бараа бүтээгдэхүүний Нийлүүлэлт (эсхүл түүний аль нэг хэсэгт) холбоотойгоор Компани ба Нийлүүлэгчийн хооронд онцгой эрх бүхий харилцаа үүссэнийг нотлох үндэслэл биш бөгөөд мөн ийм харилцааг үүсгэхгүй.

## **24. Нийлүүлэгчийн ажиллах хүч, барилга байгууламж, тоног төхөөрөмж**

---

### **24.1 Нийлүүлэгчийн ажиллах хүч**

Нийлүүлэгч нь бараа бүтээгдэхүүний Нийлүүлэлтийг чанартай гүйцэтгэхэд зайлшгүй хэрэгцээтэй бүх ажилтныг ажиллуулах шаардлагатай. Тухайн ажилтан нь холбогдох чадварын шаардлага хангасан, өрсөлдөх чадвар бүхий, өөрийн хариуцан ажиллаж буй Нийлүүлэлтийн холбогдох хэсгийг гүйцэтгэх чадвартай байх ёстой.

### **24.2 Ажиллах хүчний тохиролцоо**

Нийлүүлэгч нь бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн аливаа хэсгийг гүйцэтгэхэд оролцож буй Нийлүүлэгчийн бүх ажилтан нь Оюуны өмчийн эрх, Нууц мэдээлэл, олон нийтэд зарлан мэдээлэх болон бизнесийн стандартын талаар 40, 41, 42, 45, 46, 47–д заасан зохицуулалтыг мөрдөж ажиллана гэдгийг баталгаажуулах ёстой.

### **24.3 Нийлүүлэгчийн ажиллах хүчний талаарх мэдээлэл**

- (а) Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн Нийлүүлэгч нь Компанийн төлөөлөгчийг Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтд хяналт тавьж ажиллах өөрийн ажилтантай холбогдох Нийлүүлэгч байгууллагын дотоод зохион байгуулалт, албан тушаал буюу хийж гүйцэтгэх ажил үүрэг, тайлагнах журмын талаар дэлгэрэнгүй тусгасан ажиллах хүчний хуваарь бүхий мэдээллээр хангах ёстой.
- (б) Нийлүүлэгч нь Гэрээ хэрэгжих хугацааны туршид 24.3(а)-д заасны дагуу өгсөн ажиллах хүчний хуваарьт албан тушаал солигдсон болон тайлагналын журам өөрчлөгдсөний улмаас оруулсан аливаа өөрчлөлтийн талаар Компанийн төлөөлөгчид нэн даруй мэдэгдэх ёстой.
- (в) Нийлүүлэгч нь Сайтад ажил гүйцэтгэж байгаа өөрийн ажиллах хүчний шинэчилсэн жагсаалтыг бүхий л хугацаанд хадгалах ёстой.

### **24.4 Компани ажилтнуудаас татгалзах**

Компани нь Нийлүүлэгчийн аливаа ажилтныг зохих туршлага, чадварын хувьд дутмаг, хууль бус үйл ажиллагаанд оролцсон, өрсөлдөх чадваргүй эсхүл хайхрамжгүй байдал гаргасан тохиолдолд Компанийн төлөөлөгчийн саналаар ажиллуулахаас татгалзаж болно. Нийлүүлэгч нь Компанийн төлөөлөгчөөс тухайн ажилтныг ажлаас халах, түүнчлэн Компанийн төлөөлөгчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр Нийлүүлэлттэй холбоотойгоор дахин ажилд авч ажиллуулахгүй байхыг шаардсан мэдэгдлийг хүлээн авмагц түүний дагуу уг ажилтныг солих ёстой. Түүнчлэн, Нийлүүлэгч нь тухайн халагдсан ажилтны оронд зохих чадварын шаардлага хангасан, өрсөлдөх чадвар бүхий, дадлага туршлагатай, зөвшөөрөгдсөн ажилтныг өөрийн зардлаар сольж ажиллуулах ёстой.

### **24.5 Нийлүүлэгчийн хариуцлага**

Нийлүүлэгч нь:

- (а) Өөрийн ажилтнуудын Сайт дээр ажиллах үед хөдөлгөөнд оролцоход хэрэглэгдэх бүх автомашин, жолооч нар нь зохих журмаар зөвшөөрөл авсан байх ёстой бөгөөд бүх машин нь холбогдох замын аюулгүй байдал, замын хөдөлгөөний хууль, дүрэм, зохицуулалтыг дагаж мөрдөх ёстой;
- (б) Гэрээний дагуу Нийлүүлэлт хийхэд зайлшгүй шаардлагатай бүх ажил, тавигдах хяналт, багаж, тоног төхөөрөмж, материал, аюулгүй байдал зэргийг хариуцах; бөгөөд

- (в) Өөрийн ажилтны эрүүл мэнд ба аюулгүй байдлыг хариуцаж ажиллана.

#### **24.6 Компанийн барилга байгууламж**

- (а) 24.5 ба 24.6(б)-д заасны дагуу Компани нь тухайн газар холбогдох барилга байгууламжтай байгаа тохиолдолд уг барилга байгууламжийг Нийлүүлэлт хийхтэй холбоотойгоор Нийлүүлэгч, түүний ажилтнууд хэрэглэх боломжтой байна. Нийлүүлэгч нь Нийлүүлэлт хийхэд хэрэглэх шууд ашиглалтанд байхгүй боловч бэлэн болгох боломжтой (Компанийн тодорхойлсоноор) аливаа шаардлагатай байгууламжийг хариуцах үүрэгтэй.
- (б) Нийлүүлэгч нь Компанийн барилга байгууламжийг ашиглахтай холбоотой шаардлагын талаар Компанийн төлөөлөгчид 7-оос доошгүй хоногийн өмнө мэдэгдэх шаардлагатай. Компанийн аливаа барилга байгууламжийг хэрэглэх нөхцөл шаардлагыг Компани өөрөө тогтооно.
- (в) Нийлүүлэгч нь Сайт ба барилга байгууламжийг бүхий л хугацааны туршид цэвэр цэмцгэр, эмх цэгцтэй, аюулгүй байдлаар хэрэглэх бөгөөд тэдгээрийг яаралтай тохиолдолд шууд ашиглахад бэлэн байлгах ёстой.

#### **24.7 Зөрчил, дутагдалтай зүйлс**

- (а) Компанийн төлөөлөгч нь аливаа зөрчилтэй гологдол материал, үйлдвэрлэл, машин механизм, техник хэрэгслүүдээс татгалзах, тэдгээрийг Сайтаас нүүлгэн шилжүүлэх, зайлуулахыг шаардаж болох бөгөөд түүнчлэн Компанийн төлөөлөгчийн Гэрээний биелэлт гүйцэтгэлд зайлшгүй шаардлагатай гэж үзсэн аливаа зүйлсийг нэмж солих хүсэлтийг гаргаж болно.
- (б) Хэрэв Нийлүүлэгч нь Компанийн төлөөлөгчийн гаргасан дээрх татгалзал эсхүл хүсэлтийг энэ тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор биелүүлээгүй тохиолдолд, Компани уг материал, үйлдвэрлэлийн байгууламж, машин механизм болон техник хэрэгслүүдийг Нийлүүлэгчийн тохирох зардлаар нэмэгдүүлж эсхүл сольж болно.

### **25. Бараа бүтээгдэхүүний сав баглаа боодол, ачилт, тээвэрлэлт**

---

#### **25.1 Нийлүүлэгчийн хариуцлага**

Нийлүүлэгч нь Бараа бүтээгдэхүүний сав баглаа боодол, Хүргэлтийн цэг хүртэлх тээвэрлэлтийг өөрийн зардлаар хариуцна.

#### **25.2 Тээвэрлэлтийг Компани хариуцах**

Гэрээний нөхцөлийн дагуу Компани нь Бараа бүтээгдэхүүний зарим эсхүл бүх хэсгийн тээвэрлэлтийг хариуцах үүрэг хүлээсэн бол, Нийлүүлэгч нь ачихад бэлэн болсон Бараа бүтээгдэхүүний тухай дэлгэрэнгүй мэдээллийг тээвэрлэлтийн зохицуулалт хийх хангалттай цаг хугацааны өмнө Компанийн төлөөлөгчид мэдэгдэнэ.

#### **25.3 Тээвэрлэлтийн бэлтгэл**

Нийлүүлэгч нь барааг Хүргэлтийн цэг хүртэл тээвэрлэхдээ тохирох тээврийн нөхцөлийг дамжин өнгөрөх цаг агаарын онцлог байдалд нийцүүлэн тогтсон сайн туршлагын дагуу болон энэхүү Гэрээнд заасан сав баглаа боодол, тэмдэглэгээ хийх зааврыг мөрдлөг болгон, ачихад бэлэн болсон бүх Барааны савлалт, баглаа боодол, хамгаалалтыг сайтар хийх ёстой. Нийлүүлэгч нь тээвэрлэлтэнд яваа буюу дамжин өнгөрөх Барааг ачих, буулгахад шаардлагатай бүхий л багаж, тоног төхөөрөмжөөр хангах зохицуулалтыг хийх ёстой.

#### **25.4 Илгээсэн өдрийг мэдэгдэх**

Нийлүүлэгч нь Компанийн төлөөлөгчид бараа тус бүрийн илгээсэн өдөр ба Хүргэлтийн цэгт очихоор тооцоолсон өдрийг тухай бүрт мэдэгдэх ёстой.

### **26. Хяналт шалгалт**

---

#### **26.1 Хяналт шалгалт**

Компанийн төлөөлөгч нь аливаа Бараа бүтээгдэхүүнийг Гэрээний дагуу шаардлага хангаж байгаа болон Гэрээнд заасан стандартад нийцсэн эсэхийг тодорхойлохын тулд хэдийд ч хянан шалгах эрхтэй байна.

#### **26.2 Мэдээллээр хангах үүрэг**

Нийлүүлэгч нь Компанид ямагт Бараа бүтээгдэхүүнд хяналт тавих эрхийг олгох ёстой бөгөөд Сайт дээр байгаа, хаа нэгтгээ хадгалагдсан эсхүл үйлдвэрлэлийн явцад байгаа бүх Бараа бүтээгдэхүүний хяналт, шалгалт, туршилт хийхэд шаардлагатай бүхий л бололцоогоор хангах ёстой.

#### **26.3 Хяналт шалгалтын зардал**

- (а) 26.3(б)-д заасан нөхцөлд хамааралтайгаар, хэрэв Компанийн төлөөлөгч Бараа бүтээгдэхүүний аливаа хэсгийг буулгах эсхүл задалж угсрах удирдамж өгсний дараа шалгалт шинжилгээ хийх явцад уг Бараа бүтээгдэхүүнийг Гэрээний дагуу шалгасан бол буулгах эсхүл задлах, буцаан эвлүүлэхэд гарах бүх зардлыг

Компани хариуцна. Хэрэв Бараа бүтээгдэхүүн нь Гэрээний дагуу биш байгаа нь тогтоогдвол уг Бараа бүтээгдэхүүнийг Гэрээний дагуу нөхцөлд нийцүүлэхтэй холбоотой аливаа зардлаар үл хязгаардлагдан гарах бүх зардлыг Нийлүүлэгч хариуцна.

- (б) Хэрэв Компанийн төлөөлөгч Нийлүүлэгчид Бараа бүтээгдэхүүнийг угсрахаас өмнө түүний аль нэг хэсэгт Компанийн төлөөлөгч үзлэг шалгалт хийх тухай холбогдох мэдэгдлийг Нийлүүлэгчид өгсөн бөгөөд Нийлүүлэгч нь Компанийн төлөөлөгчид үзлэг шалгалт хийх нөхцөл боломжийг эхлэн олгохгүйгээр Бараа бүтээгдэхүүнийг угсарвал, түүнийг задалсны болон дахин угсарсны улмаас гарах аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.

## **27. Туршилт хийх, ашиглалтад оруулах**

### **27.1 Туршилт**

Нийлүүлэгч нь Бараа эсхүл Барааны хэсгийг Гэрээний дагуу эсэх, эсхүл Олон улсын стандартчлалын байгууллагын тогтоосон холбогдох стандартуудын шаардлагыг ба холбогдох аливаа үйлдвэрлэлийн дүрэм зохицуулалтуудыг хангаж буй эсэх, хэрэв тийм стандарт ба дүрэм зохицуулалт байхгүй бол практикт өргөнөөр хүлээн зөвшөөрөгдсөн түвшинд буй эсэхийг шалгаж турших ажиллагааг явуулах ёстой.

### **27.2 Туршилтын зардал**

26.1-т заасан Компанийн эрхээс гадна Компанийн Төлөөлөгч нь шаардлагатай гэж үзэх үндэслэлтэй бол Барааг шалгах, туршилт хийх ажиллагааг явуулж болно. Компанийн Төлөөлөгчийн явуулсан туршилт хийх зардал ба Гэрээнд тусгаагүй боловч Компанийн Төлөөлөгчийн удирдамжийн дагуу Нийлүүлэгчийн ажиллуулж буй туршилт хийх эрх мэдэл бүхий этгээдийн явуулсан туршилтын зардалыг Компани хариуцна. Бусад бүх Шалгалт, туршилтын зардлыг Нийлүүлэгч хариуцна.

### **27.3 Туршилт хийх тухай мэдэгдэл**

Шалгалт, туршилтыг явуулж буй эсхүл Шалгалт, туршилтыг хийхийг шаардаж буй Тал нь нөгөө Талд хамгийн багадаа ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө туршилт хийх өдрийн талаарх мэдэгдэлийг өгөх ёстой. Компанийн Төлөөлөгчийн үндэслэл бүхий саналаар Шалгалт, туршилт нь Компанийн үйл ажиллагааг тасалдуулахааргүй эсхүл тасалдуулах магадлалтай бус гэж үзсэн тохиолдолд Шалгалт, туршилтыг мэдэгдэлд заасан өдөр эхлүүлэх ёстой. Шалгалт, туршилтыг хариуцан явуулаагүй Тал нь туршилтын үеэр байлцах эрхтэй боловч тэрхүү Тал Шалгалт, туршилтын явцад байлцах эсэхээс үл хамааран туршилт явагдана.

### **27.4 Хугацаа хоцорсон туршилт**

27.5(а)-д зааснаар хэрэв аль нэг Тал нь явуулах ёстой Шалгалт, туршилтыг явуулахыг тодорхой үндэслэлгүйгээр хойшлуулбал эсрэг Тал нь хойшлуулж буй Талд мэдэгдэл хүргүүлэх ба мэдэгдэл хийсэн хугацаанаас хойш 5 хоногийн дотор Шалгалт, туршилтыг эхлүүлсэн байхыг шаардаж болно. Хэрэв хойшлуулагч Тал нь заасан хугацаанд Шалгалт, туршилтыг эхлүүлэхгүй бол нөгөө Тал нь хойшлуулагч Талын эрсдэл ба зардлаар Шалгалт, туршилтыг эхлүүлж болно.

### **27.5 Шалгалт, туршилтыг давтан хийх**

- (а) Энэхүү 27-р заалтын дагуу гүйцэтгэх шаардлагатай аливаа Шалгалт, туршилтыг нөгөө Талын хүсэлтээр дахин явуулна. Хэрэв давтан хийсэн Шалгалт, туршилт нь өмнөх Шалгалт, туршилтын үр дүнг баталбал, давтан явуулсан Шалгалт, туршилттай холбоотой бүх зардлыг давтан Шалгалт, туршилтыг явуулах хүсэлт гаргасан Тал төлөх бөгөөд, эсрэг тохиолдолд анхны Шалгалт, туршилтыг явуулах үүрэгтэй эсхүл анхны Шалгалт, туршилтыг явуулахыг шаардсан Тал нь дахин туршилттай холбоотой зардлыг хариуцна.
- (б) 8.3-т заасны дагуу аливаа өөрчлөлт эсхүл орлуулалт хийсэн тохиолдолд, холбогдох Барааг Нийлүүлэгчийн зардлаар дахин шалгах ёстой.

### **27.6 Туршилт хийгээгүйн улмаас үүсэх үр дагавар**

- (а) Хэрэв Нийлүүлэгч нь Гэрээнд заасан хугацааны дотор эсхүл тодорхой хугацаа заагаагүй тохиолдолд үндэслэл бүхий боломжит хугацааны дотор аливаа Шалгалт, туршилтыг явуулж чадаагүй бол Компанийн Төлөөлөгч нь Нийлүүлэгчийн зардлаар:
- (i) Шалгалт, туршилтыг явуулж; эсхүл
  - (ii) Барааг хэрэглэхээр Компанийн эрмэлзэж буй хугацаанаас өмнө 7 хоногийг Мэдэгдлийг гарган Нийлүүлэгчид өгч болно.
- (б) Хэрэв Компани 27.6.(а)(ii)-н дагуу мэдэгдсэн хугацаа дуусахад Барааг хэрэглэхээр шийдвэл, (8-д заасан) Доголдлын Хариуцлагын буюу баталгаат Хугацааг дуусах хүртэл холбогдох бараа нь Нийлүүлэгчийн эрсдэл хэвээр үлдэнэ.

- (в) Хэдий Компанийн Төлөөлөгч Барааг энэхүү 2-р заалтын дагуу хэрэглэхийн өмнө Шалгалт, туршилтыг явуулсан ч, Компанийн Төлөөлөгчийн энэхүү үйлдэл нь шаардлагатай аливаа Шалгалт, туршилтыг явуулах Нийлүүлэгчийн хариуцлагаас өөрийг нь чөлөөлөхгүй гэдгийг Нийлүүлэгч хүлээн зөвшөөрнө.
- (г) Аливаа Шалгалт, туршилт хийн Барааг хүлээн авах нь Нийлүүлэгчийг түүний Гэрээгээр хүлээсэн аливаа үүргээс ямар нэг байдлаар чөлөөлөхгүй.

#### **27.7 Туршилтын үр дүн**

Ямар нэг Шалгалт, туршилтыг гүйцэтгэсэн даруй Нийлүүлэгч нь Шалгалт, туршилтыг үр дүнг бэлтгэж Компанийн Төлөөлөгчд хүргүүлэх ёстой.

#### **27.8 Ашиглалтад хүлээлгэн өгөх үе дэх Нийлүүлэгчийн хариуцлага**

- (а) Нийлүүлэгч нь Гэрээнд өөрөөр заагаагүй бол, Гэрээний дагуу шаардсан Ашиглалтад хүлээлгэн өгөх аливаа ажиллагааг Компанийн Төлөөлөгчийн сэтгэл ханамжинд хүрсэн хэмжээнд явагдахыг удирдан хянах үүргийг хүлээнэ.
- (б) Нийлүүлэгч нь Ашиглалтад хүлээлгэн өгөх зорилгоор хүрэлцээтэй хэмжээний сэлбэг хэрэгслүүдийг Ашиглалтад хүлээлгэн өгөх ажиллагаанаас өмнө Ажлын Талбайд нийлүүлэх (хүргэсэн байх) ёстой.

#### **27.9 Ашиглалтад хүлээлгэн өгөх ажиллагаанд оролцох Нийлүүлэгчийн ажилтан**

Хэрэв, Гэрээний дагуу Ашиглалтад хүлээлгэн өгөх ажиллагааг удирдан хянах Нийлүүлэгчийн нэг буюу түүнээс дээш тооны ажилтнаар Компанид үйлчилгээ үзүүлэхийг шаардсан бол, Компанийн Төлөөлөгчийн чиглүүлснээр Нийлүүлэгч нь тэдгээр ажилтныг гаргаж өгөх бөгөөд тэдгээр ажилтнууд нь Бараа бүтээгдэхүүнийг Ашиглалтад хүлээн авах ажиллагааг Гэрээгээр шаардсан стандартад хүрсэн бөгөөд Нийлүүлэгч хүлээн зөвшөөрч буй гэдгийг баталгаажуулах ёстой.

#### **27.10 Тайлан**

Нийлүүлэгч нь Ашиглалтад хүлээлгэн өгөх ажиллагааны турш болсон холбогдох бүх үйл явдлын тэмдэглэлийг хөтөлж Шалгалт, туршилтын бүх үр дүнг бүртгэн хадгална. Ашиглалтад хүлээлгэн өгөх ажиллагаа дуусахад Нийлүүлэгч нь Компанийн Төлөөлөгчид Ашиглалтад хүлээлгэн өгсөн Бараа бүтээгдэхүүний үзүүлэлт гүйцэтгэлийг танилцуулсан тайланг өгнө.

#### **27.11 Ажиллуулж эхлэхийн өмнө мэдэгдэх**

Нийлүүлэгч нь аливаа Барааг Ашиглалтад хүлээлгэн өгөх ажиллагаа эхлэхээс хамгийн багадаа 12 цагийн өмнө Компанид танилцуулга хийх ёстой бөгөөд тэрхүү Ашиглалтад хүлээлгэн өгөхтэй холбоотой аливаа Бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийн зааврыг бүх цаг хугацааны турш бүрэн мөрдөх ёстой.

### **28. Эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, байгаль орчин**

#### **28.1 Заалтын хэрэглээ**

Энэхүү 28 дугаар заалт нь Нийлүүлэлт хийх зорилгоор Сайтад эсхүл түүний эргэн тойронд ойрхон байх шаардлагатай Нийлүүлэгч, түүний ажилтанд үйлчилнэ.

#### **28.2 Нийлүүлэгч баталгаа гаргах**

Нийлүүлэгчийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа ба байгаль орчны шаардлага хангасан гүйцэтгэл болон Компанийн бизнесийн амжилт нь хоорондоо шууд холбоотой гэдгийг Нийлүүлэгч нь хүлээн зөвшөөрнө.

#### **28.3 Эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, байгаль орчны тухай хууль тогтоомж, бодлого шийдвэр, холбогдох стандартыг дагаж мөрдөх**

Нийлүүлэгч нь:

- (а) 30 дугаар заалтаар үл хязгаарлагдан Сайтын Онцгой Нөхцөлүүдэд (нэг хувийг Нийлүүлэгчид өгсөн) тодорхойлсноор хязгаарлагдах, байнга сахин мөрдөх шаардлагатай Компанийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа ба байгаль орчны бодлого болон дагалдах стандартууд (**ЭАБ-ны бодлого, стандарт**);
- (б) 31 дугаар заалтаар үл хязгаарлагдан, цаг тухай бүрт батлагдсан (ялангуяа 2008 оны 5 сарын 22-нд батлагдсан Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27.3 дахь хэсэг ба, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас 2008 оны 12 сарын 2-нд батласан Эрүүл ахуй, Аюулгүй ажиллагааны зөвлөлийг байгуулах, хариуцсан ажилтныг ажиллуулах тухай 126 дугаар тушаал) эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа ба байгаль орчны талаар хүчин төгөлдөр хэрэгжиж буй бүх холбогдох хууль тогтоомжууд;
- (в) 27 дугаар заалтад агуулсан эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа ба байгаль орчны нөхцөлүүдийг тус тус дагаж мөрдөх, мөн өөрийн ажилтнуудаар нэгэн адил мөрдүүлэхийг хангахыг хүлээн зөвшөөрнө.

#### 28.4 Эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, байгаль орчны удирдлагын төлөвлөгөө

- (a) Хэрэв эрүүл ахуй, аюулгүй байдал ба байгаль орчны удирдлагын төлөвлөгөөг (**ЭАБ-ны удирдлагын төлөвлөгөө**) Нийлүүлэгчийн Тендерийн (хэрэв байгаа бол) нэг хэсэг болгож ирүүлээгүй тохиолдолд Нийлүүлэгч нь Компанийн хүсэлтийг хүлээн авснаас хойш 20 хоногийн дотор, ЭАБ бодлого, стандартын дагуу санал болгож буй ЭАБ-ны удирдлагын төлөвлөгөөгөөг Компанийн төлөөлөгчид хянуулахаар хүргүүлэх ёстой.
- (б) Компанийн төлөөлөгч нь санал болгож буй ЭАБ-ны удирдлагын төлөвлөгөөг хянасны үндсэн дээр аливаа нэмэлт өөрчлөлт хийх тухай хүсэлтийг Нийлүүлэгчид гаргаж өгнө.
- (в) ЭАБ-ны удирдлагын төлөвлөгөөг шаардсан тохиолдолд ЭАБ-ны удирдлагын төлөвлөгөө ба түүнд оруулахыг хүссэн нэмэлт өөрчлөлтийг Компанийн төлөөлөгч батлах хүртэл буюу зөвшөөрөхөөс өмнө Нийлүүлэгч, түүний ажилтан нь Сайтад ажлыг эхлүүлж болохгүй.
- (г) Компанийн төлөөлөгч нь ЭАБ-ны бодлого, стандартад орсон аливаа нэмэлт өөрчлөлтөд харгалзах өөрчлөлтийг өмнө нь баталсан ЭАБ-ны удирдлагын төлөвлөгөөнд оруулах талаар Нийлүүлэгчид байнгын чиглэл, удирдамж өгч болно.
- (д) Нийлүүлэгч нь гэрээ хэрэгжих хугацааны туршид батлагдсан ЭАБ-ны удирдлагын төлөвлөгөөний хувийг Сайт дахь албан ёрууд эсхүл ажиллах талбартаа хадгалах ёстой.

#### 28.5 Удиртгал сургалт

- (a) Нийлүүлэгчийн өөрийн дотооддоо хэрэгжүүлдэг эрүүл мэнд ба аюулгүй ажиллагааны сургалтаас гадна Компаниас шаардсан холбогдох бүхий л удиртгал сургалтанд (**Компанийн удиртгал сургалт**) Нийлүүлэгчийн ажилтан бүр хамрагдах ёстой.
- (б) Компанийн үйл ажиллагааны зарим онцлог хэсэгт мөрдөгдөх дүрэмд нийцүүлэн Нийлүүлэгчийн аливаа ажилтан нь Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг хийж гүйцэтгэхэд шаардагдах тодорхой ур чадвартай (**Компаниас шаардсан чадвар**) байх ёстой ба Компаниас эрх хэмжээтэй холбоотой удиртгал болон сургалт нь дараахь шаардлагыг хангасан байвал зохино. Үүнд:
  - (i) ЭАБ-ны удирдлагын төлөвлөгөөнд багтсан байх;
  - (ii) тэдгээрийг Техникийн шаардлага, Тодорхойлолтонд заагаагүй тохиолдолд Компанийн төлөөлөгчөөр зөвшөөрөгдсөн байх;
  - (iii) Аливаа ажил эхлэхээс өмнө холбогдох ажилтнаар Сайтад эсхүл түүний ойролцоо явагдсан байх ёстой зэрэг болно.
- (в) Өөрөөр тохиролцоогүй тохиолдолд:
  - (i) Компани нь Компанийн удиртгал сургалтыг зохион байгуулж, санхүүжүүлэх бөгөөд Нийлүүлэгчийн ажилтны Компанийн удиртгал сургалтанд оролцох зардлыг хариуцна;
  - (ii) Нийлүүлэгч нь Компаниас шаардсан чадвартай холбоотой бүх сургалтыг зохион байгуулж, санхүүжүүлэх бөгөөд Нийлүүлэгчийн ажилтны уг сургалтанд оролцох зардлыг хариуцна.
- (г) Сайтад ажиллаж буй Нийлүүлэгчийн ажилтантай уулзахаар ирсэн, аливаа биеийн хөдөлмөрийн ажилд оролцохгүй хүн бүр Компанийн холбогдох удиртгал сургалтад хамрагдах шаардлагатай. Гэвч уг зочны Сайтад байх бүх хугацаанд Компанийн холбогдох удиртгал сургалтанд бүрэн хамрагдсан, Сайтад нэвтрэн орохтой холбоотой Компанийн шаардсан чадвар бүхий хэн нэгэн хамт яваа бол дээрх шаардлага үйлчлэхгүй.

#### 28.6 Нийлүүлэгчийн хариуцлага

Энэхүү 28 дугаар заалтын аль ч нөхцөл нь (ЭАБ-ны удирдлагын төлөвлөгөөний зөвшөөрлийг оролцуулан) өөрийн аливаа ажилтны эрүүл мэнд ба аюулгүй ажиллагааг баталгаажуулахгүй бөгөөд Нийлүүлэгч, түүний ажилтанд ногдох аливаа үүрэг хариуцлагыг хязгаарлах эсхүл чөлөөлөх үндэслэл болгохгүй. Нийлүүлэгч нь өөрийн ажилтнуудын эрүүл мэнд ба аюулгүй байдлыг гэрээ хэрэгжих бүхий л хугацаанд дангаараа хариуцна гэдгийг хүлээн зөвшөөрнө.

#### 28.7 Сайтаас нүүлгэн шилжүүлэх, гаргах

Гэрээний бусад нөхцөлийг үл харгалзан, хэрэв 28 дугаар заалтыг (ЭАБ бодлого, стандартыг зөрчсөн үйлдлийг оролцуулан) зөрчсөн аливаа үйлдэл гарсан тохиолдолд Компани нь дараахь арга хэмжээ авна. Үүнд:

- (a) Энэхүү хүчин төгөлдөр хэрэгжиж буйгэрээг нэн даруй цуцлахыг хамааруулан 39.2(б)-д заасны дагуу арга хэмжээ авах;
- (б) Нийлүүлэгч, Нийлүүлэгчийн ажилтан болон аливаа бусад этгээдийг Сайтыг нэн даруй орхихыг шаардах;



- (в) Нийлүүлэгч болон түүний аливаа ажилтнаас Нийлүүлэгчийн зардлаар Сайтаас аливаа материал эсхүл бодисыг холдуулж зайлуулахыг шаардаж болох

бөгөөд Нийлүүлэгч нь дээрх хүсэлтийг нэн даруй биелүүлэн бүх ажил, ажилтан, байгаль орчны хамгаалалт, аюулгүй байдлыг баталгаажуулах бүхий л боломжит арга хэмжээг өөрийн зардлаар авч хэрэгжүүлэх ёстой.

## 29. Сайтад нэвтрэн орох

---

### 29.1 Нэвтрэх эрх

34.15 ба 29-д зааснаар үл хязгаарлагдан, Компани нь Нийлүүлэгчид Гэрээ хэрэгжих өдрөөс эхлэн Сайтад нэвтрэх эрхийг албан ёсоор олгох бөгөөд Нийлүүлэгч нь Сайтад Нийлүүлэлт хийгдэж эхлэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө Компанийн төлөөлөгчид энэ тухай мэдэгдэл хүргүүлнэ.

### 29.2 Нийлүүлэгчийн үүрэг

- (а) Сайтад Нийлүүлэлт хийгдэж эхлэхээс өмнө Нийлүүлэгч нь өөрийн баримтлах ажлын цаг, үргэлжлэх хугацааг Компанийн төлөөлөгчид мэдэгдэх ёстой бөгөөд хэрэв тухайн ажлын цаг, үргэлжлэх хугацаанд ямар нэгэн өөрчлөлт оруулах бол энэ тухай Компанийн төлөөлөгчид 24-өөс доошгүй цагийн өмнө мэдэгдэх ёстой.
- (б) Нийлүүлэгч нь Компанийн үйл ажиллагаанд саад болох магадлалтай аливаа ажиллагааны талаар тухай бүрт Компанийн төлөөлөгчтэй зөвлөлдөх ёстой бөгөөд 14 хоногийн өмнө бичгээр зөвшөөрөл авна. Компанийн төлөөлөгч нь энэ тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор хариу өгөх ёстой.

### 29.3 Нэвтрэх эрхийг хугацаа хоцорч олгох эсхүл хойшлуулах

Хэрэв Нийлүүлэгчид Сайтад нэвтрэх эрх өгөхдөө хугацаа хоцрох эсхүл хэрэв нэвтрэх эрх нь хүлээгдсэн эсхүл хангагдаагүй бол Нийлүүлэгч нь 9.2(а)-д тодорхойлсоны дагуу Нийлүүлэлтийн хугацааны хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлт гаргаж болно.

### 29.4 Нэвтрэх эрх олгохоос татгалзах эрх

Хэрэв Нийлүүлэгч, түүний ажилтан нь 28, 29-д заасан аливаа шаардлагыг биелүүлээгүй бол Компанийн төлөөлөгч нь тухайн хүн буюу хүмүүсийг Сайтад нэвтрэхийг хориглох эсхүл зөвшөөрөх шийдвэрийн аль нэгийг холбогдох нөхцөл шаардлагад нийцүүлэн өөрийн үзэмжээр гаргаж болно.

### 29.5 Эзэмших онцгой эрх байхгүй байх

Нийлүүлэгч нь энэхүү гэрээний аль ч хэсэгт Сайтад нэвтрэх онцгой эрх олгох тухай байхгүй бөгөөд зөвхөн Нийлүүлэлт хийхтэй холбоотойгоор Компанийн төлөөлөгчийн шаардлагатай гэж үзсэн зөвшөөрөгдөх хэмжээнд Сайтад нэвтрэх ажиллах боломжтойг баталгаажуулсан явдал гэдгийг хүлээн зөвшөөрнө.

## 30. Компанийн бодлогод нийцүүлэх

---

### 30.1 Рио Тинто-ийн ерөнхий бодлого

Гэрээ хэрэгжих хугацааны туршид Нийлүүлэгч нь Компаниас Нийлүүлэгчид цаг тухай бүрт бичгээр мэдэгдсэн Компанийн болон Рио Тинто Группийн дүрэм, журам, бодлого тус бүрийг мөрдөн ажиллах ёстой бөгөөд түүний ажилтнууд нэгэн адил мөрдөн ажиллаж байхыг хангана.

### 30.2 Бидний ажлын арга барил

Нийлүүлэгч нь Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг хийж гүйцэтгэхдээ:

- (а) <http://www.ot.mn/en/about-us/way-we-work> цахим хуудас дээр буй “Бидний ажлын арга барил” (**Бидний ажлын арга барил**) гэсэн бизнесийн үйл ажиллагааны дүрмийг мөрдөх буюу түүнд нийцүүлж ажиллах;
- (б) “Бидний ажлын арга барил”-ыг хэрхэн мөрдөж байгаа эсхүл эргэлзээ, тээнэгэлзлийн улмаас мөрдөж чадахгүй байгаа тохиолдолд энэ тухайгаа Компанид эсхүл Рио Тинто Группийн “Speak-OUT” програмаар дамжуулан тайлагнах;
- (в) “Бидний ажлын арга барил”-ыг зөрчсөн нь баттай бус бол түүний талаарх хяналт шалгалт хийхэд Компанитай нэн даруй бүрэн хэмжээнд хамтарч ажиллах

ёстой бөгөөд Нийлүүлэгчийн ажилтнууд нэгэн адил мөрдөн ажиллаж байгааг баталгаажуулна.

## 31. Хууль

---

### 31.1 Хууль тогтоомжид нийцүүлэх

Гэрээ хэрэгжих хугацааны туршид Нийлүүлэгч нь:

- (а) Энэхүү гэрээнд заасан үүрэгт холбогдох бүх хууль тогтоомж, Засгийн газрын эрх бүхий байгууллагын гаргасан шаардлагыг мөрдөх ёстой ба Нийлүүлэгчийн ажилтнууд нэгэн адил мөрдөн ажиллах явдлыг хангах;

- (б) Нийлүүлэлт хийхтэй холбоотойгоор, өөрийн зардлаар:
  - (i) Шаардлагатай бүх мэдэгдлийг хүлээн авах;
  - (ii) Шаардлагатай бүх мэдэгдлийг өгөх;
  - (iii) Шаардлагатай бүх төлбөр, өр төлбөр ба татвар хураамжийг төлөх

ёстой бөгөөд хэрэв Компани хүсэлт гаргавал 31.1(б)–д дурдсан ажиллагааны талаар нотолгоог хангах ёстой.

### **31.2 Эрүүл мэндийн үзлэг**

31.1-д заасныг үл хязгаарлагдан, Нийлүүлэгч нь 2008 оны 5-р сарын 22-ний өдөр батлагдсан Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн тухай хуулийн дагуу:

- (а) түүний бүх ажилтан нь энэхүү гэрээт ажлыг эхлэхээс өмнө буюу хөдөлмөрийн харилцаанд орохын өмнөх эрүүл мэндийн урьдчилсан үзлэг хийлгэсэн гэдгийг; мөн
- (б) Гэрээ хэрэгжих хугацааны туршид түүний ажилтан нь тогтмол хугацаанд эрүүл мэндийн үзлэгт хамрагддаг гэдгийг тус тус баталгаажуулах ёстой.

### **31.3 Хууль зөрчсөнөөс үүсэх үр дагавар**

(а) Энэхүү Ерөнхий Нөхцөлийн аль нэг заалт эсхүл Гэрээний нөхцөлийг үл харгалзан, 30 ба энэхүү 31-д заасныг зөрчсөн аливаа тохиолдолд Компани нь:

- (i) Нийлүүлэгч, Нийлүүлэгчийн ажилтан болон/эсхүл аливаа бусад этгээдийг Сайтыг нэн даруй орхин явахыг шаардах;
- (ii) Нийлүүлэгч болон түүний аливаа ажилтныг Нийлүүлэгчийн зардлаар Сайтаас аливаа материал эсхүл бодисыг холдуулж зайлуулахыг шаардаж

болох бөгөөд Нийлүүлэгч нь уг шаардлагын дагуу бүх ажилтны аюулгүй байдлыг хангах бүхий л боломжит арга хэмжээг авч өөрийн зардлаар нэн даруй биелүүлсэн гэдгийг баталгаажуулах ёстой.

(б) Нийлүүлэгч нь 30 ба 31 дүгээр заалтууд нь Гэрээний нэн чухал ач холбогдолгүй нөхцөлүүд гэдгийг хүлээн зөвшөөрөх бөгөөд Нийлүүлэгч эсхүл түүний аливаа ажилтан нь 30 ба 31 дүгээр заалтыг биелүүлээгүй тохиолдолд Нийлүүлэгч энэ тухайгаа нэн даруй Компанид мэдэгдэнэ гэдэгтэй санал нийлнэ. Түүнчлэн 30 эсхүл энэхүү 31 дүгээр заалтыг зөрчсөн нь 30-д тодорхойлсон үр дагавар үүсгэхээс гадна Гэрээг цуцлах үндэслэл болж болно.

## **32. Гуравдагч этгээдтэй хамтран ажиллах**

### **32.1 Хөндлөнгөөс үл оролцох**

Нийлүүлэгч нь гэрээ хэрэгжих хугацаанд Сайтад буй бусад нийлүүлэгчид эсхүл тэдний ажилтны (Компанийн авч ажиллуулсан/ажиллуулаагүй эсхүл хөлсөлсөн/үл хөлсөлсөн)үйл ажиллагаанд саад болох эсхүл хөндлөнгөөс оролцох ёсгүй.

### **32.2 Нөхөн төлбөр олгохгүй байх**

Нийлүүлэгч нь Сайтад буй бусад нийлүүлэгч, гүйцэтгэгч болон ажилтны хөндлөнгийн оролцооны улмаас Гэрээний үнэ, хохирол, өртөг зардал болон аливаа бусад санхүүгийн эсхүл нөхөн төлбөрийг нэмэгдүүлэх эрхгүй.

### **32.3 Нийлүүлэлтийн хугацааны хуваарьт өөрчлөлт оруулах**

Хэрэв Нийлүүлэгчийн өөрийн буруугаас болоогүй хэдий ч Сайтад буй бусад нийлүүлэгч, гүйцэтгэгч болон тэдгээрийн ажилтны хөндлөнгийн оролцооны улмаас хугацаа хоцорсон тохиолдолд Нийлүүлэгч нь Нийлүүлэлтийн хугацааны хуваарьт 9.2(а)-д заасны дагуу нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлт гаргаж болно.

## **33. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал**

### **33.1 Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэнийг мэдэгдэх**

Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэний улмаас гэрээний аль нэг тал хугацаа хоцрох эсхүл гэрээгээр хүлээсэн аливаа үүргийг (мөнгөн төлбөр төлөх үүргээс бусад) биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээхгүй бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь нөлөөлж байгаа энэхүү нөхцөл байдал үүссэнээс хойш нөгөө талдаа 33.2-д заасан шаардлагын дагуу мэдэгдлийг аль болох хурдан хүргүүлнэ.

### **33.2 Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдэл**

33.1-д зааснаар хүргүүлэх мэдэгдэлд:

- (а) гэрээний нэг талын гүйцэтгэж чадахгүй байгаа үүргийг заах;
- (б) тухайн үүссэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлыг бүрэн тодорхойлох;

- (в) тухайн үүссэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын үргэлжлэх хугацааг тооцоолох;
- (г) тухайн нөхцөл байдлыг засч залруулах, намжаахаар санал болгож буй арга хэмжээний талаар тодорхой тусгах ёстой.

### **33.3 Хохирлыг арилгах, засч залруулах үүрэг**

Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэний улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийг хойшлуулж буй гэрээний аль нэг тал нь:

- (а) Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэний улмаас учирсан хохирлыг боломжит хэмжээгээр барагдуулж, үүргийн биелэлтийг аль болох хурдан хангуулах;
- (б) нөгөө талд гэрээний дагуу үүргээ биелүүлээгүйн улмаас учирсан хариуцлагыг бууруулах боломжит бүх арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой.

### **33.4 Нөхөн төлбөр олгохгүй байх**

Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдалд өртсөн тал нь Нийлүүлэгч байх тохиолдолд 9.2(а)-д заасны дагуу Нийлүүлэлтийн хугацааны хуваарьт нэмэлт оруулах нь уг нөхцөл байдлын улмаас аливаа хугацаа хойшилсныг залруулах ганц арга хэмжээ байх бөгөөд Нийлүүлэгч нь гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэнтэй холбоотойгоор Гэрээний үнэ эсхүл аливаа хохирол, зардлын дүнг нэмэгдүүлэх эрхгүй болно.

## **34. Даатгал**

### **34.1 Нийлүүлэгчийн даатгал**

Гэрээнд заасан Нийлүүлэгчийн аливаа үүргийг хязгаарлахгүйгээр, Нийлүүлэгч нь энэхүү 34-р заалтад тодорхойлсон даатгалын төрлүүд ба хамрах хүрээг дан ганц өөрийн зардлаар гүйцэтгэж түүний хүчин төгөлдөр байдлыг хадгална (**Нийлүүлэгчийн даатгал**). Нийлүүлэгчийн даатгал нь А.М. Best Company-аас гаргасан үнэлгээний А /VII-иас доошгүй түвшний нэр хүнд бүхий даатгагчаар хийгдсэн байх ба даатгагч нь барааг хүргэх болон Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг хийж гүйцэтгэх тухайн муж, орон нутаг, нутаг дэвсгэр бүрт бизнесийн үйл ажиллагаа явуулах эрхтэй байна. Энэхүү 33-р заалт дахь бүх мөнгөн дүн нь АНУ-н доллараар илэрхийлэгдэнэ.

### **34.2 Ерөнхий болон бүтээгдэхүүний хариуцлагын даатгал**

Нийлүүлэгч нь Нийлүүлэгчийн болон түүний нэрийн өмнөөс явуулсан үйл ажиллагаа (дэлбэрэлт, нуралт ба газрын доорх аюул зэргийг хамарна) ба хэн нэгэнд ямар нэгэн шалтгаанаар учирсан осол гэмтэл, амь насны эсхүл аливаа хөрөнгийн хохирол, эвдрэл, сүйрэлтэй холбоотой бүх хариуцлагыг хамрах, хариуцлагын хэмжээ нь тохиолдол бүрт \$10,000,000-с багагүй хязгаар бүхий цогц хариуцлагын даатгал эсхүл арилжааны ерөнхий даатгалаар даатгуулсан байна.

### **34.3 Ажилчдын нөхөн олговор ба ажил олгогчийн хариуцлагын даатгал**

Нийлүүлэгч нь холбогдох хууль тогтоомжийн дагуу ажилчдын нөхөн олговрын болон ажил олгогчийн хариуцлагын даатгалд даатгуулж байх ёстой.

### **34.4 Автомашины хариуцлагын даатгал**

Хэрэв гэрээний гүйцэтгэл нь Нийлүүлэгчийг моторт тээврийн хэрэгслийг хэрэглэх эсхүл түүнийг ашиглуулахыг шаардсан тохиолдолд Нийлүүлэгчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу уг моторт тээврийн хэрэгслийн эзэмшигч болон уг хэрэгслийг ажиллуулах операторийг автомашины (моторт тээврийн хэрэгсэл) болон жолоочийн хариуцлагын даатгал хийлгэхийг шаардана.

### **34.5 Мэргэжлийн хариуцлага (Алдаа, дутагдал)-ын болон мэргэжлийн баталгаа гаргах даатгал**

Хэрэв гэрээний гүйцэтгэл мэргэжлийн зөвлөгөө ба нийлүүлэлт хийх үүргийг хамарсан эсхүл үүнтэй холбоотой тохиолдолд Нийлүүлэгч нь гэрээ хэрэгжих хугацаанд болон гэрээг цуцалсны эсхүл Гэрээнд заасан Нийлүүлэгчийн үүрэг дуусгавар болсон (Компанийн үндэслэл бүхий шийдвэрээр) эсвэл Гэрээ цуцлагдсаны дараа 3-аас доошгүй жилийн туршид Нийлүүлэгчийн гэрээний дагуу гүйцэтгэсэн мэргэжлийн үйлчилгээ, зөвлөгөөтэй холбоотой хариуцлагыг хамрах, хариуцлагын хэмжээ нь тохиолдол бүрт \$10,000,000-с багагүй хязгаар бүхий мэргэжлийн хариуцлагын даатгал эсхүл аливаа буруутай, хайхрамжгүй ажиллагаатай холбогдсон алдаа, дутагдлын хариуцлагын даатгалаар даатгуулсан байна.

### **34.6 Нийлүүлэгчийн үйлдвэрлэлийн байгууламж ба тоног төхөөрөмж**

Хэрэв гэрээний гүйцэтгэл нь Гэрээтэй холбоотойгоор Нийлүүлэгчээс Сайтад хэрэглэгдэх үйлдвэрлэлийн байгууламж, тоног төхөөрөмжийг хэрэглэх эсхүл түүнийг ашиглуулахыг шаардсан тохиолдолд Нийлүүлэгчийг тухайн үйлдвэрлэлийн байгууламж, тоног төхөөрөмжийн өөрийнх нь үнэлгээгээр уг үйлдвэрлэлийн байгууламж ба тоног төхөөрөмжинд учирсан бүх хохирол, эвдрэл гэмтлийг хамрах даатгалд даатгуулах эсхүл эзэмшигчийг нь (тухайн

үйлдвэрлэлийн байгууламж ба тоног төхөөрөмжийн эзэмшигч нь Компани эсхүл Рио Тинто Группийн гишүүн биш бол) даатгуулахыг шаардана. Хуулиар хориглосноос бусад тохиолдолд энэхүү даатгал нь Компани ба түүний захирлууд, албан тушаалтнууд, ажилчдын даатгалыг шилжүүлэн эсхүл орлуулан тооцох тусгайлсан эрхгүй байна.

#### **34.7 Тээвэрлэлтэнд яваа бараа**

Хэрэв гэрээний гүйцэтгэл Нийлүүлэгчээс Бараа бүтээгдэхүүнийг Сайт руу эсхүл Сайтаас тээвэрлэхийг шаардсан тохиолдолд Компанийн бичгээр өгсөн зөвлөмжид өөрөөр заагаагүй бол Нийлүүлэгч нь тухайн бараа бүтээгдэхүүний төлбөрийг Компани гүйцэтгэсэн эсэхээс үл хамааран, тээвэрлэлтийн үед бараа бүтээгдэхүүнд гарах аливаа хохирол эвдрэл, гэмтлийг хамарсан даатгалд даатгуулсан байх шаардлагатай.

#### **34.8 Аюултай бодис (аюултай бодисын тээвэрлэлт)-ын даатгал**

- (a) Хэрэв Гэрээний гүйцэтгэл нь Нийлүүлэгчээс аюултай бодис ашиглан аливаа үйл ажиллагаа явуулахыг шаардсан тохиолдолд Нийлүүлэгч нь аюултай бодисыг ашигласнаас эсхүл ашиглан үйл ажиллагаа явуулсны улмаас аливаа хүнд осол гэмтэл, амь насны гарз учрах эсхүл аливаа хөрөнгөнд хохирол, эвдрэл гэмтэл ба сүйрэл учрахтай холбоотой бүх хариуцлагыг хамарсан, тохиолдол бүрт \$5,000,000-с багагүй хязгаар бүхий Аюултай бодис (бохирдол)-ын хариуцлагын даатгалд даатгуулсан байна.
- (b) Хэрэв гэрээний гүйцэтгэл Нийлүүлэгчээс аюултай бодис тээвэрлэхийг шаардсан тохиолдолд Нийлүүлэгч нь аюултай бодисыг (ялангуяа MCS 90 төрлийн) тээвэрлэх эсхүл зөөвөрлөхөд ямар нэг хүнд осол гэмтэл, амь насны гарз учрах эсхүл аливаа хөрөнгөнд хохирол, эвдрэл гэмтэл ба сүйрэл учрахтай холбоотой бүх хариуцлагыг хамарсан, тохиолдол бүрт \$5,000,000-с багагүй хязгаар бүхий даатгалд даатгуулсан байна.

#### **34.9 Агаарын тээврийн даатгал**

Хэрэв гэрээний гүйцэтгэл Агаарын тээврийн хэрэгслийг (нисдэг тэрэг багтана) хэрэглэхийг шаардсан тохиолдолд Нийлүүлэгч нь дараахь нөхцөлөөр даатгалд хамрагдсан байх ба агаарын тээврийн хэрэгслийн эзэмшигчээс мөн адил даатгуулахыг шаардах ёстой.

- (a) ашиглаж буй бүх Агаарын тээврийн хэрэгслийн хувьд иж бүрэн даатгалд хамрагдах ба нөхөн олговрын хэмжээ нь тухайн тээврийн хэрэгслийн зах зээлийн үнэлгээнээс багагүй хязгаартай байх;
- (b) хариуцлагын даатгалд нисэх баг, зорчигчид болон бусад этгээдийн аливаа осол гэмтэл, амь насны гарз мөн ачаа тээштэй холбоотой аливаа хохирлыг даатгуулах ба тухайн даатгалын тохиолдол бүрийн нөхөн олговрын нийт хэмжээ нь:
  - (i) \$10,000,000–с багагүй; эсхүл
  - (ii) зорчигчийн суудал бүрт \$2,000,000тухайн тохиолдолд бүрт хамтад нь тооцно.

#### **34.10 Нэмэлт хариуцлагын (шүхрэн) даатгал**

Нийлүүлэгч 34-р зүйлд шаардсан даатгалын нөхөн олговрыг авч чадахгүй тохиолдолд нэмэлт хариуцлагын даатгалд хамрагдаж болох бөгөөд энэ нь тухайн даатгалын ангилал дахь Нийлүүлэгчийн суурь нөхөн олговортой нийцүүлэхэд гарч ирэх, нийт даатгалын хамрах хүрээ нь тухайн даатгалын ангилалд шаардлагатай үнийн дүнгээс багагүй байхаар байна. Ямарваа нэг эргэлзээгүй байлгах үүднээс, гуравдагч талаас Нийлүүлэгчийн нэмэлт хариуцлагын ба/эсхүл шүхрэн даатгалын талаар даатгалын хамрах үнийн дүнгийн шаардагдах доод хязгаараас бууруулсан байна гэсэн эсрэг шаардлага бүхий гомдол гаргасан тохиолдолд, Нийлүүлэгч нь нэмэлт хариуцлагын шүхрэн даатгалд 33-т заасны адил шалгуурт нийцэх даатгалын компаниар даатгуулах ёстой бөгөөд энэ нь 33-р зүйл дэх даатгалын хамрах хүрээний шаардлагуудтай нийцнэ.

#### **34.11 Даатгалын нөхцөлүүд**

Нийлүүлэгчийн даатгал дараахь нөхцөлтэй байна:

- (a) даатгалын хамрах хугацаа нь гэрээ хэрэгжиж эхлэх хугацаанаас хоцрохгүйгээр эхлэх ба Гэрээний хэрэгжилтийн туршид болон Гэрээ дуусгавар болсоноос хойш хоёр (2) жилийн хугацаанд (34.7-д заасан даатгалын тохиолдолд Гэрээ дуусгавар болох хугацаа эсхүл Гэрээнд заасан Нийлүүлэгчийн үүргээ гүйцэд биелүүлэх эсвэл гэрээ цуцлагдсан хугацаанаас хойш 3 жилийн туршид) үргэлжилнэ. Хэрэв Гэрээнд тодорхойлсон доголдол арилгах баталгаат хугацаа нь хоёр (2) жилээс дээш бол, шаардлагатай даатгалд хамрагдах хугацаа нь доголдол арилгах баталгаат хугацаан дээр арван хоёр (12) сарыг нэмэлт хугацаа байна.
- (b) Нийлүүлэгчийн даатгал нь өөрийгөө даатгах сан эсхүл зөрүүг төлөхтэй холбогдсон бол тэрхүү өөрийгөө даатгах сан эсхүл зөрүүгийн хэмжээг Компанид мэдэгдэх ёстой.

- (в) Нийлүүлэгч нь 34.12(е)-д нийцүүлэн даатгалын гэрчилгээ (эсхүл үүнийг гаргах тухай тодорхойлолт) ба даатгалын гэрээний нэмэлт нөхцөлийг дараахь байдлаар Гэрээгээр шаардсан даатгалын үндэслэл болгон Компанид гаргаж өгнө:
- (i) Аливаа Бараа эсхүл Үйлчилгээг нийлүүлэхээс өмнө, Гэрээ хэрэгжиж эхлэх өдрөөс хойш арван дөрөв(14) хоногоос хэтрүүлэлгүйгээр
  - (ii) даатгалын гэрээ шинэчлэгдэх эсхүл өөрчлөгдөх бүрд түүнээс хойш арван дөрөв (14) хоногийн дотор;
  - (iii) Гэрээ дуусгавар болсноос хойш Гэрээний нөхцөлүүдийн дагуу даатгал шаардлагагүй болох хүртэл жил бүр;
- эргэлзээ төрүүлэхээс сэргийлэх үүднээс, энэхүү гэрээнд хэрэглэгдсэн “даатгалын гэрээний нэмэлт нөхцөл” гэдэг үг нь даатгалын гэрээний нэг хэсэг биш боловч, даатгалын гэрээний холбогдох нөхцөлүүдийг дурдсан, даатгалын гэрээнд хавсаргахад тэрхүү гэрээний нэг хэсэг болж орох нэмэлт хуудас юм.
- (г) Нийлүүлэгчийн бүх даатгалууд нь Компани бичгээр хүсэлт гаргахаас бусад тохиолдолд Компанид хохирол учруулахаар өөрчлөгдөх, цуцлагдах, хүчингүй болохоор зөвшөөрөгдөх ёсгүй.
- (д) Нийлүүлэгч нь 34.2, 34.7 ба 34.9-д тодорхойлсон Нийлүүлэгчийн даатгалын ангилал бүрийн хувьд хамрах хүрээний даатгалын гэрээний нэмэлт нөхцөлийг гаргаж өгнө:
- (i) Компани, түүний охин Компани ба тэдний харьяа ажилтаныг нэмэлт даатгуулагч болгон багтаасан даатгалын гэрээний нэмэлт нөхцөл;
  - (ii) ижил төстэй даатгалын үндсэн хэсэг болсон, Компани авч явж болох даатгалын гэрээний нэмэлт нөхцөл;
  - (iii) даатгуулагч Тал бүр тусдаа этгээд гэж тооцогдсон бөгөөд Тал тус бүрт тусдаа даатгалын гэрээ мэт даатгал нь хэрэгждэг харилцан хариуцлага хүлээх заалтыг агуулсан даатгалын гэрээний нэмэлт нөхцөл;
  - (iv) Компани, түүний охин компани, тэргээрийн ажилчдын эсрэг даатгалын шилжүүлэх шууд ба далд эрхээс татгалзсан (энэхүү татгалзалт нь даатгалын гэрчилгээнд мөн тусгагдсан) даатгалын гэрээний нэмэлт нөхцөл;
  - (v) Аль нэг даатгуулагчийн зөрчил гаргасан байдал нь нөгөө даатгуулагч талын хамрах хүрээнд сөргөөр нөлөөлөхгүй гэсэн Бие даасан байдлын заалтыг хүчин төгөлдөр болгосон даатгалын гэрээний нэмэлт нөхцөл;
  - (vi) 34.2-т тодорхойлсон даатгалын хувьд, Нийлүүлэгчийн эзэмшиж буй “Бараа”-ны үнэ цэнээс бага бус үнийн дүнгээр “даатгуулагчийн биечлэн ба хуулиар хянах Бараа”-г хамарсан даатгалын гэрээний нэмэлт нөхцөл.

#### **34.12 Нийлүүлэгчийн гэрээний дагуух мэдэгдэл**

Хэрэв энэхүү 34-р зүйлд шаардсанаар Нийлүүлэгч аливаа даатгалын гэрээний дагуу Компанитай холбоотой гомдол заргыг нэмэгдүүлж болох ямар нэг үйл явдлын талаар Нийлүүлэгч нь мэдэж байгаа бол, энэ талаар Нийлүүлэгч Компанид мэдэгдэх ёстой бөгөөд тэрхүү гомдол саналтай холбоотой дараагийн арга хэмжээний талаар Компани бүрэн мэдэж байх явдлыг хангаж ажиллана.

#### **34.13 Туслан гүйцэтгэгчдийн даатгал**

Нийлүүлэгч нь Туслан гүйцэтгэгчид Нийлүүлэгчийн даатгуулахыг шаардсан Нийлүүлэгчийн даатгалуудтай төстэй даатгалуудад хамрагдсаар байх, тэдгээр даатгалын үр дүн, ашиг тусыг авах явдлыг хангаж ажиллана.

#### **34.14 Нийлүүлэгчийн даатгалд байнга хамрагдаж чадаагүй бол**

Хэрэв Нийлүүлэгч нь Нийлүүлэгчийн аливаа даатгалд даатгуулах болон байнга хамрагдаж чадаагүй тохиолдолд, Компани нь:

- (a) Нийлүүлэгч ба түүний ажилтныг Сайтын аль нэг эсхүл бүх хэсэгт нэвтрэхээс татгалзах; ба/эсхүл
- (b) энэхүү явдлыг Гэрээгээр хүлээсэн үүргээ санаатайгаар зөрчсөн гэж үзэн арга хэмжээ авч болно

#### **34.15 Даатгалын нөхөн олговрын нэхэмжлэх ба нөхөн олговрын зөрүүг төлөх**

Нийлүүлэгчийн хамрагдсан даатгалтай холбоотой илүүдэл эсхүл хасагдах зөрүүгийн төлбөрийг Нийлүүлэгч хариуцах бөгөөд Нийлүүлэгчийн төлсөн аливаа илүүдэл эсхүл хасагдах зөрүүг Компаниас гаргуулах эрх Нийлүүлэгчид байхгүй.

#### 34.16 Нөхөн төлбөрт үл нөлөөлөх Нийлүүлэгчийн даатгал

Энэхүү 34-р заалтын аль ч хэсэг нь Гэрээнд заасан нөхөн төлбөртэй холбоотой Нийлүүлэгчийн хариуцлагыг хязгаарлахгүй.

#### 35. Нөхөн төлбөр

##### 35.1 Хүлээн зөвшөөрөх

Нийлүүлэгч нь Сайтад нэвтрэх тохиолдолд энэ нь Нийлүүлэгчийн өөрийн эрсдэл байхыг хүлээн зөвшөөрнө. Нийлүүлэгчийн мэргэжилтэн Сайтад нэвтрэх тохиолдолд энэ нь түүний өөрийн эрсдэл байхыг мэдэж буй гэдгийг Нийлүүлэгч хүлээн зөвшөөрнө.

##### 35.2 Нөхөн төлбөр

Энэхүү 35-р заалтын дагуу Нийлүүлэгч нь нөхөн төлбөр авах эрх бүхий талуудын өмнөөс бүх хариуцлагыг хүлээж нөхөн төлбөрийг төлж дор дурдсан бүх хохирол, гэм хорыг хариуцна.

- a) Нийлүүлэгч эсхүл түүний ажилтны үйл ажиллагаа ба эс үйлдлээс шалтгаалсан буюу шалтгаалсан байж болох бөгөөд дараахь зүйлстэй холбоотой, тэдгээрээс үүдэн гарсан хариуцлагууд:
  - (i) Нийлүүлэгчийн аливаа албан хаагчид, агентууд, гэрээлэгчид, эсхүл туслан гүйцэтгэгчид эсхүл түүний ажилтны Сайтад байх үед, ажлын талбайгаас гарах болон орох үед учирсан аливаа өвчин, гэмтэл, амь насны гарз;
  - (ii) Аливаа хөрөнгийн эвдрэл гэмтэл;
  - (iii) Нийлүүлэгчийн болон түүний ажилтны Гэрээний дагуу эсхүл аливаа худалдан авалтын захиалгын дагуу хүлээсэн аливаа үүрэг, тохиролцоо, амлалт даалгавар, танилцуулга, баталгааг зөрчих;
  - (iv) Бараа бүтээгдэхүүн ба холбогдох үйлчилгээ;
  - (v) Нийлүүлэгч эсхүл Нийлүүлэгчийн ажилтан Сайтад нэвтэрсэн ба тэнд дээрх (i)-ээс (iv) хүртэлх хэсэгт дурдсан эд зүйл ба үйл ажиллагаанаас үүдсэн аюултай бодисыг санаатай болон болгоомжгүйгээр задруулах эсхүл гаргах зэргээр (задруулах, гаргах, бохирдол эсхүл хордох зэргийг Нийлүүлэгч тэр даруй судлан шинжилж Компани ба холбогдох засгийн газрын ажилтнуудын сэтгэл ханамжинд хүрэх хэмжээнд хүртэл засаж залруулах ажлыг өөрийн зардлаар хийх) үл хязгаарлагдан хийсэн тэдний аливаа үйл ажиллагаануудаар үл хязгаарлагдах хийсэн үйл ажиллагаа;
- (б) Нийлүүлэгч түүний туслан гүйцэтгэгч эсхүл охин компаниудын ажлын байр оролцоотой холбоотойгоор үүдэн гарсан орлогын татвар, ажилчдын нөхөн олговор, ажилгүйдлын нөхөн олговор, нөхөн олговор, илүү цаг, цалин, бусад тэтгэлэг (жилийн ээлжийн амралт эсхүл удаан ажилласны амралтын мөнгө багтана), ялгаварлал, хүчирхийлэл, өс хонзон авах, гэрээ тохиролцоог шууд эсхүл дам хэлбэрээр зөрчих, сайн итгэлцэл ба шударга харилцааны зөвшилцөлийг зөрчих, амлалтаа зөрчих, шударга бусаар баяжих, нэр төрд халдах, доромжлох, эдийн засгийн харилцаанд хөндлөнгөөс оролцох, хууль бусаар ажлаас халах эсхүл дуусгавар болгох эсхүл орон нутаг, муж, улсын хууль зохицуулалтаас үүдсэн сэтгэл хөдлөлийн дарамт учруулах зэрэгтэй холбоотой (зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй) Нөхөн төлбөр авах эрх бүхий талын эсрэг Засгийн газрын агентлаг, эсхүл Нийлүүлэгч ба түүний туслан гүйцэтгэгчдийн аливаа ажилтнаар хийгдсэн гомдол заргууд;
- (в) Нийлүүлэгч болон түүний ажилтны Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт эсхүл үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой холбогдох хууль тогтоомжийг зөрчсөний улмаас үүссэн үр дагавар; эсхүл
- (г) Нийлүүлэгч нь Гэрээгээр шаардсан аливаа даатгалыг худалдан аваагүй эсхүл түүнд хамрагдсан хэвээр байгаагүйн улмаас үүссэн үр дагавар зэрэг болно.

##### 35.3 Онцгой тохиолдол

Нийлүүлэгч нь компанийн аливаа буруутай, алдаатай болон санаатай зохисгүй үйл ажиллагаанаас шалтгаалсан эсвэл түүний нөлөөгөөр үүссэн хохирлын хариуцлагыг 35.2 заасны дагуу хүлээх үүрэггүй.

#### 36. Үр дагавар бүхий хохиролд үл тооцох

Гэрээний аль ч тал нь нөгөө талынхаа өмнө Үр дагавар бүхий буюу Гарцаагүй алдагдалд тооцогдох хариуцлагыг хүлээхгүй (*Үл тооцогдох нөхцөл*). Дор дурдсан тохиолдолд Үл тооцогдох нөхцөлийг хэрэглэхгүй. Үүнд:

- (a) Амь нас эрсдэх эсхүл хүн осол гэмтэлд өртөх;
- (б) Хөрөнгийн эвдрэл гэмтэл, хохирол учрах;
- (в) Санаатай гаргасан алдаа;

- (г) Үр дагавар бүхий хохиролд тооцогдохоор боловч Гэрээний дагуу төлөгдөх хугацаа хэтрүүлсний төлбөр буюу арилгах ёстой доголдол гологдлын хэмжээнээс хэтрээгүй бол;
- (д) Холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн;
- (е) Гэрээний нууц болон гэрээний нууцлалын заалтыг зөрчсөн;
- (ё) Аль нэг гуравдагч талын эрхийг (Оюуны өмчийн эрхийг оролцуулан) зөрчсөн;
- (ж) Гэрээний нөхцөлд заасны дагуу гэрээний аль нэг талын даатгуулсан эсхүл даатгуулах шаардлагатай байсан хариуцлага;
- (з) Хуулиар үл тооцогдох боломжгүй алдагдал, гарз хохирол зэрэг болно.

### **37. Хугацаа хэтрүүлсний төлбөр**

#### **37.1 Хугацаа хэтрүүлсний төлбөр**

- (а) Энэхүү 37-р заалт нь Хавсралт D (Нийлүүлэлт хийх хугацааны хуваарь) хугацаа хэтрүүлсний төлбөрийн, тухай агуулсан тохиолдолд мөрдөгдөх бөгөөд хэрэв Нийлүүлэлт хийх хугацааны хуваарь нь хугацаа хэтрүүлсний төлбөрийн талаар агуулаагүй тохиолдолд үйлчлэхгүй.
- (б) Хэрэв Гэрээ хэрэгжиж эхлэх өдөр ба түүнээс хойши аливаа цаг хугацаанд Нийлүүлэгч нь Нийлүүлэлт хийх хугацааны хуваарийн дагуу Бараа бүтээгдэхүүнийг хүргэж чадахгүй бол (**ХА Нийлүүлэлт хийгдэхгүй байх**), Нийлүүлэгчид Компаниын өмнө хариуцах өр төлбөр үүсэх бөгөөд Нийлүүлэлтийн хугацааны хуваарьт заасан урьдчилан үнэлсэн ба хугацаа хэтрүүлсний төлбөр (**Хугацаа хэтрүүлсний төлбөр**)-тэй холбоотой Компанийн хохирлыг барагдуулна.

#### **37.2 Компани буруутай үед хугацаа хэтрүүлсний төлбөр төлөхгүй байх**

Дан ганц Компани Гэрээгээр хүлээсэн өөрийн үүргийг биелүүлээгүй, зөрчсөний улмаас шууд үүдэлтэй ХА Нийлүүлэлт хийгдэхгүй байх тохиолдолд энэхүү заалтын дагуу Нийлүүлэгч нь хугацаа хэтрүүлсний төлбөр төлөх хариуцлагыг хүлээхгүй.

#### **37.3 Хүлээн зөвшөөрөх**

Талууд нь Нийлүүлэгч Гэрээгээр шаардсан өдөр гэхэд Бараа бүтээгдэхүүнийг нийлүүлж чадахгүй бол Компанид ноцтой бөгөөд ихээхэн хэмжээний хохирол учирч болохыг хүлээн зөвшөөрнө. Тиймээс, Талууд нь энэхүү 37-р заалтад тодорхойлсон хугацаа хэтрүүлсний төлбөрийн дагуу дараахь зүйлсийг хугацаа хэтрүүлсний төлбөрт тулгуурлан зөвшилцөн тохиролцов. Үүнд:

- (а) Гэрээгээр заасан Нийлүүлэгчийн үүргийг зөрчсөнтэй холбоотой хохирлыг тооцож батлахтай холбоотой хүндрэлүүдээс зайлсхийхээр тохиролцсон;
- (б) Бизнесийн туршлагатай, харилцан зай барьсан талуудын хооронд тодорхой байдлыг хангах буюу зүй зохистой байх;
- (в) Компанид тохиолдох хохирол ба алдагдлын урьдчилсан үнэлгээг бодитойгоор илэрхийлэхээс өөрөөр шийтгэх зорилго агуулаагүй байх;
- (г) Учирсан хохирлын нотлох боломжтой хувь хэмжээтэй харьцуулахад түүнээс хэтэрхий илүүдсэн хэмжээтэй бус байна.

#### **37.4 Шаардсаны дагуу хугацаа хэтрүүлсний төлбөр төлөх**

Энэхүү 37-р заалтын дагуу Нийлүүлэгчийн Компанид төлөх ёстой аливаа хугацаа хэтрүүлсний төлбөр нь шаардсаны дагуу төлөгдөж болох бөгөөд эсхүл, Компани нь хугацаа хэтрүүлсний төлбөрийг Нийлүүлэгчийн төлөх ёстой өр гэж үзэж Компанид төлбөл зохих эсхүл төлөх ёстой болсон аливаа мөнгөн дүнгээс суутгаж болно.

### **38. Гэрээ цуцлах үед зөрчил үл гаргах**

#### **38.1 Гэрээ цуцлах тухай мэдэгдэл**

Компани нь 30-с доошгүй хоногийн өмнө Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлснээр Гэрээг эсхүл түүний аль нэг хэсгийг цуцалж болно. (*Гэрээ цуцлах мэдэгдэл*)

#### **38.2 Гэрээ цуцлах мэдэгдлийг хүлээн авмагц хүлээх үүрэг**

Гэрээ цуцлах мэдэгдлийг хүлээн авмагц Нийлүүлэгч нь:

- (а) Бүх ажилтны аюулгүй байдал болон бүх бараа бүтээгдэхүүний хадгалалт, хамгаалалтыг хангах боломжит бүх арга хэмжээг нэн даруй, өөрийн зардлаар авах;
- (б) Гэрээ цуцласны улмаас үүссэн аливаа өр төлбөрийг багасгах бүх боломжит бүх арга хэмжээг нэн даруй авах;

(в) Гэрээг цуцлахтай холбоотойгоор Компаниас үндэслэлтэйгээр шаардсан бусад арга хэмжээг авах ёстой.

### 38.3 Гэрээх цуцлах үед хүлээх үүрэг

Гэрээ цуцлах мэдэгдэлд тусгайлан заасан өдөр Нийлүүлэгч нь дараахь үүргийг хүлээнэ. Үүнд:

- (а) Гэрээ цуцлах мэдэгдлийн дагуу, түүнд заасан хэмжээгээр Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг яаралтай зогсоох;
- (б) Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг зогсоох хүртэлх өдрийн байдлаар (Гэрээ цуцлах мэдэгдэл хүлээн авсан өдрийг оролцуулан) Компаниас шаардсан маягтын дагуу дэлгэрэнгүй тайланг бэлтгэн Компанид өгөх;
- (в) Гэрээ хэрэгжих хугацааны туршид Компаниас Нийлүүлэгчид гарган өгсөн аливаа зүйлийг буцаан өгөх;
- (г) Нийлүүлэгчийн Гэрээг хэрэгжүүлэх зорилгоор хэрэглэсэн аливаа тоног төхөөрөмжийг түүний элдэгдэл тооцсон өртөг эсхүл талуудын харилцан тохиролцсон үнэлгээгээр Компанид худалдах санал тавих ба уг саналаас түрүүлж татгалзах эрхийг Компани хадгална;
- (д) Гэрээ цуцлахтай холбоотойгоор Компанийн үндэслэл бүхий шаардсан бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх зэрэг болно.

### 38.4 Нийлүүлэгчид нөхөн төлбөр олгох

- (а) Энэхүү 38-р заалтын дагуу Компани гэрээ цуцлах тохиолдолд Нийлүүлэгч нь Нийлүүлэлт хийхэд гарсан цалин хөлснөөс бусад дараахь зардлыг дан ганц Гэрээний улмаас учирсан буюу учирч болох бөгөөд түүнийг өөрөөр нөхөн төлөх эсхүл бууруулах боломжгүй тохиолдолд Компаниас нөхөн төлүүлэх эрхтэй. Үүнд:
  - (i) сайтаас Нийлүүлэгчийн үйлдвэрлэлийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой зардал;
  - (ii) Нийлүүлэгчийн ажилтныг ажилд авсан газар руу нь буцаан тээвэрлэхтэй холбоотой зардал зэрэг багтана.
- (б) 38.4(а)-д заасан мөнгөн дүнгийн хэмжээ нь зөвхөн 38-р заалтын дагуу Компани гэрээ цуцалсан тохиолдолд Компаниас Нийлүүлэгчид төлөх дүнг буюу нөхөн төлбөрийн хэмжээг илэрхийлнэ.

## 39. Нийлүүлэгч гэрээний үүргээ зөрчих, төлбөрийн чадваргүй байх

### 39.1 Нийлүүлэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай мэдэгдэл

Хэрэв Нийлүүлэгч Гэрээний аливаа нөхцөлийг зөрчсөн тохиолдолд Компани 39.2-т тодорхойлсон мэдээлэл бүхий Мэдэгдлийг (*Нийлүүлэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай мэдэгдэл*) Нийлүүлэгчид хүргүүлнэ.

### 39.2 Нийлүүлэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай мэдэгдэлд тавигдах шаардлага

Нийлүүлэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай мэдэгдэл нь:

- (а) Нийлүүлэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай мэдэгдлийг Нийлүүлэгчид хүргүүлснээс хойш 30-с доошгүй хоногийн дотор байх тусгайлан заасан хугацаанд аливаа зөрчлийг засч залруулахыг шаардах эсхүл тухайн зөрчил нь засагдах боломжгүй бол энэ талаар заах;
- (б) Хэрэв уг зөрчлийг Нийлүүлэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай мэдэгдэлд заасан хугацааны дотор засч залруулаагүй эсхүл тухайн зөрчил нь засагдах боломжгүй тохиолдолд Компани дараахь арга хэмжээний аль нэгийг эсхүл хэд хэдийг хэрэгжүүлж болохыг заасан буюу дор дурдсан мэдээлэл бүхий дараагийн Мэдэгдлийг Нийлүүлэгчид хүргүүлнэ. Үүнд:
  - (i) Нийлүүлэгч зөрчлийг засч арилгах хүртэл Гэрээний төлбөрийг хэсэгчлэн эсхүл бүхэлд нь зогсоохын аль нь болохыг дурдах;
  - (ii) Зөрчлийг залруулахад зайлшгүй шаардлагатай гэж Компанийн үзсэн тухайн арга хэмжээг авах (Компаниас авах тухайн арга хэмжээний зардал нь Нийлүүлэгчээс Компанид нөхөн төлөх нөхцөлтөйгөөр үүссэн Нийлүүлэгчийн Компанид өгөх өглөг болно.);
  - (iii) Гэрээг эсхүл түүний аль нэг хэсгийг тусгайлан заасан өдрөөр цуцлах (*Цуцлах өдөр*) зэргийг тусгана.

### 39.3 Гэрээг цуцлах үед хүлээх үүрэг

Хэрэв Компани 39.2(б)(iii)-д зааснаар Мэдэгдэл өгсөн бол тусгайлан заасан өдрөөр Гэрээ цуцлагдах бөгөөд Нийлүүлэгч нь дараахь үүргийг хүлээнэ. Үүнд:

- (а) Нийлүүлэгчийн гэрээний үүргээ зөрчсөн тухай мэдэгдлийн дагуу, түүнд заасан хэмжээгээр Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг яаралтай зогсоох;



- (б) Бүх ажилтны аюулгүй байдал болон бүх бараа бүтээгдэхүүний хадгалалт, хамгаалалтыг хангах боломжит бүх арга хэмжээг нэн даруй, өөрийн зардлаар авах;
- (в) Гэрээ цуцалсны улмаас үүссэн аливаа өр төлбөрийг багасгах бүх боломжит бүх арга хэмжээг нэн даруй авах;
- (г) Нийлүүлэгчийн Гэрээ хэрэгжүүлэх зорилгоор хэрэглэсэн аливаа тоног төхөөрөмжийг түүний элдэгдэл тооцсон өртөг эсхүл талуудын харилцан тохиролцсон үнэлгээгээр Компанид худалдах санал тавих ба уг саналаас түрүүлж татгалзах эрхийг Компани хадгална;
- (д) Гэрээ цуцлахтай холбоотойгоор Компанийн үндэслэл бүхий шаардсан бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх зэрэг болно.

#### **39.4 Хохиролгүй болгох**

Нийлүүлэгчийн гэрээний үүргээ зөрчсөн тухай аливаа мэдэгдэл эсхүл Гэрээ цуцлах тухай мэдэгдлийн нөхцөлөөс үл хамааран, энэхүү 39-р заалтын дагуу Компанийн зүгээс авч хэрэгжүүлсэн ямар ч арга хэмжээ нь холбогдох зөрчлийн улмаас Гэрээний дагуу Компанийн эдлэж болох аливаа эрх эсхүл хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг хязгаарлахгүй.

#### **39.5 Нийлүүлэгчийн төлбөрийн чадваргүй байдал ба дампуурал**

Хэрэв Нийлүүлэгч нь:

- (а) Дараахь нөхцөл байдалд байгаа компани бол:
  - (i) нийт өр зээл болон өр зээлийн зарим хэсгийн төлбөрийг зогсоосон эсхүл хойшлуулсан, эсхүл зогсоох, хойшлуулах талаар сануулга хүлээн авсан;
  - (ii) үүсгэн байгуулсан улсынхаа эрх зүйн тогтолцооны холбогдох хууль тогтоомжийн дагуу төлбөрийн чадваргүй болсон эсхүл аливаа гуравдагч талд дампууруулах болон татан буулгахаар шүүхэд өргөдөл гаргахыг нь хүлээн зөвшөөрөх тухай баримт бичиг гаргасан;
  - (iii) эд хөрөнгийн бүх болон зарим хэсэг, үйл ажиллагааг хариуцуулах зохицуулагчийг томилсон эсхүл зохицуулагч томилохын өмнөх ямар нэгэн арга хэмжээг авсан байгаа;
  - (iv) эд хөрөнгийн бүх болон зарим хэсэг, үйл ажиллагааг нь хяналтанд авах хянагч эсхүл түүнтэй төсөөтэй албан тушаалтныг томилсон;
  - (v) түүнийг татан буулгаж байгаа болон задарсан тухай, зохион байгуулалтанд орох, татан буулгах, нэгдэх, эсхүл түүний зээлдүүлэгчдийн бүгдийнх нь болон заримынх өрийг хаах зорилгоор эзэмшилд нь шилжүүлэх тухай өргөдөл болон тушаал гарсан, ажиллагааг эхлүүлсэн, шийдвэр гарсан, хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлд энэ талаар тусгасан эсхүл санал болгосон, шүүхэд өргөдөл гаргасан (хуурамч, залилангийн шинжтэй өргөдөл, ажиллагаа, мэдэгдэл эсхүл арга хэмжээ байх ёсгүй) болон үүнтэй холбоотойгоор эсхүл үүний эсрэг ямар нэгэн арга хэмжээ авагдсан байгаа; болон
- (б) хувь хүн байх тохиолдолд, дампуурсан эсхүл үйл ажиллагааг нь зогсоосон, эсхүл түүний эд хөрөнгийг зээлдүүлэгчдийнх нь өрийг хаах зорилгоор эзэмшилд нь шилжүүлсэн тухай баримт бичиг гаргасан бол,

Компани нь дараахь арга хэмжээ авч болно. Үүнд:

- (i) Нийлүүлэгчид болон Гэрээгээр эрх олгосон аливаа этгээдэд мэдэгдэл хүргүүлснээр Гэрээг цуцлах;
- (ii) Гэрээгээр эрх олгосон этгээдэд Гэрээт Нийлүүлэлтийг хангалттай гүйцэтгэж чадахаа Компанид баталгаажуулсан нөхцөлд Гэрээний дагуу гүйцэтгэхээр үлдсэн Нийлүүлэлтийн үнийн дүнгээр (Компанийн төлөөлөгч баталсаны дагуу) гүйцэтгэх сонголтыг өгөх зэрэг болно.

### **40. Компани гэрээний үүргээ зөрчих**

#### **40.1 Компани гэрээний үүргээ зөрчих**

Хэрэв Компани нь 15-р заалтад тодорхойлсноор Нийлүүлэгчид Гэрээний дагуу төлөх үүрэгтэй аливаа мөнгөн дүн бүхий төлбөрийг төлөөгүйн улмаас 15.4, 17, 21.4, 39.2(б)-д заасан эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд энэхүү 40-р заалт үйлчилнэ.

#### **40.2 Компани гэрээний үүргээ зөрчсөн тухай мэдэгдэл**

Хэрэв Компани Гэрээний үүргээ зөрчсөнөөс хойш 30 хоногийн дотор уг зөрчлийг арилгаагүй бол Нийлүүлэгч нь үүрэг зөрчсөн тухай мэдэгдлийг (*Компани гэрээний үүргээ зөрчсөн тухай мэдэгдэл*) Компанид хүргүүлнэ.

#### **40.3 Компани гэрээний үүргээ зөрчсөн тухай мэдэгдэлд тавигдах шаардлага**

Компани гэрээний үүргээ зөрчсөн тухай мэдэгдэл нь:

- (a) Компани гэрээний үүргээ зөрчсөн тухай мэдэгдлийг Компанид хүргүүлснээс хойш 30-аас доошгүй хоногийн дотор байх тусгайлан заасан хугацаанд Компанийн гэрээний үүргийн зөрчил буюу төлөх ёстой дүнгээр Нийлүүлэгчид төлбөр төлөхийг Компаниас шаардах;
- (б) хэрэв уг зөрчлийг Компани гэрээний үүргээ зөрчсөн тухай мэдэгдэлд заасан хугацааны дотор засч залуулаагүй тохиолдолд Нийлүүлэгч нь дор дурдсан арга хэмжээг авч болохыг заана. Үүнд:
  - (i) Компани зөрчлийг засч арилгах хүртэл Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг хэсэгчилэн эсхүл бүхэлд нь зогсоох; эсхүл
  - (ii) Компанид мэдэгдэл хүргүүлсэнээр Гэрээг цуцлах зэрэг болно.

#### 40.4 Нийлүүлэгчид нөхөн төлж болох зардлууд

- (a) 40.3(б)(ii)-т зааснаар Нийлүүлэгч Гэрээг цуцалсан тохиолдолд Нийлүүлэгч дараахь зардлыг Компаниар нөхөн төлүүлэх эрхтэй. Үүнд:
  - (i) Компанийн төлөх ёстой үнийн дүнгийн хэмжээгээр;
  - (ii) Нийлүүлэгч нь Нийлүүлэлт хийхэд гарсан цалин хөлснөөс бусад дараахь зардлыг (хэрэв байгаа бол) дан ганц Гэрээний улмаас учирсан буюу учирч болох бөгөөд түүнийг өөрөөр нөхөн төлөх эсхүл бууруулах боломжгүй тохиолдолд Компаниас нөхөн төлүүлэх эрхтэй. Үүнд:
    - (A) сайтаас Нийлүүлэгчийн үйлдвэрлэлийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой зардал;
    - (B) Нийлүүлэгчийн ажилтныг ажилд авсан газар уруу нь буцаан тээвэрлэхтэй холбоотой зардал зэрэг багтана.
- (б) 40.4(а)-д заасан мөнгөн дүнгийн хэмжээ нь зөвхөн 40.3 (б)(ii)-д заасны дагуу Нийлүүлэгч гэрээ цуцалсан тохиолдолд Компаниас Нийлүүлэгчид төлөх дүнг буюу нөхөн төлбөрийн хэмжээг илэрхийлнэ.

#### 40.5 Нийлүүлэгчийн бүртгэл тооцооны талаар мэдээлэл авах Компанийн эрх

40.4(а)(ii)-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор Нийлүүлэгч нь Компаниас Нийлүүлэгчийн нэхэмжилсэн мөнгөн дүнг нягтлах үүднээс шаардаж болох тайлан бүртгэл, тооцоо, дэвтэр болон холбогдох гэрээний талаар мэдээлэл (нууцлалын зэрэглэл тогтоон хориглосон тохиолдолд) авах эрхээр Компанийг хангана.

### 41. Маргаан шийдвэрлэх

---

#### 41.1 Маргаан

Компани ба Нийлүүлэгчийн хооронд Гэрээний улмаас үүссэн аливаа маргаан, асуулт болон ойлголцлын зөрүү гарсан (**Маргаан**) тохиолдолд нэг тал нь нөгөө талдаа 39-р заалтын дагуу маргаан болон түүнийг шийдвэрлэхийг шаардсан тухай тодорхой заасан мэдэгдлийг (**Маргааны тухай мэдэгдэл**) хүргүүлнэ.

#### 41.2 Талуудын маргаан шийдвэрлэх төлөөлөгчид

- (a) Хэрэв маргааны тухай мэдэгдлийг нөгөө Талд хүргүүлсэнээс хойш 7 хоногийн хугацаанд маргааныг шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Тал тус бүр өөрсдийн ахлах удирдлагаас нэг төлөөлөгчийг (**Маргааны төлөөлөгч**) маргаан шийдвэрлүүлэхээр нэр дэвшүүлнэ.
- (б) Хэрэв 30 хоногийн хугацаанд (эсхүл талуудын харилцан тохиролцсон тухайн хугацаанд) Маргааныг шийдвэрлэх хамтарсан шийдвэр гараагүй тохиолдолд Нийлүүлэгч болон Компани нь тухайн маргаантай асуудлыг UNCITRAL (НҮБ-ын олон улсын худалдааны хуулийн комисс)-ын Арбитрийн дүрмийн хүрээнд Сингапур улс дахь Олон Улсын Арбитрын Төвд шилжүүлэхээр харилцан тохиролцов. Арбитрын ажиллагаанд хэрэглэх хэл нь Англи хэл байх ба явагдах газар нь Сингапур улс байна. Арбитрын ажиллагааг талуудын харилцан зөвшөөрсөн хөндлөнгийн нэг (1) арбитрч эсхүл хэрэв талуудын нэг тал нь нөгөө талдаа арбитраар маргаан шийдвэрлүүлэх тухай эхний шаардлага тавьсанаас хойш гуч (30) хоногийн дотор нэг арбитрчийг сонгох тухай харилцан зөвшилцөж чадаагүй бол гурван (3) арбитрчийн бүрэлдэхүүнтэй баг (талууд тус бүр нэг арбитрчийг томилох ба томилогдсон арбитрч нар хамтдаа гуравдахь арбитрчийг сонгоно) удирдан явуулна. Арбитрч нар, Талууд, Маргааны төлөөлөгчид болон оролцогч нар нь аливаа арбитрын ажиллагаа, агуулга, үр дүнгийн нууцлалыг зохих ёсоор эсхүл холбогдох хуульд өөрөөр шаардсаны дагуу хангана.

#### 41.3 Маргаан үүссэн үед гэрээний үүргийн гүйцэтгэл

Аливаа маргаан үүссэн үед Талууд өөрөөр тохиролцоноос бусад тохиолдолд тэдний Маргаан дахь байр суурьнаас үл хамааран Гэрээний дагуу үүргийн гүйцэтгэлийг үргэлжлүүлэх ёстой.

#### 41.4 Яаралтай үед түр зуурын арга хэмжээг авч хэрэгжүүлэх

21.6(в) заалттай холбоотойгоос бусад тохиолдолд энэхүү 39-р заалт нь Гэрээний дагуу шаардагдаж болох, яаралтай үед авч хэрэгжүүлэх аливаа түр зуурын арга хэмжээг хориглохгүй.

## 42. Нууцлал

---

### 42.1 Нууцлалыг ханган үүрэг

Гэрээний аль ч тал дараахь үйл ажиллагааг явуулах ба зөвшөөрнө. Үүнд:

- (a) бүх нууц мэдээллийн нууцыг чанд хадгалж задруулахгүй байх, нууц мэдээлэл авч ашиглах зөвшөөрлийг дор дурдсан этгээдийн аливаа ажилтнаас бусад этгээдэд өгөхгүй. Үүнд:
  - (i) Нийлүүлэгч нь Нийлүүлэлтийг гүйцэтгэх зорилгоор нууц мэдээллийг шаардсан бол;
  - (ii) Компани нь Рио Тинто группийн үйл ажиллагаатай холбоотой нууц мэдээлэл шаардсан бол; болон
- (б) Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтэд зайлшгүй шаардлагатай болсон бөгөөд шаардагдах хэр хэмжээнээс хэтрүүлэлгүйгээр (хуулбарлах, дахин үйлдэх, тараах эсхүл шууд болон шууд бусаар нууц мэдээллээс ашиглах зэргийг оролцуулан) нэг тал нь нөгөө талдаа энэ тухай урьдчилан бичгээр зөвшөөрөл (аль нэг талын өөрийн үзэмжээр тухайн мэдээллийг бусдад задруулахыг хориглосон эсхүл авч ашиглахыг зөвшөөрсөн тухай) олгосноос бусад тохиолдолд Нууц мэдээллийг авч ашиглахгүй байх зэрэг болно.

### 42.2 Онцгой тохиолдол

42.1 дэх заалт дараахь тохиолдолд хамаарахгүй. Үүнд:

- (a) Нийлүүлэгчид нууцлалын талаар оногдуулсан аливаа нэг үүрэг эсхүл энэхүү 40-д заасныг зөрчсөнөөс бусад тохиолдолд нэгэнтээ нийтийн хүртээл болсон мэдээлэл
- (б) аливаа хууль тогтоомж, хуулийн хүчин чадал бүхий шүүхийн тогтоол, Засгийн газрын эрх бүхий байгууллагаас эсхүл нэр хүнд бүхий хөрөнгийн биржээс гаргасан аливаа шийдвэрийг биелүүлэх зорилгоор Нийлүүлэгчээс тухайн мэдээллийн дэлгэрэнгүй танилцуулга бүхий мэдэгдлийг Компанид урьдчилан өгсөн зэрэг болно.

### 42.3 Нийлүүлэгч хүлээн зөвшөөрөх

- (a) Нийлүүлэгч энэхүү 42-р заалт нь Компанийн төдийгүй аливаа аливаа нууц мэдээллийг авах сонирхол бүхий Рио Тинто Группийн аль ч гишүүний ашиг тусын тулд байхыг хүлээн зөвшөөрнө.
- (б) Нийлүүлэгч энэхүү 42-р заалтаас үл хамааран Рио Тинто Группийн аливаа гишүүнд Нийлүүлэгчээс хангасан нууц мэдээллийг өөрийн үйл ажиллагааны дотоод хэрэгцээнд ашиглаж болохыг, түүнчлэн Рио Тинто Группийн тухайн гишүүн нь энэхүү 40-р заалтад тусгасан мэдээллийн нууцлалыг хамгаалахтай холбогдон үүрэг хүлээх шаардлагатай талаар хүлээн зөвшөөрч мэдэгдэнэ.

### 42.4 Нөхөн төлбөр

34-р заалтаар үл хязгаарлагдан, Нийлүүлэгч, түүний аливаа ажилтан энэхүү 40-р заалтыг зөрчсөний улмаас Компани болон Рио Тинто Группийн гишүүн бүрт учруулсан аливаа хохирол, хүлээсэн алдагдлыг Нийлүүлэгч нөхөн төлж, тэдгээрийг хохиролгүй болгох ёстой.

### 42.5 Нэмэлт хариуцлага

Энэхүү энэхүү 40-р заалтад тусгасан үүрэг нь нийтийн эрх зүйн болон аливаа хууль журмын хүрээнд эсхүл худалдааны болон мэргэжлийн хэрэгцээний нууц мэдээлэлтэй холбоотойгоор талуудын хүлээх үүрэг дээр нэмж хэрэгжих ба тухайн үүргийг бууруулж зохицуулахгүй.

### 42.6 Нууц мэдээллийг буцаах

Хэрэв Гэрээ дуусгавар болохоос өмнө болон хойно, эсхүл уг хугацаанаас өмнө гэрээ цуцлагдсан эсэхийг харгалзахгүйгээр, гэрээний аль нэг тал хүсэлт гаргасан бол нөгөө тал нь Компанийн хадгалалт хамгаалалт, эзэмшил эсхүл хяналтанд байдаг бүх мэдээллийг нэн даруй буцаах ёстой.

## 43. Нийтэд зарлан мэдээлэх

---

Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмаар шаардсанаас эсхүл Гэрээнд өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд Нийлүүлэгч нь Компанийн бичгээр үйлдсэн зөвшөөрөлгүйгээр Гэрээний агуулгаас өөрөөр олон нийтэд аливаа мэдээлэл хийж болохгүй. Үүнтэй холбоотойгоор Компанийн бичгээр үйлдсэн зөвшөөрөлгүйгээр эсхүл тухайн зөвшөөрлийг Компаниас олгосон байх шаардлагатай тохиолдолд Гэрээний талаар хэвлэл мэдээллээр цацах эсхүл олон нийтэд хүргэх аливаа мэдээлэлийн үг хэллэг болон нийтлэлийн агуулга дээр Компаниас бичгээр зөвшөөрөл авсан байх шаардлагатай.

#### 44. Үйлчилгээний оюуны өмчийн эрх

##### 44.1 Нийлүүлэгчийн оюуны өмч

- (a) Нийлүүлэгч нь Нийлүүлэгчийн оюуны өмчийг эзэмшигч хэвээр үлдэх ба Гэрээний аль ч заалт Нийлүүлэгч Нийлүүлэгчийн оюуны өмчийг хэрэглэх, ашиглахыг хориглох, хязгаарлахгүй гэж Компани хүлээн зөвшөөрнө.
- (b) Нийлүүлэгч нь Компанид үйлчилгээний ашиг тусыг хүртэх, бараа бүтээгдэхүүнийг хэрэглэхэд шаардлагатай эрхийг бий болгох үүднээс Рио Тинто Группийн бизнестэй холбоотойгоор түүний үйл ажиллагааны зорилгын хүрээнд Нийлүүлэгчийн бүх оюуны өмчийг компани онцгой бус эрхтэй, шилжүүлэх боломжтой, үнэ төлбөргүй, эргэлт буцалтгүй, хугацаагүй нөхцөлөөр эзэмших тусгай зөвшөөрөлд баталгаа гаргаж өгнө.

##### 44.2 Гэрээний Оюуны өмч

- (a) Нийлүүлэгч нь Гэрээний бүх оюуны өмч үүсэхдээ Компанийн эрх мэдэлд байх ба Компанийн өмч байхыг хүлээн зөвшөөрч, Нийлүүлэгч Гэрээний оюуны өмч (Гэрээ хэрэгжиж эхлэх өдөр эсхүл түүнээс өмнө эсхүл түүнээс хойш үүссэн) дэх өөрийн эзэмших эрх, сонирхлыг Компанид шилжүүлэх, мөн Нийлүүлэгчийн бүх ажилтнууд Гэрээний өмчтэй холбоотой харгалзах эрхүүдийг компанид шилжүүлэхийг хариуцна.
- (b) Компанийн хүсэлтээр Нийлүүлэгч нь энэхүү 44.2-р заалтад нөлөө үзүүлэхэд шаардагдах аливаа албан даалгавар болон бусад баримт бичгийг гүйцэтгэх үүрэгтэй.

##### 44.3 Нийлүүлэгчийн оюуны өмчид давхар зөвшөөрөл олгох

Компани нь Нийлүүлэгчийн оюуны өмчийг ашиглах тухай 44.1(б)-д заасан эрхийг Рио Тинто Группийн бизнестэй холбоотойгоор ашиглах аливаа этгээдэд давхар ашиглах зөвшөөрөл олгож болно

##### 44.4 Рио Тинтогийн Оюуны өмч

- (a) Нийлүүлэгч нь Компани эсхүл Рио Тинто Группийн гишүүн нь Рио Тинтогийн бүх оюуны өмчийн эзэмшигч хэвээр үлдэх ба Гэрээний аль ч заалт Рио Тинтогийн оюуны өмчийг хэрэглэх ашиглахад нь Компани ба Рио Тинто Группийн гишүүнийг хорих буюу хязгаарлахгүй гэж Нийлүүлэгч хүлээн зөвшөөрнө.
- (b) Зөвхөн Нийлүүлэлт хийх зорилгын хүрээнд Рио Тинтогийн оюуны өмч ба Гэрээний оюуны өмчийг онцгой бус эрхтэй, шилжүүлэх боломжгүй, буцаах нөхцөлтэйгөөр ашиглах эрхийн зөвшөөрлийн баталгааг Нийлүүлэгчид Компани гаргаж өгөх буюу Рио Тинтогийн Оюуны өмчийг эзэмшигч нь Компаниас бусад Рио Тинто Группийн гишүүн бол энэхүү зөвшөөрлийн баталгааг худалдан авч Нийлүүлэгчид өгнө.
- (c) Нийлүүлэгч нь Нийлүүлэлт хийх зорилгоос бусад ямар ч зорилгын төлөө Рио Тинтогийн оюуны өмч болон Гэрээний оюуны өмчийг хэрэглэх, бүртгүүлэх эсхүл аливаа сонирхлоор бүртгүүлэхийг оролдох ба үүнтэй адил аливаа үйлдэл хийхийг бусад аливаа этгээдэд зөвшөөрч болохгүй.

##### 44.5 Нийлүүлэгчийн баталгаа

Нийлүүлэгч нь дараахь тохиолдолд баталгаа гаргана:

- (a) Нийлүүлэгч нь заалтын дагуу Компанид зөвшөөрөл гаргаж өгөх эрхтэй; ба
- (b) Нийлүүлэгч нь 44.2. заалтын дагуу Гэрээний бүх Оюуны өмчийг Компанид шилжүүлэх эрхтэй.

##### 44.6 Нийлүүлэгчийн ерөнхий үүрэг

Нийлүүлэгч дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

- (a) Гэрээний оюуны өмч үүсэх үед түүнийг Компанид танилцуулах;
- (b) Гэрээний зорилгын дагуу Туслан гүйцэтгэгчийн үүсгэсэн аливаа оюуны өмч дэх бүх Оюуны өмчийн эрхийг Туслан гүйцэтгэгч Компанид шилжүүлэхийг багтаасан Гэрээтэй холбоотойгоор Нийлүүлэгчийн байгуулах аливаа туслах гэрээг баталгаажуулах;
- (c) Гэрээний Оюуны өмч дэх оюуны өмчийн эрхийн сэжигтэй, дохио өгсөн эсхүл бодит зөрчил мөн оюуны өмчийн эрхийг зөвшөөрөлгүй хэрэглэсэн талаар Нийлүүлэгч мэдсэн даруйдаа Компанид мэдэгдэх ба тэрхүү зөрчилтэй холбоотой боломжит бүх тусалцааг үзүүлэх;
- (d) Гэрээний Оюуны өмчийн доторх өөрийн сонирхол ба Гэрээний оюуны өмчийг хэрэглэх, ашиглах эрхийг хамгаалах, сайжруулах, сахиулах, зөвтгөхөөр гаргасан Компанийн хүсэлтэд Нийлүүлэгч боломжит бүх тусалцааг үзүүлнэ. Мөн Нийлүүлэгч нь түүний ажилтан энэхүү 44.2-д тусгасан боломжит бүх тусламжаар Компанийг хангаж буйг баталгаажуулна.

#### 45. Гуравдагч талын оюуны өмчийн эрх

##### 45.1 Гуравдагч талын Оюуны өмчийн эрх

Нийлүүлэгч нь бараа бүтээгдэхүүний Нийлүүлэлтийн биелэлтэд аливаа гуравдагч талын Оюуны өмчийн эрхийг ашиглах болон ашиглахыг санал болгох эсвэл Компани нь Нийлүүлэлтийн хэрэглээнд болон түүний ашиг ашгийг хүртэх явдалд аливаа гуравдагч талын Оюуны өмчийг ашиглах эсвэл ашиглахыг санал болгоход дор дурдсан байдлаар баталгаа гаргана:

- (a) Нийлүүлэгч нь тухайн гуравдагч талын шаардлагатай бүх Оюуны өмчийг эрхийг ашиглах лиценз, зөвшөөрөл авах болон эрхийг шилжүүлэн авахдаа Компаниас ямар нэг зардал гаргахгүй.
- (b) Нийлүүлэгч нь 45.1(a) заалтад тусгасан аливаа тусгай зөвшөөрөл болон эрхийн шилжүүлэхтэй холбоотой заалтыг зөрчихгүй.

##### 45.2 Нөхөн төлбөр

- (a) 34-р заалтаар үл хязгаарлагдан Нийлүүлэгч нь дараахь шалтгааны улмаас үүсэх аливаа Гуравдагч талын Оюуны өмчийн бодит болон сэжиг бүхий зөрчлийн улмаас компанид учирсан хохирлыг нөхөн төлөх ба Компанийн нөхөн төлбөр авах эрхийг хадгална. Үүнд:
  - (i) Нийлүүлэгчийн гүйцэтгэсэн Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт;
  - (ii) Нийлүүлэгчийн ашигласан болон нийлүүлсэн бусад аливаа үйлдвэрийн газрын үйл ажиллагааны гүйцэтгэл, тоног төхөөрөмж, машин, сэлбэг хэрэгсэл, хэрэглэл, ажил, материал;
  - (iii) Компанийн хэрэглэсэн болон үр ашгийг нь хүртсэн бараа бүтээгдэхүүн, хүлээн авсан холбогдох үйлчилгээ.
- (b) Нийлүүлэгч нь 45.2(a)-д зааснаар Компанид нөхөн төлбөрт хамрагдах аливаа зүйлтэй холбоотойгоор аюул учирсныг мэдсэн даруйдаа Компанид мэдэгдэнэ.
- (c) Компани нь 45.2(b)-д заасантай холбоотой шаардлагаас үүсч болох аливаа нэхэмжлэл болон тухайн нэхэмжлэлийг шийдвэрлэх бүх хэлэлцээг зохион байгуулахыг Нийлүүлэгчээс хүсч болно. Гэвч Нийлүүлэгч нь компанийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр аливаа компанийн эсрэг ямар нэгэн шүүхийн шийдвэр, тушаал, тогтоолын өмнө ямарваа шийдвэр болон зөвшөөрлийг үйлдэх ёсгүй.

##### 45.3 Оюуны Өмчийн Эрхийн Худалдан авах ажиллагаа

Хэрэв Компани нь оюуны Өмчийн Эрхийн зөрчилтэй холбоотой аливаа нэхэмжлэлийн улмаас нийлүүлсэн бараа бүтээгдэхүүнийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хэрэглэхээс саатуулагдсан бол Нийлүүлэгч нь Нийлүүлэлт ба холбогдох үйлчилгээний аливаа хэсгийг түүний зориулалтын дагуу хэрэглэх эрхийг компанид худалдан авч өгөх боломжит бүх арга хэмжээг (өөрийн зардлаар) авах үүрэгтэй.

##### 45.4 Оюуны өмчийн эрх худалдан авах боломжгүй үеийн журам

Хэрэв Нийлүүлэгч нь 45.3-р заалтад тусгагдсан эрхийг боломжит хугацаанд (Компанийн төлөөлөгч өөрөөр зөвшөөрөөгүй бол 60 хоногийн хугацаанаас хэтрүүлэхгүй) худалдан авах боломжгүй бол тэр талаар компанийн Төлөөлөгчид мэдэгдэх үүрэгтэй ба Компанийн төлөөлөгч дараахь журмаар Нийлүүлэгчийг (Нийлүүлэгчийн зардлаар) чиглүүлж болно. Үүнд:

- (a) Оюуны өмчийн эрхийн зөрчил болон бусад зөрчлөөс зайлсхийхээр Бараа бүтээгдэхүүн ба Холбогдох үйлчилгээг эсхүл Бараа бүтээгдэхүүн ба Холбогдох үйлчилгээний зарим хэсгийг өөрчлөх;
- (b) Бараа бүтээгдэхүүн ба Холбогдох үйлчилгээ эсхүл Бараа бүтээгдэхүүн ба Холбогдох үйлчилгээний зөрчилд нөлөөлөх холбогдох хэсгийг Оюуны өмчийн эрхэд зөрчилдөхгүй ажил ба бараа бүтээгдэхүүнээр орлуулах, холбогдох үйлчилгээг дахин гүйцэтгэх;
- (c) бараа бүтээгдэхүүнийг буцаан шилжүүлэх болон холбогдох үйлчилгээг зогсоох ба мөн Компанийн нөхөн төлбөр болон компаниас Нийлүүлэгчид төлөгдсөн мөнгийг буцаан төлж зогсоосон үйлчилгээ ба буцаан шилжүүлсэн бараа бүтээгдэхүүнтэй холбоотойгоор Компанид үүсч болох аливаа зардал болон бусад төлбөрийг төлнө.

##### 45.5 Ёс суртахууны эрх

- (a) Нийлүүлэгч (өөрийн зардлаар) нь Хуулийн дагуу Компаниас шаардах боломжтой дор дурьдсан үйл ажиллагааг хууль ёсоор хэрэгжүүлэх зорилгоор буцалтгүй болон гарцаагүйгээр нөхцөл бүхий зөвшөөрлийг Нийлүүлэгчийн тусын тулд (Нийлүүлэгчийн болон түүний үйлчлүүлэгчийн тусын тулд, үүнд Компани багтана) Нийлүүлэгчийн ажилтан болон Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтэд оролцогч аливаа гуравдагч талын ажилтан бүрээс худалдан авна. Үүнд:

- (i) Үйлчилгээтэй холбоотой аливаа материалыг (хамтад нь **Материал** гэх) эсхүл түүний шинэчлэлтийг (эсхүл Материалын болон тухайн шинэчлэн өөрчлөлтийн аливаа хэсэг) Компаниас дахин үйлдвэрлэж, шилжүүлж, харилцаж, шинэчилж компаниас тохирно гэж үзсэн аль ч хэлбэрээр (Материал болон тохируулагад эсвэл материал болон тохируулгын аливаа хэсэгт хийгдсэн аливаа гажуудал, нэмэлт, хувиралтыг багтаана) дэлхийн хаана ч дахин үйлдвэрлэх, дамжуулах, харилцах, шинэчлэх, нийтлэхийг;
  - (ii) Дахин үйлдвэрлэлт, шилжүүлэлт, холболт, шинэчлэлт, нийтлэлийн талаар ажил олгогч/гүйцэтгэгч/гуравдагч талын аливаа тодотгол үйлдэхгүйгээр Материалууд болон тэдгээрийн шинэчлэлийг (материал болон тухайн тохируулгын аливаа хэсэг) дэлхийн хаана ч дахин үйлдвэрлэх, шилжүүлэх, холбох, шинэчлэх ба нийтлэхийг;
  - (iii) Ажил олгогч/гүйцэтгэгч/гуравдагч талын аливаа ёс суртахууны эрхийн болон түүнтэй төстэй эрхийг зөрчихөөс өөрөөр Материалтай холбоотой ямарч бүх үйл ажиллагааг дэлхийн хаана ч хийхийг зэрэг болно.
- (b) Компани нь Нийлүүлэгчийг 45.5-д заасан үүргээ биелүүлээгүй нь үндэслэлтэй гэж үзвэл Нийлүүлэгч нь 45.5-д тусгагдсан аливаа зүйлийг батлах болон түүнд нөлөөлөх үүднээс Компанийн үндэслэл бүхий гаргасан хүсэлтийн дагуу Нийлүүлэгчийн болон Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтэд оролцогч гуравдагч талын ажилтан бүрийн тухайн бүх зүйлийг хийсэн болон тухайн бүх баримт бичгүүдийг боловсруулсан ажиллагааг худалдан авах үүрэгтэй.

## **46. Мэдэгдэл**

---

### **46.1 Мэдэгдлийн хэлбэр**

Гэрээнд өөрөөр заагаагүй бол Гэрээний дагуу хийгдэх эсхүл хүргүүлэх аливаа мэдэгдэл, шаардлага, зөвшөөрөл болон бусад харилцаа холбоо (**Мэдэгдэл**) нь:

- (a) Бичгээр хийгдсэн;
- (б) Мэдэгдэл хүргүүлэх буюу хаяглагдсан талд "Компанийн Нарийн бичиг"-ын анхаарлыг татах тэмдэглэгээтэй;
- (в) Компаниас гаргаж буй тохиолдолд Компанийн төлөөлөгч болон компанийн нарийн бичиг эсхүл захирлын аль алины гарын үсэг зурж баталгаажуулсан эсхүл Компанийн төлөөлөгч албан ёсоор баталсан;
- (г) Нийлүүлэгчээс гаргаж буй тохиолдолд Нийлүүлэгчийн төлөөлөгч болон Нийлүүлэгчийн нарийн бичиг эсхүл захирлын аль алины гарын үсэг зурж баталгаажуулсан эсхүл Компанийн төлөөлөгч албан ёсоор баталсан;
- (д) Мэдэгдэл хаяглагдсан талын Гэрээнд дурдсан хаягаар эсхүл тухайн тал нь нөгөө талд мэдэгдсэн өөр бусад хаягаар гарт нь эсхүл факсаар, урьдчилсан төлбөрт шуудангаар хүргүүлнэ.

### **46.2 Мэдэгдлийг хүлээн авсан гэж үзэх**

Мэдэгдлийг дараахь тохиолдолд албан ёсоор хүргэгдсэн гэж үзнэ. Үүнд:

- (a) гарт нь хүргүүлэхээр илгээхэд мэдэгдэл хүргэгдсэн бол;
- (б) Шуудангаар илгээх тохиолдолд, илгээсэн өдрөөс хойш ажлын 2 хоног (нэг улс доторх хаяг уруу илгээсэн бол) эсхүл илгээсэн өдрөөс хойш ажлын 7 хоног (өөр улс дахь хаяг уруу илгээсэн бол);
- (в) Факсаар илгээх тохиолдолд, Илгээгчийн илгээх машины хяналтын тайлан дээр харагдаж буй илгээсэн хуудасны тоо, хүлээн авах факсын машины дугаар, хүлээн авагчийн нэр болон дугаар, түүнчлэн дамжуулалт алдаагүй хийгдсэнийг гэрчлэх мэдээллийг үндэслэх

боловч хэрэв Мэдэгдэл хүргэгдэх эсхүл үйлдэгдэх өдөр ажлын өдөр биш бол эсхүл Мэдэгдэл 16 цагаас (орон нутгийн цагаар) хойш илгээсэн тохиолдолд Мэдэгдлийг дараагийн ажлын өдрийн ажил эхлэхэд албан ёсоор хүргэгдсэн гэж үзнэ.

## **47. Ашиг сонирхлын зөрчил**

---

### **47.1 Нийлүүлэгчийн баталгаа**

Нийлүүлэгч нь Гэрээний хэрэгжилт эхлэх өдөр ажлаа эхлүүлээгүй тохиолдолд энэ нь Нийлүүлэгч, түүний ажилтныг Гэрээний дагуу Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг хийж гүйцэтгэхэд ямар нэг байдлаар саад тотгор учруулахгүй, аливаа санхүүгийн хэлэлцээр байгуулахгүй гэдгийг батална.

### **47.2 Ашиг сонирхлын зөрчил**

Нийлүүлэгч нь Компанийн бичгээр олгосон зөвшөөрлийг урьдчилан авалгүйгээр өөрөө болон түүний аль ч ажилтан үйл ажиллагаа явуулахгүй, аливаа санхүүгийн хэлэлцээр байгуулахгүй, Гэрээний дагуу Бараа бүтээгдэхүүний

нийлүүлэлтийг хийж гүйцэтгэхэд ямар нэг байдлаар саад тотгор учруулах, зөрчил үүсгэх үүргийг биелүүлэхгүй гэдгийг батална.

#### **47.3 Нөхөн төлбөр**

34-д заасныг үл хязгаарлан, Нийлүүлэгч 47.1-д заасан баталгаа гаргаагүй эсхүл 47.2-д заасан ажиллагааг зөрчсөний улмаас Компанид учруулсан аливаа хохирол, хүлээсэн алдагдлыг Нийлүүлэгч нь нөхөн төлж хохиролгүй болгох ёстой.

### **48. Бизнесийн стандарт**

---

#### **48.1 Авлигын эсрэг**

Тал тус бүр өөрсдийн ажилтныг нөгөө талын ажилтанд болон салбаруудад уг ажилтныг өөрийнх нь талын туйлын ашиг сонирхлын эсрэг үйл ажиллагаа явуулахад нөлөөлөх зорилгоор аливаа хууль бус буюу зохисгүй бэлэг, үзвэр үйлчилгээ, төлбөр, зээл, бусад шагнал урамшуулал, анхаарал халамж өгөх, үйлдэх, хүлээн авах эсхүл энэ талаар санал тавих явдлаас урьдчилан сэргийлэх журам заавар, бодлого зохицуулалт, арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **48.2 Албан тушаалтанд шударга бусаар давуу байдал, ашиг орлого бий болгох**

- (а) Энэхүү гэрээтэй холбогдуулан Тал тус бүр болон тэдгээрийн ажилтнууд нь шинээр ажлын боломж олж авах, үргэлжлүүлэх болон удирдан явуулах, эсхүл үйл ажиллагаандаа хууль бус давуу байдлыг үүсгэн хамгаалуулах зорилго агуулсан аливаа хээл хахууль, шударга бус давуу байдлыг шууд болон шууд бусаар санал тавих, үүрэг амлалт авах, өгөх, хүсч шаардах эсхүл хүлээж авах ёсгүй болно.
- (б) Энэхүү гэрээний талаар хийгдэх хэлэлцээ болон гүйцэтгэлтэй холбогдуулан Тал тус бүр болон тэдгээрийн ажилтнууд нь шинээр ажлын боломж олж авах, үргэлжлүүлэх болон удирдан явуулах, эсхүл үйл ажиллагаандаа хууль бус давуу байдлыг үүсгэн хамгаалуулах зорилго агуулсан аливаа хээл хахууль, шударга бус давуу байдлын талаар шууд болон шууд бусаар санал тавиагүй, үүрэг амлалт аваагүй, өгөөгүй, хүсч шаардаагүй эсхүл хүлээж аваагүй гэдгээ илэрхийлж баталгаажуулна.

#### **48.3 Ашиг сонирхлын өөрчлөлтийн талаар мэдэгдэх**

Тал тус бүр 46-д заасан заалтуудыг энэхүү гэрээний суурь нөхцөл болохыг хүлээн зөвшөөрөх бөгөөд анх дурдсан Тал болон түүний аливаа ажилтан энэхүү заалтыг мөрдөөгүй талаар аливаа тохиолдлыг олж мэдмэгц энэ тухай нөгөө талдаа нэн даруй мэдэгдэнэ.

#### **48.4 Туслан гүйцэтгэгчид хамаарах заалт**

Нийлүүлэгч нь Туслан гүйцэтгэгчээс 48-д тодотгож заасантай адил агуулгатай гэрээний зохицуулалтыг мөрдөх, түүнийг хүлээн зөвшөөрөхийг шаардах ёстой.

#### **48.5 Заалтыг биелүүлээгүй талаархи мэдэгдэл**

Нийлүүлэгч нь Нийлүүлэгч, түүний ажилтныг энэхүү 46-р заалтыг мөрдөөгүй талаар аливаа тохиолдлыг олж мэдмэгц энэ тухай Компанид нэн даруй мэдэгдэх үүрэгтэйг хүлээн зөвшөөрнө.

### **49. Хууль бус мэдээллийн зуучлал**

---

#### **49.1 Хууль бус мэдээллийн зуучлал**

Хууль бус мэдээллийн зуучлал эсхүл гэрээ байгуулах явцад аливаа авлигын үйл ажиллагааг Компани хориглосон болохыг Нийлүүлэгч мэдэх шаардлагатай бөгөөд Нийлүүлэгч нь Гэрээтэй холбоотойгоор хууль бус мэдээллийн зуучлалыг ашиглаагүй мөн ашиглахгүй гэдгээ илэрхийлж баталгаажуулна.

#### **49.2 Мэдэгдэл**

- (а) Хэрэв хэн нэгэн этгээд Нийлүүлэгчид Гэрээний талаар эсхүл Компанийн аливаа бусад бизнесийн ашиг сонирхолтой холбоотойгоор Хууль бус мэдээллийн зуучлал бүхий зорилго агуулан хандсан тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай Комданийн төлөөлөгчид нэн даруй мэдэгдэх ёстой.
- (б) 49.2(а)-д зааснаар холбогдох мэдэгдлийг хүлээн авсны дараа:
  - (i) Тухайн мэдэгдэл болон Нийлүүлэгчийн ирүүлсэн аливаа холбогдох мэдээллийг Компанийн бүрэн эрхийн дагуу авч хэлэлцэн шийдвэрлэх
  - (ii) Компани нь тухайн мэдэгдлийн гарахад хүргэсэн аливаа үйлдлийн үр дүнд аль нэг гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч эсхүл Нийлүүлэгчийг шударга бус давуу байдал олж авахаас сэргийлэх зорилгоор нэмэлт баталгаа гаргуулах арга хэмжээг холбогдох шаардлагын дагуу авч хэрэгжүүлнэ.

### **50. Монгол Улсын хөгжилд оруулах хувь нэмэр/олон нийтийн харилцаа**

---

- (а) Хэрэв шаардлагатай бол Нийлүүлэгч нь:

- (i) Хавсралт F-д нарийвчлан тусгасан, орон нутгийн болон бүс нутгийн шинж чанартай өөрийн үүрийг биелүүлнэ;
  - (ii) Гэрээний хэрэгжиж Эхлэх өдрөөс хойш 30 хоногийн дотор Хавсралт F-д нарийвчлан тусгасан дотоодын болон бүс нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийн үүргийг хэрэгжүүлэх дэлгэрэнгүй төлөвлөгөөг Компанид гаргаж өгнө.
- (б) Компани нь Хавсралт F -ийн биелэлтийг баталгаажуулах үүднээс Нийлүүлэгчийг шалгах, аудит хийх эрхтэй байх бөгөөд хэрэв зөрчил, дутагдал илэрсэн тохиолдолд дараахь арга хэмжээг авч болно. Үүнд:
- (i) Нийлүүлэгчийг зөрчлийг засч залруулах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлж уг арга хэмжээг хэрэгжүүлсэн тухай Компанид мэдэгдэх тухай зааварчлах; эсхүл
  - (ii) 48-р заалтыг биелүүлээгүй нь Гэрээний дагуу үүргээ зөрчсөнд тооцох үндэслэл гэж үзэх зэрэг болно.

## **51. Зардал**

---

### **51.1 Талууд өөрсдийн зардлыг хариуцах**

Тал тус бүр дараахь тохиолдлын улмаас үүссэн өөрсдийн зардлыг хариуцна. Үүнд:

- (а) Гэрээний хэлэлцээ хийх, бэлтгэл ажил болон хэрэгжүүлэх;
- (б) Гэрээнд өөрөөр тусгайлан заагаагүй бол Гэрээний хэрэгжилтийн үед хянагдсан бусад гүйлгээтэй холбогдох зардлууд байна.

### **51.2 Тэмдэгтийн хураамж**

Аливаа холбогдох хууль тогтоомжийн дагуу эсхүл Гэрээ, аливаа худалдан авалтын захиалга болон бусад баримт бичгүүд (аливаа Баталгааг оролцуулан)-тэй холбоотойгоор төлөгдөх шаардлагатай байж болох бүхий л тэмдэгтийн хураамжийг Нийлүүлэгч хариуцна.

## **52. Нийлүүлэгчийн статус**

---

### **52.1 Хараат бус гүйцэтгэгч**

Гэрээ хэрэгжих бүхий л хугацааны туршид буюу Нийлүүлэлт хийх үед Нийлүүлэгч нь хараат бус гүйцэтгэгч байх бөгөөд Компанийн ажилтан, агент буюу харьяа байгууллага нь байх тохиолдолд Нийлүүлэгч, түүний ажилтан нь Компанийн аливаа ажилтны тогтмол хангагддаг ямар нэг урамшуулал, нэмэгдэл зэргийг тэдгээрийн нэгэн адил статус бүхий давуу эрхээр хүлээн авах эрхгүй болно.

### **52.2 Түншлэл, хамтарсан нийлүүлэгч**

Нийлүүлэгч нь нэгээс олон этгээдээс бүрдэж байгаа тохиолдолд тэдгээр нь Гэрээг хэрэгжүүлэхэд хамтын болон тус тусын хариуцлага хүлээн гэдгээ албан ёсоор тодорхойлж, Гэрээний дагуу учирч болох аливаа алдагдал, гарз хохирол болон Гэрээний нөхцөлийн дагуу Компанид төлөх шаардлага үүсч болох аливаа дүнг хамтран болон тус тусдаа хариуцахыг хүлээн зөвшөөрнө.

## **53. Эрх, үүргээ шилжүүлэх болон Туслан гүйцэтгүүлэх**

---

### **53.1 Компани зөвшөөрөл олгох**

Нийлүүлэгч Компанийн бичгээр үйлдсэн зөвшөөрлийг урьдчилан авалгүйгээр Гэрээний бүх эсхүл аль нэг хэсгийг туслан гүйцэтгүүлэхийг хориглох ба уг зөвшөөрөлд Компанийн өөрийн шаардлагатай гэж үзсэн холбогдох нөхцөл, болзол болон санал болгож буй Туслан гүйцэтгэгчийг Гэрээний аль нэг бүх нөхцөл заалтыг дагаж мөрдөхийг шаардсан тухай дурдсан байна.

### **53.2 Туслан гүйцэтгүүлэх эсвэл эрх үүрэг шилжүүлэхэд хүчинтэй байх үүрэг**

Нийлүүлэгч нь зөвшөөрөл авсан хэдий боловч аливаа нэг туслан гүйцэтгүүлэх ажиллагаа нь Нийлүүлэгчийг Гэрээний дагуу түүний гүйцэтгэх аливаа үүргийн биелэлтээс ямар нэгэн байдлаар чөлөөлөхгүй гэдгийг хүлээн зөвшөөрч баталгаажуулна.

### **53.3 Туслан гүйцэтгэгчийн статус**

Компани болон Нийлүүлэгчтэй хамтран ажиллаж байгаа Туслан гүйцэтгэгч нь Нийлүүлэгчийн агент буюу ажилтан гэж тооцогдоно. Гэрээг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд Туслан гүйцэтгэгч, түүний аливаа ажилтны үйлдэл, эс үйлдэхүйг Нийлүүлэгчийн үйлдэл, эс үйлдэхүй гэж үзнэ.



## 54. Хувийн мэдээллийн хамгаалах

### 54.1 Хувь хүний мэдээлэл

Тал тус бүр Гэрээний дагуу хүлээж авсан болон нийтэд хүртээл болсон аливаа хувийн мэдээлэлтэй холбоотойгоор Хувийн мэдээллийн нууцлал ба хамгаалалттай холбоотой харилцааг зохицуулсан бүх хууль тогтоомжид заасан үүргийг биелүүлнэ гэдгийг хүлээн зөвшөөрнө.

### 54.2 Баталгаа

Тал тус бүр Гэрээний дагуу Хувийн мэдээлэлтэй холбоотойгоор (цуглуулах, ашиглах, нээлттэй болгох, хадгалах ба хамгаалах зэргийг оролцуулан) холбогдох бүх хууль тогтоомжийг мөрдөж ажиллаж байгаа болон үргэлжүүлэн мөрдөх тухай баталгааг нөгөө талдаа гаргаж өгнө.

### 54.3 Мэдээллийн хамгаалалт

54.1 болон 54.2-т зааснаас гадна Нийлүүлэгч нь дор дурдсан ажиллгааг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- (a) Компанийн хувийн мэдээллийг зөвхөн Гэрээний дагуух өөрийн үүргийн гүйцэтгэлд зориулан, түүнчлэн Компаниас өгсөн чиглэлийн дагуу цуглуулах, ашиглах, нээлттэй болгох, боловсруулах;
- (b) Компанийн хувийн мэдээллийг мэдээллийн нээлттэй байдлыг холбогдох хууль тогтоомжоор шаардаагүй бол, компанийн бичгээр үйлдсэн хүсэлт болон зөвшөөрлийг урьдчилан авалгүйгээр бусад этгээдэд задруулахгүй;
- (v) Компанийн хувийн мэдээллийн нээлттэй байдал холбогдох хууль тогтоомжоор шаардагдсан ба шаардагдаж болох талаар Компанид нэн даруй мэдэгдэх;
- (г) Компанийн хувийн мэдээллийг техникийн, биет болоод зохион байгуулалтын хувд найдвартай газар байршуулан зөвшөөрөлгүй авах, алдагдах, устгагдах, буруу хэрэглэх, өөрчлөлт оруулах, задруулах зэргээс сэргийлэх;
- (д) Компанийн хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах, нээлттэй болгох, боловсруулах ажиллагаа нь хуулийн дагуу, шударга байдлаар ашиглах байгаа гэдгийг баталгаажуулахын тулд бүхий л шаардлагатай арга хэмжээг авсан байх ба түүнчлэн Компани нь өөрийн хувийн мэдээллийг хэрхэн хамгаалдаг хэлбэрээр нэгэн адил ажиллах тухай шаардлагыг Нийлүүлэгчид тавьж болох; ба
- (e) Хэрэв Компаниас тийнхүү шаардлага тавьсан бол Хувийн мэдээллийг шилжүүлэхэд Европын Холбооны загвар гэрээг ашиглан хийнэ.
  - (i) Компани болон Рио Тинто Группийн бусад аливаа гишүүдтэй; эсхүл
  - (ii) Нийлүүлэгчийн бүх болон аль нэг харилцагч компани эсхүл туслан гүйцэтгэгчид нартай

Тодруулбал, хэрэв Компани нь глобал өгөгдлийн нууцлалын үүргийг мөрдөх зорилгоор шаардлагатай буюу тохиромжтой гэж үзсэн тохиолдолд уг хүсэлтийг гаргаж болно.

### 54.4 Хувь хүний гаргасан гомдол

- (a) Хэрэв Нийлүүлэгчийг (эсхүл түүний аливаа ажилтныг) Гэрээ гүйцэтгэхдээ тухайн хүний Хувийн мэдээллийг буруугаар ашигласан гэсэн үндэслэл бүхий гомдлыг хувь хүн Компанид гаргасан бол, Компани нь Нийлүүлэгчид гомдлын талаар мэдээллийг тухайн гомдлыг шийдвэрлэх бүх боломжит арга хэмжээ авахад нь хүрэлцээтэй байхаар дэлгэрэнгүй дурдсан мэдэгдлийг нэн даруй хүргүүлнэ. Нийлүүлэгч нь уг гомдлыг хэрхэн барагдуулж шийдвэрлэсэн талаар аль болох хурдан хугацаанд буюу аль ч тохиолдолд Нийлүүлэгч мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хойш долоо (7) хоногийн дотор Компанид бичгээр хариу өгөх ёстой. Уг хариунд Нийлүүлэгчийн гомдлыг шийдвэрлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг дурдах ёстой ба хэрэв шаардлагатай бол цаашид мэдээллийг буруугаар ашиглах явдлыг багасгах алхмын талаар мөн дурдана.
- (b) Хэрэв хувь хүн Нийлүүлэгчид Нийлүүлэгч (эвсэл түүний ажилтан) хувь хүний өөрийнх нь компанийн хувийн мэдээллийг буруугаар ашиглаж байгаа талаар гомдол гаргасан тохиолдолд Нийлүүлэгч нь дор дурьдсан үүргийг хүлээнэ. Үүнд:
  - (i) тухайн гомдлын талаар Компанид нэн даруй мэдээлэх;
  - (ii) тухайн гомдол гарсан компанийн хувийн мэдээллээр компанийг хангах;
  - (iii) уг гомдлыг хэрхэн барагдуулж шийдвэрлэсэн болон цаашид мэдээллийг буруугаар ашиглах явдлыг багасгах талаар авах арга хэмжээг дурдаж Компанид бичгээр мэдэгдэнэ.

### 54.5 Нийлүүлэгчийн нөхөн төлбөр

35-д заасныг үл хязгаарлан энэхүү 54-р заалтыг Нийлүүлэгчи бодит болон болзошгүй зөрчсөний улмаас үүдэх аливаа хариуцлагыг Нийлүүлэгч нь Компанид нөхөн төлж хохиролгүй болгох ёстой.

#### 54.6 Гэрээг цуцлах

Гэрээг дуусгавар болгосон эсхүл цуцласан тохиолдолд Нийлүүлэгч нь Компаниас өгсөн удирдамжийн дагуу Компанийн хувийн мэдээллийг буцааж өгөх, устгах, хадгалах ёстой.

#### 55. Эрхээсээ татгалзах

Тал бүр аливаа эрх, эрх мэдэл эсвэл эрх зүйн арга хэрэгслийг хэрэгжүүлээгүй эсхүл хожимдож хэрэгжүүлсэн нь эрхээсээ татгалзсан тооцогдохгүй. Аливаа эрх, эрх мэдэл, эрх зүйн арга хэрэгслээ дангаар нь эсвэл хэсэгчлэн хэрэгжүүлэх нь бусад эсвэл цаашид эрх, эрх мэдэл, эрх зүйн арга хэрэгслээ хэрэгжүүлэхэд саад учруулахгүй болно. Татгалзал нь түүнийг баталгаажуулж буй Тал бичгээр гаргаагүй тохиолдолд нь хүчингүй байна.

#### 56. Нэмэлт баталгаа

Тал тус бүр Гэрээний заалтуудыг болон төлөвлөгдсөн хэлцэлүүдийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай эсхүл хэрэгцээтэй байж болох бүхийл зүйлсийг хийх буюу акт, тоног төхөөрөмж, шилжүүлэг болон бусад баримт бичиг зэргийг үйлдэхийг хүлээн зөвшөөрөв.

#### 57. Гэрээний тусгаар байдал

##### 57.1 Гэрээний тусгаар байдал

Аль ч эрх зүйн тогтолцооны хувьд хориглосон эсхүл хэрэгжих боломжгүй гэрээний аливаа заалт нь тухайн эрх зүйн тогтолцоонд хориглосон эсхүл хэрэгжих боломжгүй хэмжээгээр хүчингүй байна. Энэ нь тухайн Гэрээний бусад үлдсэн заалтуудыг хүчингүй болгохгүй бөгөөд аль ч эрх зүйн тогтолцооны хувьд тэдгээрийн хүчин төгөлдөр, хэрэгжих боломжийг хөндөхгүй болно.

##### 57.2 Сайн санаагаар хэлэлцээ хийх

Гэрээний заалт нь хориглогдсон эсхүл хэрэгжих боломжгүй байгаа тохиолдолд Талууд тухайн хүчин төгөлдөр бус заалтыг хэрэглэгдэх хууль тогтоомжид нийцсэн, талуудын анхны хүсэл сонирхолд аль болох ойр байх заалтаар солих тухай хэлэлцээг итгэлцлийн журмаар хийх шаардлагатай бөгөөд гэрээнд зохих нэмэлт өөрчлөлтийг (хэрэв байгаа бол) оруулна.

#### 58. Удирдлага болгох хууль

##### 58.1 Удирдлага болгох хууль

Энэхүү гэрээнд баримтлах зарчмууд болон түүнчлэн зөрчилдөөний хэм хэмжээг хэрэглэхгүйгээр Англи ба Уэльсийн хууль тогтоомжийг удирдлага болгоно. 41-р заалтын дагуу зөвшөөрөгдсөн шүүхэд нэхэмжлэл гаргаж болох аливаа асуудлаар Талууд Сингапур улсын эрх зүйн тогтолцоонд үйлчилж буй аль Шүүхийн онцгой бус харьяалалд нэхэмжлэл гаргана.

##### 58.2 НҮБ-ийн конвенц – Олон улсын бараа худалдах, худалдан авах

НҮБ-ийн Олон улсын бараа худалдах, худалдан авах хэлэлцээрийн конвенц болон бусад төсөөтэй хэрэглэгдэх хуулийг энд Хэрэглэгдэх хуулиудын зөвшөөрөгдөх хамгийн дээд хэмжээгээр татгалзаж байгаа болно.

##### 58.3 Гуравдагч талын эрх

Рио Тинто группийн гишүүд эсхүл нөхөн төлбөрийн нөхцөлийн дагуу нэхэмжлэх гаргаж буй Компанийн ажилтантай холбоотойгоос бусад тохиолдолд Гэрээний тал биш аливаа этгээд нь Гэрээний (Гуравдагч талын эрх) тухай 1999 оны хуулийн дагуу ямарваа нэгэн эрхгүй байна.

#### 59. Гэрээний нөхцөлийн хүчинтэй байдал

(а) Дараахь заалтууд дахь нөхцөл нь гэрээ дуусгавар болох эсхүл цуцлагдсан ч хүчинтэй хэвээр байна. Үүнд: 7 (Нийлүүлэгчийн баталгаа), 14 (Татвар), 17 (Төлбөрөөс хасаж тооцох), 33 (Даатгал), 35 (Нөхөн төлбөр), 41 (Маргаан шийдвэрлэх), 42 (Нууцлал), 44 (Үйлчилгээ дэх оюуны өмчийн эрх) болон 54 (Хувь хүний мэдээллийг хамгаалах) зүйлүүд.

(б) Энэхүү гэрээн дэх нөхөн төлбөр бүр нь Нийлүүлэгчийн бусад үүргээс тусдаа, бие даасан үргэлжилсэн үүрэг бөгөөд Гэрээг цуцлах эсхүл дуусгавар болсон ч хүчинтэй хэвээр байна..

#### 60. Гэрээний хувь

Энэхүү Гэрээ нь хэд хэдэн хувиас бүрдэж болох бөгөөд тус бүр нэг буюу түүнээс дээш Талуудын гарын үсэг зурагдсан байна. Хэрэв тийм бол тухайн гарын үсэг зурагдсан хувиудыг нэг баримт бичиг гэж тооцох ба сүүлийн хувийг үйлдсэн өдөр нь энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр байна.

**61. Гэрээний хэл**

---

Энэхүү Гэрээг Англи хэл дээр боловсруулсан бөгөөд аливаа орчуулгыг Англи хэлнээс хийсэн болно. Гэрээний агуулга, утга санаа болон тайлбарын талаар аливаа зөрчилдөөн эсхүл асуулт гарсан тохиолдолд Англи хэл дээрх заалтууд давамгайлна.